МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

# МОНГОЛ УЛСЫН 2026-2030 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

www.invest.gov.mn

## Төсвийн тухай хууль

10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

10.1.Засгийн газар төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.15.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлах

28 дугаар зүйл.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт

28.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.

28.2.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг дараах журмаар боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

28.2.1.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг санал боловсруулах бүх шатанд олон нийтээр хэлэлцүүлсэн байх;

28.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно:

28.3.1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого;

28.3.2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж;

28.3.3.нийгмийн ач холбогдол;

28.3.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл;

28.3.5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт;

28.3.8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ;

28.3.10.болзошгүй өр төлбөр болон санхүүгийн бусад эрсдэлийн үнэлгээ.

28.3.11.Өрийн удирдлагын тухай хууль болон Стратегийн баримт бичигт заасан шаардлага. /2015.02.18/

# Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.6.“Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг; /2021.12.16/

4.1.12."Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг; /2021.12.16/

6 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл

6.7.Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

6.7.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.1.в.тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргах. /2021.12.16/

9 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг

9.3.Засгийн газрын бүрэн эрх:

9.3.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам батлах; /2021.12.16/

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

ХБТТУтХ 9.3.7. Засгийн газар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам батлах

## » ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ САНАЛАА БОЛОВСРУУЛАХ

Төсөлд тавигдах шаардлага ▶▶ Төсөвт өртөг: 30 ТЭРБУМ ₮ | ТЭЗҮ/зураг төсөв хийгдсэн | Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн

## Тавигдах шаардлага

- » Эрэлт хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн
- » Нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашигтай
- » Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартын шаардлагыг хангасан
- » Салбарын хөгжилд үзүүлэх нөлөөллийг тооцсон
- » Санхүү эдийн засгийн шинжилгээ хийгдсэн
- » Эх үүсвэрийг тодорхойлсон
- » Төслийн төлөвлөгөө боловсруулагдсан
- » 1 жилээс дээш хугацаанд хэрэгжих

## » ТӨСЛИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ

ЭЗХЯ

1. Чанар, иж бүрдэл шалгах
2. Урьдчилсан үнэлгээ
3. Иж бүрэн үнэлгээ

**Иж бүрэн үнэлгээ**

| | |
|---|---|
| Ерөнхий шалгуур | 2 |
| Дэд шалгуур | 8 |
| Үзүүлэлт | 42 |



# МОНГОЛ УЛСЫН 2026–2030 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын 2026–2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын нийт 188 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, техник эдийн засгийн үндэслэл, бэлэн байдал хангагдсан 66.6 их наяд төгрөг бүхий 87 төсөл, арга хэмжээг 2026–2030 онд 55.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 72 төсөл, 65.4 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын шийдвэрийг баталгаажуулах шаардлагатай байна. Эдгээр нь урьдчилсан судалгаа, ТЭЗҮ хийгдсэн боловч хөрөнгө оруулалтын шийдвэр гараагүй төслүүд юм.

Техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл боловсруулах шаардлагатай 29 төслийн бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөсөн.




Зураг 1. Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

# САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ТӨСӨЛ

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 87 төслийг хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, эдийн засгийн бүтцийн шинэчлэл, бүсчилсэн хөгжил, ногоон хөгжил болон засаглал гэсэн үндсэн 7 тэргүүлэх чиглэлийн тодорхойлсон үр дүнгүүдэд бодитой хувь нэмэр оруулдаг байхаар ач холбогдлыг нь тодорхойлон эрэмбэлсэн

Санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн 87 төслийг хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, эдийн засгийн бүтцийн шинэчлэл, бүсчилсэн хөгжил, ногоон хөгжил болон засаглал гэсэн үндсэн тэргүүлэх чиглэлийн хүрээнд авч үзэн, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн зорилтуудад үзүүлэх бодит хувь нэмэр, ач холбогдлоор нь үнэлж, эрэмбэлсэн. Ийнхүү төслүүдийг чиглэл тус бүрийн нөлөөллийн түвшинг тодорхойлсноор хөрөнгө оруулалт нь бодлогын зорилт, хөгжлийн үр дүнтэй уялдсан байдлаар хэрэгжих нөхцөл бүрдэнэ.




*Зураг 2. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, тэргүүлэх чиглэлээр*

Хүснэгт 1. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл 2026-2030 онд санхүүжих дүн, тэргүүлэх чиглэлээр

| Бүлгийн нэр | Төслийн тоо | Нийт төсөвт өртөг | 2026-2030 онд санхүүжих дүн | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 | Үүнээс: 2026-2030 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХҮНИЙ ХӨГЖИЛ | 14 | 5,458,260.70 | 4,614,670.80 | 423,183.50 | 1,379,799.93 | 1,120,687.84 | 868,432.11 | 822,567.41 | 8.36% |
| ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ | 19 | 23,461,588.82 | 18,706,705.18 | 3,873,281.15 | 5,540,470.88 | 5,337,510.99 | 2,302,869.15 | 1,652,573.01 | 33.89% |
| ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ | 16 | 18,795,734.89 | 15,911,758.39 | 2,814,847.68 | 4,454,120.23 | 5,214,401.60 | 2,045,555.34 | 1,382,833.55 | 28.83% |
| БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ | 34 | 16,367,668.91 | 13,624,380.24 | 2,923,700.07 | 2,613,548.54 | 2,760,897.10 | 3,297,293.67 | 2,028,940.87 | 24.68% |
| НОГООН ХӨГЖИЛ | 1 | 406,000.00 | 356,000.00 | 118,666.67 | 118,666.67 | 118,666.67 | 0.00 | 0.00 | 0.64% |
| ЗАСАГЛАЛ | 3 | 2,101,010.00 | 1,981,840.00 | 187,224.81 | 307,536.13 | 307,536.13 | 589,771.47 | 589,771.47 | 3.59% |
| **ДҮН** | **87** | **66,590,263.33** | **55,195,354.62** | **10,340,903.88** | **14,414,142.38** | **14,859,700.33** | **9,103,921.74** | **6,476,686.29** | **100%** |

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 87 төслийг 2026-2030 онд 55.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Санхүүжилтийн эх үүсвэр, төслийн тоог доорх графикаар харуулав.

# Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн эх үүсвэр, санхүүжилтийн хуваарь




Зураг 3. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, эх үүсвэрээр

Нийт төслийн 44.8 хувь буюу 39 төслийг улс, орон нутгийн төсвөөр, 28.7 хувь буюу 25 төслийг гадаадын зээл, тусламжаар, 16.1 хувь буюу 14 төслийг шууд хөрөнгө оруулалтаар, 3.4 хувь буюу 3 төслийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 2.3 хувь буюу 2 төслийг Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасаар, 3.4 хувь буюу 3 төслийг холимог эх үүсвэрээр, 1.1 хувь буюу 1 төслийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийг 2026-2030 онд санхүүжих дүн, санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалаар нь авч үзвэл:




Зураг 4. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн санхүүжилтийн хуваарь, эх үүсвэрийн бүтцээр

## Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн санхүүжилтийн хуваарь, төсвийн хүрээ

Нийт санхүүжилт 2026 онд 10.3 их наяд төгрөг байгаа бол Газрын тос боловсруулах үйлдвэр, 2025 онд эхлүүлсэн авто зам, бусад томоохон бүтээн байгуулалтын ажлууд эхлүүлэх, хэрэгжиж эхэлсэн зарим бүтээн байгуулалтын ажлуудыг 2028 онд багтаан барьж ашиглалтад оруулахтай холбогдуулан гадаадын зээл, улс, орон нутгийн зардал өсч улмаар 2027–2028 онд өсгөж 14.8 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн.

Харин 2029 оноос эхлэн санхүүжилтийн хэмжээ буурч, 2030 онд 6.5 их наяд төгрөг болж санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй төслүүдийг хэрэгжүүлэх төсвийн орон зай үүснэ.

Эх үүсвэрийн бүтцийн хувьд, нийт санхүүжилтийн гол хэсгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл ба тусламж эзэлж байна. Үүнээс гадна хувийн хэвшлийн шууд хөрөнгө оруулалт болон төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэрээр хэрэгжих төслүүд 46.2 хувийг бүрдүүлж байна.

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн санхүүжилтийн хуваарийг Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.9 дахь заалтын дагуу 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулсан.




*Зураг 5. 2026 оны төсвийн хүрээ, 2027, 2028 оны төсвийн төсөөлөл, улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, ЗГ-ын гадаад, дотоод үнэт цаас (их наяд.₮)*

# САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ТӨСЛҮҮД, ХАРИУЦАГЧ ЯАМД

Хүснэгт 2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2026-2030 онд санхүүжих дүн, яамдаар

| Төсөл хэрэгжүүлэгч яам | Төслийн тоо | 2026-2030 онд санхүүжих дүн /сая төгрөг/ | Нийт дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам | 8 | 15,380,801.75 | 27.87% |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам | 1 | 356,000.00 | 0.64% |
| Батлан хамгаалах яам | 1 | 1,602,600.00 | 2.90% |
| Боловсролын яам | 2 | 2,244,638.69 | 4.07% |
| Зам тээврийн яам | 27 | 5,297,538.70 | 9.60% |
| Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 11 | 11,289,426.43 | 20.45% |
| Соёл, спорт, аялал жуулчлалын яам | 4 | 705,124.20 | 1.28% |
| Сангийн яам | 3 | 692,419.30 | 1.25% |
| Хот байгуулалт, орон сууцжуулалтын яам | 1 | 36,600.00 | 0.07% |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 5 | 349,381.00 | 0.63% |
| Шадар сайд (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн) | 2 | 379,240.00 | 0.69% |
| Эдийн засаг, хөгжлийн яам | 2 | 1,850,847.34 | 3.35% |
| Эрүүл мэндийн яам | 7 | 1,504,243.91 | 2.73% |
| Эрчим хүчний яам | 13 | 13,506,493.29 | 24.47% |
| **Дүн** | **87** | **55,195,354.62** | **100%** |

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний 2026-2030 онд санхүүжих дүн 55.2 их наяд төгрөг бөгөөд үүнээс хамгийн их санхүүжилт хуваарилагдсан салбарууд дараах байдалтай байна.

Хамгийн өндөр санхүүжилттэй нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бөгөөд нийт 15.4 их наяд төгрөг буюу 27.9 хувь. Үүний дараа Эрчим хүчний яам 13.5 их наяд төгрөг буюу 24.5 хувь, мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 11.3 их наяд төгрөг буюу 20.5 хувь байна.

Харин Зам, тээврийн яам 5.3 их наяд төгрөг буюу 9.6 хувь, Боловсролын яам 2.2 их наяд төгрөг буюу 4.1 хувь, Эдийн засаг, хөгжлийн яам 1.9 их наяд төгрөг 3.3 хувь байна.

Эрүүл мэнд, Батлан хамгаалах, Соёл, Сангийн, Хүнс, хөдөө аж ахуй яам харьцангуй бага буюу тус бүр 0.6–3 хувийн санхүүжилтийг эзэлж байгаа бөгөөд энэ нь салбарын онцлогоос хамааралтай.

Нийт дүнгээр авч үзвэл, 2026–2030 онд хэрэгжих улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн ихэнх нь аж үйлдвэр, эрчим хүч, нийслэлийн дэд бүтэц болон зам, тээврийн салбарт төвлөрч байгаа нь эдийн засгийн өсөлт, бүсчилсэн хөгжил, хүний хөгжлийн бодлогыг дэмжих зорилготой юм.

# САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ТӨСЛҮҮД, БҮСЭЭР

Хүснэгт 3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2026-2030 онд санхүүжих дүн, бүсээр

| Бүс | Төслийн тоо | Нийт /тэрбум төгрөг/ | Санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/ | Санхүүжилтийн гүйцэтгэл 2026-2030 | Төслийн тоо /хувиар/ | 2026-2030 /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|
| Улсын хэмжээнд | 14 | 8,496.5 | 496.9 | 6,664.6 | 16.1% | 12.1% |
| Улаанбаатар | 22 | 13,948.9 | 1,593.9 | 12,355.0 | 25.3% | 22.4% |
| Баруун бүс | 12 | 2,506.9 | 383.6 | 2,123.8 | 13.8% | 3.8% |
| Баруун, Зүүн бүс | 1 | 364.6 | 8.4 | 356.2 | 1.1% | 0.6% |
| Говийн бүс | 18 | 28,020.0 | 4,447.7 | 23,301.5 | 20.7% | 42.2% |
| Говь, Хангайн бүс | 1 | 874.7 | 62.3 | 541.6 | 1.1% | 1.0% |
| Зүүн бүс | 7 | 1,725.3 | 242.9 | 1,482.3 | 8.0% | 2.7% |
| Төвийн бүс | 8 | 5,669.0 | 2,213.9 | 3,455.1 | 9.2% | 6.3% |
| Говийн бүс | 4 | 1,056.0 | 120.0 | 665.2 | 4.6% | 1.2% |
| Хойд бүс | 4 | 4,593.4 | 182.5 | 4,410.4 | 4.6% | 8.0% |
| Хойд, Говийн бүс | 1 | 1,672.9 | - | 1,672.9 | 1.1% | 3.0% |
| **ДҮН** | **87** | **66,590.2** | **9,611.3** | **55,195.3** | **100%** | **100%** |

Говийн бүс хамгийн өндөр буюу 23.3 их наяд төгрөг буюу 42.2 хувийн санхүүжилттэй, 18 төсөл хэрэгжихээр төлөвлөгдсөн. Энэ нь уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний томоохон төслүүдийг эхлүүлж, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг хийх зорилготой.

Улаанбаатар хот 12.4 их наяд төгрөг буюу 22.4 хувь, 22 төсөл хэрэгжихээр тусгагдсан. Улаанбаатар хотын түгжрэл, гэр хорооллын дахин төлөвлөлт, нийтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн.

Улсын хэмжээнд хэрэгжих төсөл 14 байгаа бөгөөд нийт 6.7 их наяд төгрөг буюу 12.1 хуьийн санхүүжилттэй байна. Эдгээр нь бүс, орон нутгийн дэд бүтцийг бий болгож, хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой.

Баруун бүс 2.1 их наяд төгрөг буюу 3.9 хувь, Төвийн бүс 1.4 их наяд төгрөг буюу 2.6 хувь, Зүүн бүс 1.5 их наяд төгрөг буюу 2.7 хувь тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын дийлэнх нь Говийн болон нийслэлийн бүсэд төвлөрсөн бөгөөд эдийн засгийн тулгуур салбарууд болох уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн хөгжилд чиглэсэн.

# 1. ХҮНИЙ ХӨГЖИЛ

# ХҮНИЙ ХӨГЖИЛ

**Өнөөгийн байдал**

Хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарууд нь Монгол Улсын үндэсний өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжил, аюулгүй байдал, бүрэн эрхт байдлын суурь тулгуур юм. Эдгээр салбар нь иргэдийн амьдралын чанарыг тодорхойлохын зэрэгцээ үйлдвэрлэл, инновацийн өсөлт, эдийн засгийн бүтээмжийн үндэс болж байгаа тул төрөөс нэн тэргүүнд дэмжих шаардлагатай хэвээр байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт хот, хөдөөгийн ялгаа гүнзгийрч, боловсролын чанар, хүртээмжийн тэгш бус байдал үргэлжилж байна. Анги танхимын хэт ачаалал, олон ээлжийн сургалт, дэд бүтцийн стандарт хангалтгүй байдал нь сурагчдын суралцах орчин, багшийн бүтээмжид сөргөөр нөлөөлж байна. 2023 оны байдлаар улсын цэцэрлэгийн 34 хувь нь стандартын шаардлага хангахгүй, ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 76.5 хувьд хүрч, Улаанбаатар хотын 8 сургууль 56 бүлэгт 2,120 сурагч 3 ээлжээр хичээллэж байна. Орон нутгийн сургалтын байгууллагуудын дэд бүтэц, дотуур байрны хүрэлцээ хангалтгүй хэвээр байгаа нь боловсролын тэгш хүртээмжийг хязгаарлаж байна.

Эрүүл мэндийн салбарт өвчлөл, нас баралтын түвшин өндөр, оношилгоо, эмчилгээний хүртээмж сул байна. Монгол Улс хорт хавдрын нас баралтаар дэлхийд тэргүүлж, жил бүр дунджаар 7,200 хүн шинээр өвчилж, 4,500 орчим хүн нас барж байна. Хорт хавдраар нас барсан хүмүүсийн 62 хувь нь оношлогдсоноос хойш нэг жилийн дотор амь насаа алдаж байгаа нь эрт илрүүлэг, эмчилгээний тогтолцоо сул байгааг илтгэнэ. Мөн жил бүр дунджаар 5,800 хүн зүрх судасны өвчнөөр цаг бусаар эндэж, зүрх, бөөр, элэг шилжүүлэн суулгах болон яаралтай тусламжийн чадавх дутмаг хэвээр байна. Орон нутгийн түвшинд мэргэшсэн эмч, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, халдварт өвчний эрт илрүүлэлт, хяналт, тусгаарлалтын дэд бүтэц хангалтгүй байгаа нь цар тахал зэрэг эрсдэлтэй нөхцөлд эрүүл мэндийн тогтолцооны уян хатан байдлыг алдагдуулдаг.

Шинжлэх ухааны салбарын хөгжил сүүлийн жилүүдэд удааширч, хөрөнгө оруулалт, лабораторийн дэд бүтэц, хүний нөөцийн чадавхи хязгаарлагдмал байна. Судалгааны байгууллагуудын уялдаа сул, материаллаг бааз хуучирсан, инновацийг үйлдвэрлэл, эдийн засгийн эргэлтэд нэвтрүүлэх нөхцөл бүрдээгүйгээс судалгааны үр ашиг, бодит нөлөөлөл буурчээ. Шинжлэх ухааны хүрээлэнгүүд олон байршилд тархсан, төвлөрсөн орчин дутмаг байгаа нь хамтын ажиллагаа, судалгааны нэгдмэл чанарыг сааруулж байна.

**Хүрэн үр дүн**

Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухааны үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор нийт 14 төсөл, арга хэмжээг 5.6 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр төслүүд нь боловсрол, эрүүл мэндийн дэд бүтцийг өргөтгөх, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, соёлын орчныг шинэ шатанд гаргах замаар Монгол Улсын “Хүний хөгжил”-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Зүрх, судасны үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын төв-II, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, мөн нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн барилгын төслүүд хэрэгжсэнээр улсын хэмжээнд 1200 гаруй ор бүхий төрөлжсөн болон нэгдсэн эмнэлгүүд шинээр ашиглалтад орно. Үүний үр дүнд өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээг дотооддоо хийх боломж бүрдэж, эрт илрүүлэлт сайжрахын зэрэгцээ зүрх судасны өвчний нас баралт буурах нөхцөл бүрдэнэ. Орон нутгийн түвшинд яаралтай тусламж, мэс заслын үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн тэгш боломж хангагдана.

Боловсролын салбарт улсын хэмжээнд 108 сургууль, 95 цэцэрлэг, 83 дотуур байр баригдана. Үүнээс Улаанбаатарт 84 сургууль, 41 цэцэрлэг, орон нутагт 24 сургууль, 64 цэцэрлэг байгуулахаар төлөвлөсөн. Төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд нийслэлийн сургуулиудын ачаалал 30 хувиар буурч, 118 мянга гаруй хүүхдийн боловсролын шинэ, аюулгүй, хүртээмжтэй орчин бүрдэнэ.

Шинжлэх ухаан, соёлын хүрээнд Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей, Үндэсний урлагийн их театр, Хүүхдийн номын ордон, Хүүхэлдэйн театр, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор зэрэг барилга байгууламжууд баригдана. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор нь олон улсын стандартад нийцсэн, нээлттэй, салбар дундын нэгдсэн лаборатори, жишиг үйлдвэрлэлийн цех, музей, архив, номын сан, хурлын танхим бүхий шинжлэх ухаан, технологи, инновац, танин мэдэхүйн төв болж, 20 гаруй байгууллагын 3300 орчим эрдэмтэн, судлаачийн ажлын орчныг бүрдүүлнэ. Эдгээр байгууламжууд ашиглалтад орсноор шинжлэх ухаан, соёлын салбар эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулж, оюуны хөрөнгө оруулалтыг дэмжих бүтэц бий болно.

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг /сая төгрөг/ | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зүрх, судасны үндэсний төв | 2026-2030 | 125,296.21 | Гадаад зээл | ЭМЯ |
| | | 2026 | 2,297.80 | Гадаад тусламж | |
| 2 | Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв | 2024-2027 | 140,000.00 | Улсын төсөв | ЭМЯ |
| 3 | Халдварт өвчин судлалын үндэсний төв-2 | 2026-2029 | 234,200.00 | Улсын төсөв | ЭМЯ |
| 4 | Хавдар судлалын үндэсний төв-2 | 2026-2028 | 312,000.00 | Улсын төсөв | ЭМЯ |
| 5 | Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 2026-2028 | 169,950.00 | Гадаад зээл | ЭМЯ |
| 6 | Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга /Чингэлтэй дүүрэг, Хан-Уул, Баянзүрх/ | 2026-2028 | 110,000.00 | Улсын төсөв | ЭМЯ |
| | | 2024-2029 | 252,000.00 | Гадаад зээл | ЭМЯ |
| 7 | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын суудлын тоог үе шаттай нэмэгдүүлэх төсөл /улсын хэмжээнд 108 сургууль, Улаанбаатарт 84, орон нутагт 24 сургууль, нийт 95 цэцэрлэг, Улаанбаатарт 41, орон нутагт 64 цэцэрлэг/ | 2026-2030 | 1,233,938.83 | Улсын төсөв | БЯ |
| | | | 468,000.00 | Гадаад зээл | БЯ |
| 8 | Улсын хэмжээнд 83 сургуулийн дотуур байр барих төсөл | 2026-2030 | 542,699.86 | Улсын төсөв | БЯ |
| 9 | Аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл /17 аймгийн нэгдсэн эмнэлгийг сайжруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын барилгыг шинэчлэлж, өргөтгөнө/ | 2026-2036 | 809,325.00 | Гадаад зээл | ЭМЯ |
| 10 | Үндэсний урлагийн их театр барих төсөл | 2027-2029 | 352,000.00 | Гадаад тусламж | ССАЖЗЯ |
| 11 | Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей /Хан-Уул дүүрэг/ | 2020-2027 | 302,200.00 | Улсын төсөв | ССАЖЗЯ |
| 12 | Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр | 2027-2030 | 60,700.00 | Улсын төсөв | ССАЖЗЯ |
| 13 | Монгол, Хятад Улсын Ерөнхийлөгч нарын нэрэмжит спорт цогцолбор | 2026-2030 | 172,464.00 | Гадаад тусламж | СЯ |
| 14 | Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалт | 2020-2027 | 171,189.00 | Улсын төсөв | ЭЗХЯ |

# 01. Зүрх, судасны үндэсний төвийн барилга

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /ЕСБХБ/ **Тусламж** /Люксембург/ | **2030** | **Улаанбаатар, Баянгол дүүрэг** |

| **нийт төсөвт өртөг:** | | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **127.6 тэрбум ₮** | Гадаад зээл 125.3 тэрбум ₮ | - | - | 31.3 тэрбум ₮ | 31.3 тэрбум ₮ | 31.3 тэрбум ₮ | 31.3 тэрбум ₮ |
| | Тусламж 2.3 тэрбум ₮ | - | 2.3 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсын хүн амын дундах зүрх судасны шалтгаант өвчлөл жилээс жилд өсөн нэмэгдэж, улсын нийт хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа бөгөөд жилд дунджаар 5800 гаруй хүн уг өвчний улмаас цаг бусаар эндэж байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, ачааллыг тасралтгүй нэмэгдүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

### Төслийн ач холбогдол:

Зүрх судасны өвчлөлийн эрт илрүүлэг, оношлогоо, эмчилгээг сайжруулснаар 10,000 хүн амд ногдох нас баралтыг одоогийн 17.5-оос 14.0 хүртэл бууруулах боломж бүрдэхэд оршино. Ингэснээр хүн амын амьдралын чанар сайжирч, эрүүл мэндийн тогтолцооны ачаалал багасна.

### Төслийн зорилго, зорилт:

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих, зүрх судасны өвчлөлийг бууруулах, чанартай тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд чиглэх бөгөөд олон улсын стандартад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж бүхий орчин үеийн эмнэлгийн орчин бүрдүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- **ТЭЗҮ, зураг:** "Зүрх Судасны Үндэсний Төв" (ЗСҮТ) байгуулах төслийг Монгол Улсын Засгийн Газар, Люксенбургийн Их Гүнт Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулсан.
- **Барилга байгуулж:** Европын сэргээн босголтын хөгжлийн банктай Зээлийн хэлэлцээр гэрээ хийгдэхээр хүлээгдэж байна.
- **Тоног төхөөрөмж:** Люксенбургийн Их Гүнт Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр 22.5 сая еврогийн буцалтгүй тусламж шийдвэрлэсэн бөгөөд гэрээ зурагдахаар хүлээгдэж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Бүрэн тоног төхөөрөмжтэй, хэвтэн эмчлүүлэх 200 ортой байна.
- Зүрх, судасны тогтолцооны өвчнөөс үүдэлтэй нас баралт 10,000 хүн амд 17.5-оос 14.0 хүртэл буурна.
- Монгол Улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд тооцогддог зүрх, судасны өвчлөл буурах нөхцөл бүрдэнэ.
- Жил бүр 83,680 гаруй иргэнд зүрх, судасны чиглэлээр чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- Олон улсын стандартад нийцсэн зүрх судасны үндэсний төв бий болж, төвлөрсөн тусламж, сургалт, судалгаа хийх орчныг бүрдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 02. Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах төв

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2024** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **140.0 тэрбум ₮** | 73.8 тэрбум ₮ | 43.1 тэрбум ₮ | 23.1 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Нас баралт, өвчлөл өндөртэй зүрх судас, бөөр, элэг зэрэг эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай өвчтөнүүдэд хурдан шуурхай, чанартай тусламж үзүүлэхэд орчин үеийн төв зайлшгүй шаардлагатай болсон.

Төслийн ач холбогдол:

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг эх орондоо чанартай, хүртээмжтэйгээр хийх боломжийг бүрдүүлж, өвчтөний амь насыг аврах, эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг бууруулахад оршино. Мөн мэргэжилтнүүдийг бэлтгэж, судалгаа шинжилгээний орчныг сайжруулснаар үндэсний хэмжээний тусламжийн чанарыг дээшлүүлнэ.

Төслийн зорилго, зорилт:

Эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээг эх орондоо нэвтрүүлж, чанартай, хүртээмжтэй тусламж үзүүлэх үндэсний төв байгуулна. Орчин үеийн барилга, тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжилтэн бэлтгэх, судалгаа, сургалтын орчинг бүрдүүлж, өвчтөний амь насыг аврах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Суурь, үндсэн бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалтын бэлтгэл ажил хийгдэж байна.

- **Төслийн хэрэгжилтийн явц:** 10.9%
- **Гүйцэтгэгч: “**Магнус сентурион констракшн” ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Бүрэн тоног төхөөрөмжтэй, хэвтэн эмчлүүлэх 120 ортой байна.
- Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг эх орond чанартай, хүртээмжтэйгээр үзүүлнэ.
- Жилд үйлчлүүлэх өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ.
- Мэргэжилтэн бэлтгэх, судалгаа, сургалтын орчин сайжирна.
- Үндэсний хэмжээнд эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээг төвлөрүүлэн хөгжүүлнэ.
- 126 авто машины зогсоолтой байна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 03. Халдварт өвчин судлалын үндэсний төв-2

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2026** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2029** | **Төв, Сэргэлэн сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **234.2 тэрбум ₮** | - | 6.32 тэрбум ₮ | 75.96 тэрбум ₮ | 75.96 тэрбум ₮ | 75.96 тэрбум ₮ | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Манай улсад 1952 онд хүний халдварт өвчин анх бүртгэж эхэлснээс хойш өнөөгийн байдлаар нийт 41 төрлийн халдварт өвчин бүртгэгдээд байна. Эдгээрээс улаанбурхан, вирүст хепатит, цусан суулга, тэмбүү, хамуу зэрэг 22 өвчин буюу 53.7 хувь нь антропонозын халдвар, бруцеллёз, боом, галзуу зэрэг 19 өвчин буюу 46.3 хувь нь зоонозын халдвар эзэлж байна.

#### Төслийн ач холбогдол:

Халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлж, хянах, тусгаарлах, эмчлэх чадавх сайжрахаас гадна тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, халдварт өвчний үед эрүүл мэндийн тогтолцооны ачаалал буурна. Судалгаа шинжилгээ, хариу арга хэмжээний чадавх олон улсын түвшинд хүрч, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх суурь бүрдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлж, хянах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Халдварт өвчний гаралтыг 30 хувиар бууруулах, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, олон улсын жишигт нийцсэн оношилгоо, тусгаарлалт, судалгааны чадавхтай байгууллага болгон хөгжүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- **ТЭЗҮ, зураг төсөв**: 100%
- **Дэд бүтцийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл:** 40%
- Төслийн төлөвлөлтийн хувьд нийт талбай болох 20 га эдэлбэр газрын 26,992.77м2 талбайд барилгажилт хийхээр төлөвлөсөн.
- Барилга угсралтын ажил улирлын нөхцөл байдлаас үүдэн түр зогсолт хийсэн байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Халдварт өвчний гаралт 30 хувиар буурна.
- Хэвтэн эмчлүүлэх 554 ор бүхий эмнэлгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
- Хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна.
- Олон улсын шаардлага хангасан оношилгоо, эмчилгээ, судалгааны орчин бүрдэнэ.
- 978 ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

# 04. Хавдар судлалын үндэсний төв-2

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **312.0 тэрбум ₮** | - | 40.52 тэрбум ₮ | 135.74 тэрбум ₮ | 135.74 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улс ДЭМБ-ын 2022 оны статистикт хорт хавдрын нас баралтаар тэргүүлж, жилд 7,244 хүн шинээр өвчилж, 4,556 хүн нас барж байна. 5 хүн тутмын 1 нь хавдраар нас барж, нас барсан хүмүүсийн 62% нь оношлогдсоноос хойш 1 жил хүрэхгүй хугацаанд амьсгал хурааж байна.

### Төслийн ач холбогдол:

Олон улсын жишигт нийцсэн төв азийн хавдар судлалын жишиг төвийг байгуулж олон улсын үйлчлүүлэгч нарыг татан, эмчлэх байдлаар Монгол Улсын төсөвт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтойгоос гадна дотоодын болон гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулах олон улсын жишигт нийцсэн сургалтын төв байгуулагдана.

### Төслийн зорилго, зорилт:

Олон улсын жишигт нийцсэн хавдрын оношилгоо, эмчилгээний цогц тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх чадамж бүхий Үндэсний төв бий болно.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон.
- **Төслийн зураг төслийн ажлын гүйцэтгэл:** 70%
- **Зураг төслийн гүйцэтгэгч: "**Бодь пропертийз" ХХК, "Төгс Гранд констракшн" ХХК түншлэл

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Хэвтэн эмчлүүлэх 600 ор бүхий эмнэлгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
- Хавдрын дэвшилтэт технологийн үр шимийг Монгол хүн эх орондоо тэгш, хүртээмжтэй, чанартай хүлээн авах боломжтой болно.
- Олон улсын шаардлага хангасан оношилгоо, эмчилгээ, судалгааны орчин бүрдэнэ.
- Нийт 1500 орчим эмнэлгийн ажилчдыг ажлын байраар хангана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 05. Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2026** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /ЕСБХБ/ | **2028** | **Дархан-Уул, Дархан сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **169.95 тэрбум ₮** | - | 20.94 тэрбум ₮ | 50.0 тэрбум ₮ | 99.01 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Одоогийн аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хүчин чадал нь 1980-аад онд баригдсан, хуучирсан бөгөөд орчин үеийн оношилгоо, эмчилгээний шаардлагыг бүрэн хангахгүйд хүрээд байна. Эмнэлгийн барилгын ашиглалтын хугацаа хэтэрсэн, дотор орчны агааржуулалт, ариутгал, халдварын хяналтын нөхцөл хангалтгүй байдалд байна.

#### Төслийн ач холбогдол:

Орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон эмнэлэг нь зүрхний шигдээс, цус харвалт зэрэг хүнд өвчний оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Дарханаас гадна Сэлэнгэ, Булган, Орхон зэрэг аймаг, сумдын иргэд эмнэлгийн тусламж авах боломжтой болно.
Өвчтэй иргэдийн Улаанбаатар руу шилжих шаардлага багасч, иргэдийн эмчилгээний зардал хэмнэгдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Олон улсын стандартад нийцсэн 4 үндсэн барилгаас бүрдэх, 250 хүний ортой, иж бүрэн тоноглогдсон бүсийн жишиг нэгдсэн эмнэлгийг барьж, байгуулна. Үндсэн 4 барилга нь:

- Амбулатори, үзлэг
- Хүүхэд, насанд хүрэгчдийн хэвтэн эмчлүүлэх
- Халдварт өвчин судлал, хэвтэн эмлүүлэх
- Яаралтай түргэн тусламж

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Зүрхний шигдээс, цус харвалт зэрэг хүнд өвчний оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Төвийн бүсийн иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж Улаанбаатарыг зорих шилжих хөдөлгөөнийг бууруулна.
- Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын стандартад нийцүүлнэ.
- Орчин үеийн тоног төхөөрөмжтэй 250 ортой жишиг эмнэлэг байгуулагдана.
- Барилгын үе шатанд болон үйл ажиллагааны үед 1,000 орчим ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийг хэрэгжүүлэх нэгж болон төслийн зөвлөх багийн сонгон шалгаруулалт явц удааширсантай холбоотойгоор тендер зарлах боломжгүйд хүрсэн.

## 06. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга /Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2024** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв, гадаад зээл** /АХБ/ | **2029** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **УТ: 110.0 тэрбум ₮** | - | 20.0 тэрбум ₮ | 50.0 тэрбум ₮ | 40.0 тэрбум ₮ | - | - |
| **ГЗ: 252.0 тэрбум ₮** | - | 106.0 тэрбум ₮ | 100.0 тэрбум ₮ | 40.0 тэрбум ₮ | 6.0 тэрбум ₮ | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүд 1980–1990-ээд онд баригдсан, засварын чанар муу, инженерийн шугам сүлжээ хуучирсан, ариутгал, агааржуулалтын систем хангалтгүй. Тухайлбал Чингэлтэй дүүргийн эмнэлэг, газар болон барилгын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан өргөтгөл хийх боломжгүй нөхцөлд ажиллаж байна.
Зарим дүүргийн эмнэлэг орчин үеийн шаардлагад нийцэхгүй байгаа нь нийслэлийн төв эмнэлгүүдэд ачаалал төвлөрөх гол шалтгаан болж байгаа төдийгүй иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын өсөлт, өвчлөл ихтэй байгаа одоогийн нөхцөл байдалд дүүргийн түвшинд шинэчлэл, өргөтгөл, нэгдсэн менежментийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Дүүргийн эмнэлгүүдийн хүчин чадлыг сайжруулснаар улсын төв эмнэлгүүдэд ирэх ачааллыг бууруулах, иргэдэд эмнэлгийн үйлчилгээгээ шуурхай авахад чухал ач холбогдолтой байна. Улмаар иргэдийн эмчилгээнд зарцуулдаг цаг хугацаа төдийгүй хөрөнгө санхүүгийн хувьд хэмнэлт үүсгэх нөхцөл болох юм. Мөн эмч сувилагчдын ачаалал, ажиллах орчин нөхцөл сайжрах давуу талтай байна.

#### Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь дүүргийн иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин үеийн нэгдсэн эмнэлгийн байгууламжийг бий болгох бөгөөд эмнэлгийн үйлчилгээг төвлөрүүлэх, ачааллыг бууруулах, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах болон мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулахад чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- **Баянзүрх дүүрэг-50%** /Суурийн, газар шорооны, цутгалтын болон хучилтын ажил дууссан. Санхүүжилтгүйн улмаас ажил зогссон/
- **Чингэлтэй дүүрэг-70%** /Суурийн, газар шороо, цутгалтын, хучилтын, дээврийн ажил, агаар соруулах систем дууссан/
- **Хан-Уул дүүрэг-34.14%** /Угсралтын ажил бүрэн дууссан. Дотор засал 20%, гадна хаалга, цонх угсралт 15%, дээвэр угсралтын ажил 30%, гадна бохирын ажил 95%, гадна цэвэр усны ажил 95%, 10кВ-н кабель шугам татах ажил 80%-тай байна/

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Дүүргийн иргэдэд зориулсан орчин үеийн тоног төхөөрөмжтэй нэгдсэн эмнэлгийн байгууламжийг бий болгоно.
- Эмнэлгийн үйлчилгээг төвлөрүүлж, дүүргийн эмнэлгийн ачааллыг бууруулна.
- Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх дүүргийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эмч сувилагчдын ажиллах орчин сайжирч, ачаалал хөнгөрнө.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 07. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын суудлын тоог үе шаттай нэмэгдүүлэх төсөл /улсын хэмжээнд 108 сургууль, Улаанбаатарт 84, орон нутагт 24 сургууль, нийт 95 цэцэрлэг, Улаанбаатарт 41, орон нутагт 64 цэцэрлэг/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Боловсролын яам** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв, Гадаад зээл** /АХБ/ | **2030** | **Улсын хэмжээнд** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **УТ: 1,233,9 тэрбум ₮** | - | 36,9 тэрбум ₮ | 311,7 тэрбум ₮ | 296,7 тэрбум ₮ | 277,0 тэрбум ₮ | 311,4 тэрбум ₮ |
| **ГЗ: 468,0 тэрбум ₮** | | - | 93,6 тэрбум ₮ | 81,9 тэрбум ₮ | 81,9 тэрбум ₮ | 210,6 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Статистик тооцооллоор хүүхдийн тоо 2030 он хүртэл 14.4 хувь буюу 88 мянга орчмоор нэмэгдэх төлөвтэй байна. Нийт сургуулийн гуравны хоёр нь хоёр болон түүнээс дээш ээлжээр хичээллэх эрсдэл бий болно. Иймд 2026 оноос эхлэн нэмэгдсэн хэрэгцээг хангах, бэлтгэл шаардлагатай бөгөөд нийтдээ 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барих хэрэгцээ шаардлага үүсээд байна.

#### Төслийн ач холбогдол:

Шинэ сургууль, цэцэрлэгийн хүчин чадал нэмэгдсэнээр нийслэлийн хэмжээнд 84 сургуулийн нийт 60–70 мянган хүүхэд нэмэлтээр боловсролын үйлчилгээ авах боломж бүрдэх бөгөөд анги дүүргэлт 30 хувиар буурна. Үүнтэй зэрэгцэн орон нутагт шинээр байгуулагдах 32 сургууль, 64 цэцэрлэг нь алслагдсан аймаг, сумдын хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын суудлын тоог үе шаттай нэмэгдүүлнэ.
Сурагчдын анги дүүргэлт, ээлжийн хичээллэлтийг стандартын хэмжээнд байлгана.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Монгол Улсын 2026 оны Улсын төсвийн төсөлд Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт 2 сургууль /640, 960 суудал/, Сонгинохайрхан дүүрэгт 1 сургууль /640 суудал/, Ховд аймгийн Жаргалант суманд 1 сургууль /320 суудал/, Сүхбаатар аймгийн Баруун-Уртад 1 цэцэрлэг /200 ор/, Увс аймгийн Наранбулаг суманд 1 сургууль /75 ор/ -ийг байгуулахаар 36.9 тэрбум төгрөг төсөвлөгдсөн.

### Төслийн бэлэн байдал:

Зураг төсөл /УБ 8, Орон нутаг 12, нэг маягийн зурагтай 35/ Нийт 55

Газрын зөвшөөрөл /УБ хотын 24 байршилд газрын асуудал шийдвэрлэгдсэн. Үүнээс 18 байршил гэр хороололд, 6 байршил хотын төвд/

### Төслийн хүрэх үр дүн:

Улаанбаатар
- Сургууль 84, 85,880 суудал
- Цэцэрлэг 41, 6000 ор

Орон нутаг
- Сургууль 24, 12,260 суудал
- Цэцэрлэг 64, 6,455 ор
- Анги дүүргэлт 30 хувиар буурна.
- Хөдөө орон нутгийн алслагдсан аймаг сумдын хүүхдүүдийн боловсролын хүртээмж нэмэгдэнэ.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Стандартын шаардлага хангасан орчин бүхий ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

## 8. Улсын хэмжээнд 83 сургуулийн дотуур байр барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Боловсролын яам** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **542.7 тэрбум ₮** | - | 10,5 тэрбум ₮ | 133.0 тэрбум ₮ | 133.0 тэрбум ₮ | 133.0 тэрбум ₮ | 133.0 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

- Аймаг, сумдад сурагчдын тоо өссөн ч дотуур байрны тоо нэмэгдээгүй тул хүчин чадал хүрэлцэхгүй байна.
- Одоогийн дотуур байрны барилга байгууламжийн 70 орчим хувь нь 30-с дээш жилийн насжилттай
- Дулаан хангамж, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн чанар хангалтгүй

Төслийн ач холбогдол:

Орон нутгийн сурагчдын боловсролын тэгш боломжийг хангах, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, сургалтын чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой. Мөн алслагдсан бүсийн боловсролын ялгааг бууруулж, ирээдүйн хүний нөөцийн хөгжилд хувь нэмэр оруулна.

Төслийн зорилго, зорилт:

- Хөдөө орон нутгийн сурагчдын сургалтын тэгш боломжийг хангах,
- Боловсролын хүртээмжийг сайжруулах,
- Сургалтын чанарыг дэмжихэд чиглэсэн дотуур байрны шинэчлэл, өргөтгөлийг хэрэгжүүлэх.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- УБ-т 3 дотуур байр
  - 360 ор
- Орон нутагт 80 дотуур байр
  - 10,390 ор

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Стандартын шаардлага хангасан орчин бүхий ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Дотуур байрын барилга, 150 ор /Төв, Зуунмод сум/
- Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/
- Дотуур байрын барилга, 80 ор /Дорнод, Булган сум/

## 9. Аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл /17 аймгийн нэгдсэн эмнэлгийг сайжруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын барилгыг шинэчлэлж, өргөтгөнө/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрүүл мэндийн яам** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2036** | **Улсын хэмжээнд** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **809.3 тэрбум ₮** | - | - | 20.0 тэрбум ₮ | 20.0 тэрбум ₮ | 96.1 тэрбум ₮ | 96.1 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсын нийт нас баралтын 68% нь эмнэлгийн орчноос гадуур тохиолдож байгаа бөгөөд хөдөө орон нутгийн нас баралтын түвшин 79% хүрч, олон улсын жишгээс хамаагүй өндөр байгаатай холбоотойгоор орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг яаралтай хүртээмжтэй байдлаар авах боломжийг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

#### Төслийн ач холбогдол:

Төслийг хэрэгжүүлснээр иргэд орон нутагтаа яаралтай болон нарийн мэргэжлийн тусламж авах боломж нэмэгдэж, эмчилгээний үр дүн дээшилнэ. Мөн эрүүл мэндийн байгууллагын чадавх бэхжиж, бүс нутгийн эрүүл мэндийн тэгш байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь улсын хэмжээнд яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг өргөжүүлэн шинэчлэх, түргэн тусламжийн автомашиныг сайжруулах, стандартчилсан протокол нэвтрүүлэх замаар таван жилийн хугацаанд урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтыг 26%-иар бууруулахад оршино.
Ийнхүү хэрэгжүүлснээр хот, хөдөөгийн ялгааг арилгаж, олон нийтийн эрүүл мэндийн хямралд тэсвэртэй байдлыг сайжруулан, Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Монгол улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд 4 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.
- 225.0 сая ам.долларын төсөвт өртөг бүхий тус төсөл нь хэрэгжиж эхлэхээр хүлээгдэж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | X |
| ТЭЗҮ | X |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын өрөөний барилга, өргөтгөл болон шинэчлэл хийгдэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй авах боломж бүрдэнэ.
- Яаралтай тусламжийн эмч, сувилагч, түргэн тусламжийн ажилтнуудад зориулсан мэргэшсэн сургалтын хөтөлбөр боловсруулагдаж чадавх сайжирна.
- Хөдөө орон нутгийн яаралтай тусламжийн багуудын телемедицинийн дэмжлэгээр хангагдана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 10. Үндэсний урлагийн их театр барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам** | **2027** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад тусламж** /БНХАУ/ | **2029** | **Улаанбаатар, Хан-Уул дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **352.0 тэрбум ₮** | - | - | 117.3 тэрбум ₮ | 117.3 тэрбум ₮ | 117.3 тэрбум ₮ | |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Үндэсний урлагийн их театр 70 жилийн түүхтэй боловч өөрийн гэсэн байргүй, Улсын драмын эрдмийн театрын байранд үйл ажиллагаа явуулдаг.

#### Төслийн ач холбогдол:

- Үндэсний урлагийг эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын аялал жуулчлалыг нэмэгдүүлнэ.
- Үндэсний болон сонгодог урлагийг хөгжүүлэх, сурталчлах ач холбогдолтой
- Улс, аймаг бүс, Зүүн Азийн орнууд болоод олон улсын шинж чанартай хурал цуглаан, урлаг соёлын үйл ажиллагааг зохион байгуулах ач холбогдолтой.
- Олон улсын чанартай арга хэмжээнүүд зохион байгуулах боломжтой болно.

#### Төслийн зорилго, зорилт:

- Нийт талбай 49500 м2.
- 3 үндсэн танхимаас бүрдэх 1,500, 800, 2,500 суудалтай, нийт 4300 суудал бүхий театрын барилга барина.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- НИТХ-ийн шийдвэрээр Баянзүрх дүүргийн 11, 26-р хорооны нутаг дэвсгэрт “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын эзэмшил газрын 40 га талбайд уг төслийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгож, газрын байршил, талбайн хэмжээ, хилийн заагийн солбицлыг баталж өгсөн. ТЭЗҮ хийгдсэн, зураг, төсвийн судалгааны ажил 50%-ийн явцтай байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

Үндэсний урлагийн их театр:

- Өнөөгийн нөхцөлд театрт жилд дунджаар давхардсан тоогоор 150,000 орчим хүн үйлчлүүлж соёл, урлагийн үзвэр үйлчилгээ авч байгаа.
- Тус төсөл хэрэгжсэнээр үндэсний урлагийг эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын аялал жуулчлалыг нэмэгдүүлэн суудлын тоо 4300-аар буюу 9,6 дахин нэмэгдэнэ.
- Мөн шинээр 400 ажлын байр бий болно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Соёлын боловсролын түвшинг нэмэгдүүлнэ.

## 11. Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей /Хан-Уул дүүрэг/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам** | **2020** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Улаанбаатар, Хан-Уул дүүрэг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтий н гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **302.2 тэрбум ₮** | 78.6 тэрбум ₮ | 51.9 тэрбум ₮ | 171.6 тэрбум ₮ | - | - | |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Улсын зэрэглэлтэй уран бүтээл туурвидаг ердөө 3 байгууллага байгаа ч музейн барилга ашиглалтын хугацаа дуусаж шаардлагад нийцэхгүй болоод байна.
- МХЕГ-аас уг барилгын ашиглалтын хугацаа дууссан, газар хөдлөлтийн үед нурах магадлалтай гэсэн шийдвэр гаргасан.

#### Төслийн ач холбогдол:

- Байгалийн шинжлэх ухааны Үндэсний музейн гол онцлог нь олон улсын чиг хандлагад нийцсэн үзэгч төвтэй боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Байгалийн шинжлэх ухаанаас дамжуулан хүүхэд багачуудад танин мэдэхүйг хөгжүүлэх,
- Эх дэлхий, элгэн нутгаа хайрлан хамгаалах, эх орноороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Шинээр баригдах музей нь нийт үзэгч, жуулчид болон орон нутгийн ард иргэдийн дунд соёлын хүртээмжтэй үйлчилгээг хүргэх, музей- орон нутгийн иргэд хоорондын харилцааг нягтруулах, түүх-соёлын дурсгалуудыг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр үзүүлэн таниулах, эх орныхоо үүх түүхийг сурталчлах зорилготой.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

Барилга угсралтын ажлын гэрээг 2023.08.24-нд байгуулсан.

- **Төслийн гүйцэтгэгч:** “Содон номин констракшн” ХХК
- **Барилгын ажлын явц**: 45% 2025.08.01

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Боловсролын бүх шатны сургалтад музей, түүх, соёлын мэдлэг олгох боловсролын хөтөлбөр боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Олон улсын музейн үйл ажиллагааг өөрийн үйлчилгээнд нэвтрүүлэх, үзэсгэлэн гаргах, сурталчлах арга хэмжээ бодитой болно. Төсөл хэрэгжсэнээр өдөрт 60 хүн, сардаа 1500 жилд 18,000 хүн зөвхөн үзмэр, үзүүлэнгийн танхимаар үйлчлүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Нийгмийн соён гэгээрлийн түвшинг нэмэгдүүлнэ.

## 12. Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам** | **2027** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **60.7 тэрбум ₮** | - | - | 15.2 тэрбум ₮ | 15.2 тэрбум ₮ | 15.2 тэрбум ₮ | 15.1 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Нийт хүн амын 40 гаруй хувийг бүрдүүлж буй хүүхдүүдэд зориулсан номын сан байхгүй.
- Хүүхэлдэйн театр 1959 онд барилга нь нурах аюултай болсноор УДЭТ-ын зүүн талд байрлаж байна. Театрын барилга, хүүхэлдэй урлах өрөө, хүүхэлдэй хадгалах өрөөний талбай хангалтгүй болсон.
- 150 үзэгчийн суудалтай танхимдаа жилд зөвхөн 18 мянга орчим хүүхэд хүлээн авч, үзвэрээ хүргэдэг.

#### Төслийн ач холбогдол:

- Стандартын дагуу баригдсан анхны Хүүхдийн номын сангийн барилга баригдана.
- Олон төрлийн үйлчилгээ, контент, музей, соёлын болон боловсролын бүтээгдэхүүн, дижитал технологид суурилсан бүтээгдэхүүн бий болно.
- Үндэсний ёс заншил, соёлыг хөгжүүлэх, дэлхийн сонгодог уран бүтээлүүдийг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

- Улсын Хүүхэлдэйн театр нь төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, тэр дундаа хүүхэд багачуудад зориулсан тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон Монголын болон дэлхийн сонгодог уран бүтээлүүдийг туурвидгаараа онцлогтой. Театрын шинэ барилга ашиглалтад орсноор нийслэл хотод амьдарч буй 528.200 хүүхэд багачуудад мэргэжлийн түвшний чанартай уран бүтээлээр хүрч үйлчлэх, уран бүтээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх буюу жилд хүрч үйлчлэх үзэгчдийн тоо болон тоглолтын орлогыг 4-5 дахин нэмэгдүүлэх боломж бий болох юм.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Газрын асуудал шийдэгдсэн. /Байршил ЧД-5 хороо Тасганы овоо/
- Урьдчилсан судалгаа, ТЭЗҮ хийгдсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэй номын сан, хүүхэлдэйн театрын 4 давхар бүхий барилга ашиглалтад оруулна.
- 190,000 орчим хэрэглэгчдэд үйлчлэх боломжтой.
- Номын санд сургуулийн өмнөх насныхан болон бага, дунд ангийнханд зориулсан танхим болон өрнө, дорно хэлний 6-7 танхимтай байгуулна.
- Хүүхэлдэйн театр нь нийт 750 суудалтай 2 танхим, 5D танхим, энтертайнмент танхим, хүүхэлдэйн музей бий болно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Нийгмийн соён гэгээрлийн түвшинг нэмэгдүүлнэ.

## 13. Монгол, Хятад Улсын Ерөнхийлөгч нарын нэрэмжит спорт цогцолбор

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Сангийн яам** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад тусламж** /БНХАУ/ | **2030** | **Улаанбаатар, Баянзүрх дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **172.5 тэрбум ₮** | - | 44.2 тэрбум ₮ | 34.5 тэрбум ₮ | 34.5 тэрбум ₮ | 34.5 тэрбум ₮ | 24.7 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Хүн амын өсөлт, суурьшлын бүсийн бүтэцтэй хамааралтайгаар нийгмийн дэд бүтцийн эрэлт үүсэх, биеийн тамир спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэх хандлага жил ирэх өсөж байна. Хүн амын статистик сангийн мэдээллээр УБ нь 2024 оны байдлаар 1.68 сая хүн амтай бөгөөд үүнээс 62 хувийг 15-64 насны иргэд эзэлж байна.
Энэ насны иргэд өдөр бүр дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж эрүүл мэнддээ анхаарах шаардлагатай ч манай улсын хувьд энэхүү нөхцөл байдлыг хангах төвлөрсөн олон улсын стандарт бүхий спорт цогцолбор байхгүй байна.

#### Төслийн ач холбогдол:

Тус төсөл нь нийслэлийн хүн амын өсөлттэй уялдуулан иргэдийн эрүүл мэндийг дэмжих, спортын хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын стандартын спортын орчин бүрдүүлэх замаар нийтийн эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ач холбогдолтой юм.

#### Төслийн зорилго, зорилт:

Бүх насныхныг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх хүсэл сонирхлыг татахуйц спортын олон төрлийг хөгжүүлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн тамирчдыг олон улсын стандартад нийцсэн спорт цогцолборт хичээллэх орчин нөхцөлөөр хангана.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт 4 га газар шийдвэрлэгдсэн.
- Зураг төслийг 2022 онд баталсан.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 58,560 м2 талбайтай 4 давхар барилга байх бөгөөд 19 нэр төрлийн спортын үйл ажиллагаа явуулна
- Нэгэн зэрэг 1385 хүн үйлчлүүлэх боломжтой.
- Олон улсын стандартад нийцсэн, өдөрт 8000-10000 хүнд үйлчлэх хүчин чадалтай.
- Ногоон байгууламж: 3,153.2 м2
- Авто зам талбай: 9,616.6 м2

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.

## 14. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалт

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эдийн засаг, хөгжлийн яам** | **2020** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Улаанбаатар, Баянзүрх дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **171.2 тэрбум ₮** | 114.1 тэрбум ₮ | 40.4 тэрбум ₮ | 16.7 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Одоогийн эрдэм шинжилгээний байгууллагуудын дэд бүтэц хуучирсан, олон улсын шаардлагад нийцэхгүй байгаа нь судалгааны үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Шинжлэх ухааны салбарын хөгжил удаашралтай, инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрэх боломж хязгаарлагдмал байна.

#### Төслийн ач холбогдол:

Олон улсын стандартад нийцсэн лаборатори, технологи дамжуулах төвүүдийг бий болгож, шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд түлхэц өгнө. 20 орчим эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийг нэг дор төвлөрүүлснээр салбар хоорондын хамтын ажиллагаа, нөөцийн үр ашиг нэмэгдэнэ. 3000 орчим эрдэмтэн, судлаачид орчин үеийн нөхцөлд ажиллах боломжтой болж, судалгааны үр дүн сайжирна. Шинжлэх ухааны үр дүнг үйлдвэрлэл, эдийн засагт нэвтрүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь Монгол Улсын шинжлэх ухааны салбарыг олон улсын түвшинд хүргэж, судалгаа, инновацын үр дүнг эдийн засагт нэвтрүүлэхэд оршино. Үүний хүрээнд шинжлэх ухааны хүрээлэнгүүдийг нэгтгэсэн цогцолбор байгуулж, олон улсын стандартад нийцсэн лаборатори, технологи дамжуулах төвийг ашиглалтад оруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Шинжлэх ухааны цогцолборын 7 объектоос 5 барилгын ажил төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж, 27,000 м2 ашиглалтын талбай бүхий лабораторийн 3 гол объект 2025 онд ашиглалтад орно.
- Оффисын зориулалттай 2 барилгын ажлын явц 65%.
- Шинжлэх ухааны цогцолборын барилгыг дахин төлөвлөх, ерөнхий төлөвлөлтийг өөрчлөх, магадлан хийлгэх шаардлага гарсан. Үүнд нэмэлтээр 16.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Олон улсын стандартад нийцсэн лаборатори, технологи дамжуулах төвүүдийг бий болгоно.
- Шинжлэх ухааны үр дүнг үйлдвэрлэл, эдийн засагт нэвтрүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.
- Төрийн өмчийн эрдэм шинжилгээний болон бусад (эрдэм шинжилгээний 20 орчим хүрээлэн, төв) байгууллагын 3000 орчим эрдэмтэн, судлаачид шилжин очиж ажиллах боломж бүрдэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Шинжлэх ухаан, технологи инновацын салбарт ажиллаж буй судлаачдын бүтээлийн чанарыг сайжруулна.

# 2. ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ

# ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн салбарын экспортод тулгуурласан бүтцээр төлөвшиж, үйлдвэрлэлийн төрөлжилт сул, түүхий эдийн хамаарал өндөр хэвээр байна. Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, үүнээс 88 хувь нь боловсруулаагүй түүхий эд, 5 хувь нь хагас боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байгаа нь эдийн засгийн суурь бүтэц хэврэг, зах зээлийн савлагаанд хэт эмзэг байна.

Түүхий эдийн экспортоос хэт хамааралтай байдал нь улсын төсвийн орлого, гадаад валютын урсгал, эдийн засгийн өсөлт гадаад зах зээл дэх нүүрс, зэс, алт, газрын тос зэрэг гол бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд хүчтэй хамаарах нөхцөл бүрдүүлж байна. Үүний улмаас гадаад орчны савлагаа эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэж, төсвийн орлогын хэлбэлзэл нэмэгдэж, улсын өрийн дарамт өсөх хандлагатай байна.

Уул уурхайн салбарт бүтээмж өндөр боловч нэмүү өртөг бага, дотоодын боловсруулах үйлдвэрлэл сул хөгжсөн хэвээр байна. Түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, технологи, дэд бүтэц хангалтгүйгээс экспортын 80 гаруй хувь нь түүхий эд хэлбэрээр гадагшилж байна.

Үйлдвэрлэл, технологийн парк, боловсруулах үйлдвэрүүдийн хөгжил хангалтгүйгээс аж үйлдвэржилтийн суурь дэд бүтэц бүрдээгүй, эрчим хүч, ус, авто болон төмөр замын сүлжээний хүртээмж хязгаарлагдмал байдал үйлдвэржилтийн бүсүүдийг хөгжүүлэхэд саад болж байна. Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох боомтуудын хүчин чадал, логистикийн урсгалын зохион байгуулалт сул, тээвэрлэлтийн хугацаа урт, зардал өндөр байгаа нь экспортын өрсөлдөх чадварыг бууруулж байна.

Нүүрсний экспортын дийлэнх нь Гашуунсухайт боомтоор гарч байгаа нь хил дээр саатал, ачаалал үүсэх, экспортын тасалдал гарах шалтгаан болж байна.

Иймд Монгол Улсын эдийн засгийн бүтцийг шинэчилж, уул уурхайн салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах үйлдвэрлэлийн сүлжээг хөгжүүлэх, тээвэр логистикийн чадавхыг сайжруулах шаардлага нэн тулгамдсан асуудал юм. Эдгээр зорилтын хүрээнд боловсруулах үйлдвэрлэл, хил дамнасан дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндсэн нөхцөл юм.

Монгол улсын эдийн засаг уул уурхайн экспортоос өндөр хамааралтай бөгөөд нийт экспортын 93 хувийг уул уурхайн түүхий эд бүрдүүлж байна. Тухайлбал, нийт экспортын дүнгийн 93 хувь нь боловсруулаагүй түүхий эд, 5 хувь нь хагас боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байна. Иймд манай улсын экспортын орлого, улмаар эдийн засгийн өсөлт болон төсвийн орлого нь гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн савлагаанд хэт өртөмтгий байгаа нь эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж байна.

Иймд, ашигт малтмалын түүхий эд бүтээгдэхүүний боловсруулалтын шатыг нэмж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх томоохон төслүүдийг энэ төлөвлөгөөнд тусгалаа. Тухайлбал:

- Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр
- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн төслүүд
- Уран олборлох үйлдвэрлэлийн төсөл

Түүнчлэн одоо байгаа экспортын бүтээгдэхүүнийг гадаад улс руу тээвэрлэх, логистикийг сайжруулахад экспортын дийлэнх боомт руу чиглэсэн авто зам, төмөр замын хил холболтын төслүүд, боомтуудыг сайжруулах дэд бүтцийн төслүүд хэрэгжүүлж, экспортыг дэмжих бодлогыг баримтлахаар төслийг боловсруулаад байна. Тухайлбал:

Хил дамнасан холболтын төмөр замын төслүүд

Экспортын голлох боомтууд руу чиглэсэн автозамын төслүүд

Хилийн боомтын барилга байгууламж, дэд бүтцийн болон хилийн боомтын үр ашгийг нэмэгдүүлэх төслүүд

Ийнхүү хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэмэгдсэнээр тээвэрлэлтийн хугацаа, зардал буурч, логистикийн найдвартай байдал дээшилж, олон маршруттай болох, ач холбогдолтой.

Экспортын дэд бүтцийн төслүүд ашиглалтад орсноор эдийн засгийн төрөлжилт сайжирч, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээс олох гадаад валютын урсгал нэмэгдэж, бүс нутгийн түвшинд бүтээн байгуулалт, ажлын байр бий болж, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурна.

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг /сая төгрөг/ | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр | 2026-2029 | 2,577,184.56 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 2 | Эрдэнэтийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц | 2026 | 239,740.00 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 3 | Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл | 2017-2028 | 6,013,400.00 | Гадаад зээл | АҮЭБЯ |
| 4 | Газрын тос дамжуулах хоолой | 2023-2026 | 1,319,417.50 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 5 | "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн парк, нүүрс баяжуулах коксын үйлдвэр | 2024-2028 | 487,310.00 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 6 | "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн парк | 2024-2030 | 1,598,700.00 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 7 | "Зөөвч-Овоо төсөл (Уран олборлох, боловсруулах)" | 2026-2030 | 5,925,480.00 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 8 | Хөтөлийн "Цемент шохой" үйлдвэрийн урьдчилсан халаагчтай эргэх зуухны технологитой шохойн үйлдвэрийн өргөтгөл | 2025-2026 | 57,976.89 | Шууд хөрөнгө оруулалт | АҮЭБЯ |
| 9 | "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнасан 19.5 км холболтын төмөр зам | 2026-2028 | 868,589.00 | Шууд хөрөнгө оруулалт | ЗТЯ |
| 10 | "Ханги-Мандал" боомтын хил дамнасан 0.6 км холболтын төмөр зам | 2026-2027 | 30,000.00 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТЯ |
| 11 | "Шивээхүрэн-Сэхээ" боомтын хил дамнасан 6.9 км төмөр зам | 2024-2027 | 30,000.00 | Шууд хөрөнгө оруулалт | ЗТЯ |
| 12 | Өмнөговь аймгийн "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам | 2025-2028 | 457,293.94 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТЯ |
| 13 | Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой, Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл-Уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам | 2026-2028 | 881,119.02 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТЯ |
| 14 | Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам | 2022-2028 | 185,514.90 | Улсын төсөв | ЗТЯ |
| 15 | Өндөрхаан-Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 248.3 км хатуу хучилттай авто зам | 2022-2030 | 311,802.22 | Улсын төсөв | ЗТЯ |
| 16 | Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам | 2026-2030 | 366,850.00 | Улсын төсөв | ЗТЯ |
| 17 | Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам | 2025-2028 | 324,000.00 | Улсын төсөв | ЗТЯ |
| 18 | Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төсөл /Хавирга, Цагааннуур, Булган боомт/ | 2023-2030 | 364,680.00 | Гадаад зээл | СЯ |
| | | | 18,000.00 | Гадаад тусламж | СЯ |
| 19 | Хилийн Цагаандэл-Уул боомтын барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээ, авто зам талбайн барилга | 2026-2028 | 145,735.10 | Гадаад тусламж | СЯ |

# 15. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ боловсруулах, сонгон шалгаруулалтын шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2026** | **Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Эрдэнэс Монгол" ХХК/ | **2029** | **Орхон аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **2.57 их наяд ₮** | - | 644.2 тэрбум ₮ | 644.2 тэрбум ₮ | 644.2 тэрбум ₮ | 644.2 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол улсын экспортын орлогыг жил тутамд 115 орчим сая ам.доллароор нэмэгдүүлэх, цаашид эрэлт, хэрэгцээ нь өсөн нэмэгдэж буй зэс утас, хоолой, эд анги, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрийг дагасан жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, уурхай дагасан Эрдэнэт хотын ирээдүйг эргээр шийдэхэд томоохон хувь нэмэр болох зэрэг эдийн засаг нийгмийн олон чухал ач холбогдолтой.

### Төслийн ач холбогдол:

Монгол Улсын хэмжээнд анх удаа металлурги-химийн үйлдвэр бий болж, дагалдах жижиг дунд үйлдвэрүүд хөгжих нөхцлийг бүрдүүлнэ. Төслийг хэрэгжүүлснээр жилд дунджаар 1.1 тэрбум ам.долларын борлуулалт хийн, улсын болон орон нутгийн төсөвт 13.6 сая ам.долларыг төвлөрүүлэн, 42.02 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллана.

### Төслийн зорилго, зорилт:

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах "уул уурхай–металлурги–химийн үйлдвэрийн цогцолбор" ҮТП-т жилд 124 мянган тн катодын зэс үйлдвэрлэх зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийг барьж байгуулна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийн ТЭЗҮ-г хүлээж авсан ба хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зохион байгуулахаар ажлын даалгаварт санал авч байна.
- Эрдэнэт үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажил 2026 онд багтаан хэрэгжиж дуусах төлөвлөгөөтэй үргэлжилж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр нь жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж 125.5 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38 тонн мөнгө, 182 мянган тонн элементийн хүхэр, 118.2 мянган тонн шингэрүүлсэн хүхрийн хүчил үйлдвэрлэнэ.
- Зэсийн баяжмалын боловсруулалтын шатыг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Аж үйлдвэрийн дэд бүс болох хойд бүсэд 850 гаруй шууд ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

## 16. Эрдэнэтийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2023** | **Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ/ | **2026** | **Орхон аймаг** |

| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **239.74 тэрбум ₮** | 162.0 тэрбум ₮ | 77.7 тэрбум ₮ | - | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол улс нь нийт 46 зэсийн ордын батлагдсан 50 сая.тн орчим зэсийн нөөцтэй байна. Энэхүү нөөцийн үзүүлэлтээр Монгол улс зэсийн нөөцөөр дэлхийд 7-р байрт ордог бөгөөд дэлхийд томоохон тоглогч боломжтой гэж үздэг. Гэвч зэс боловсруулах үйлдвэр байхгүй улмаас баяжмал хэлбэрээр Хятад улсад  жил бүр ойролцоогоор 1.5 сая тн- ыг экспортолж байна.

#### Төслийн ач холбогдол:

Эрдэнэт ҮТП нь зэсийн баяжмалыг боловсруулан нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж Монгол улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой юм. Тус Эрдэнэт ҮТП-д хэрэгжих боломжтой шинэ үйлдвэрүүд ашиглалтад орсноор эдийн засгийн хувьд ач холбогдолтойгоос гадна ажлын байр нэмэгдэж , гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж, урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Уул уурхай, металлурги, химийн үйлдвэрлэл, эрчим хүчний үйлдвэрлэлийн чиглэлээр "Эрдэнэт" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, катодын зэс, элементийн хүхэр, үнэт металл, зэс бүтээгдэхүүн боловсруулах цогцолбор үйлдвэрүүдийг үйлдвэрлэл, технологийн паркийн зарчмаар хөгжүүлэхээр төлөвлөсөн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц (авто зам 70%, төмөр зам 97%, ус хангамж, ариутгах татуургын систем 98%, цахилгаан хангамж 13%)-ийг инженерийн нарийвчилсан зураг төслийн дагуу барьж байгуулах ажлууд хийгдэж байгаа ба үүнд шаардлагатай 68 сая ам долларыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хариуцан ажиллаж байна.

### Төслийн хүрэх үр дүн:

- Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц хэрэгжсэнээр Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, Исэлдсэн хүдрийг өндөр технологиор боловсруулах үйлдвэр, Хүхрийн хүчлийн үйлдвэр, холбогдох үйлдвэрүүдэд шаардлагатай дэд бүтэц болон 62.56 МВт цахилгааны ачааллыг шийдвэрлэнэ.
- Нийт 1200 гаруй ажлын байр бий болгоно.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

# 17. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2017** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /БНЭУ Эксим банк/ | **2028** | **Дорноговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **6.01 их наяд ₮** | 1.03 их наяд ₮ | 207.7 тэрбум ₮ | 2.4 их наяд ₮ | 2.4 их наяд ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Уул уурхай, газар тариалангийн салбарын хувьд гэхэд үйлдвэрлэлийн нийт зардлын 40 орчим хувийг дизель түлшний зардал эзэлж байна.
Манай улс сүүлийн жилүүдэд жилд дунджаар 1,25 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортоор худалдан авч, үүнд жилд 2.0 тэрбум гаруй ам.доллар зарцуулж байна. Эрчим хүчний эх үүсвэр болох нефтийн бүтээгдэхүүнийг импортлоход зарцуулж буй дээрх валютын урсгал нь гадаад худалдааны тэнцэлд сөргөөр нөлөөлж байна.

### Төслийн ач холбогдол:

Газрын тос боловсруулах үйлдвэр нь үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдолтой

### Төслийн зорилго, зорилт:

Газрын тос боловсруулах үйлдвэр нь жилд 1,5 сая.тн газрын тосыг боловсруулж, 1,33 сая.тн олон улсын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэглээний 50-55% (өссөн дүнгээр)-ийг хангаж, импортод зарцуулдаг гадаад валют 2.0 гаруй тэрбум ам.доллараар буурах боломж бүрдэнэ.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- EPC 01: Технологийн бус барилга байгууламж – 100%
- EPC 02: Атмосферийн болон Вакуум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламж, дагалдах, туслах байгууламжууд – 47.3%
- EPC 03: Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц – 34.0%
- EPC 04: Лицензтэй технологийн байгууламжууд – гүйцэтгэл 8.2% ба инженерийн ажил эхэлсэн.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулж, дотоодын хэрэгцээний 50-55 хувийг хангах боломжтой болно.
- Евро- 4,5 стандартын шаардлага хангасан 339,0 мянган тонн автобензин, 824,0 мянган тонн дизель түлш, онгоцны түлш 80,0 мянган тонн, 43,0 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж импортын хэрэглээг бууруулна.
- Шинээр 700 гаруй ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

# 18. Газрын тос дамжуулах хоолой

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2023** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Эрдэнэс Тавантолгой" ХК/ | **2026** | **Дорноговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1,319.4 тэрбум ₮** | 1,239.3 тэрбум ₮ | 80.1 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Манай улс сүүлийн жилүүдэд жилд дунджаар 1,25 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортоор худалдан авч, үүнд жилд 1.0 тэрбум гаруй ам.доллар зарцуулж байна. Эрчим хүчний эх үүсвэр болох нефтийн бүтээгдэхүүнийг импортлоход зарцуулж буй дээрх валютын урсгал нь гадаад худалдааны тэнцэлд сөргөөр нөлөөлж байна. Үйлдвэр бий болсон тохиолдолд зардал бага, найдвартай тээвэрлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

### Төслийн ач холбогдол:

Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тосыг эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтайгаар, байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар, аюулгүй тээвэрлэх.

### Төслийн зорилго, зорилт:

Бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогт нийцүүлэн түүхий тос дамжуулах технологийн оновчтой шийдлийг гаргаж дамжуулах хоолойн үндсэн болон дагалдах барилга байгууламжийг төлөвлөж, барьж байгуулна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- "Газрын тос дамжуулах хоолойн төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх 528 км технологийн зам засвар, арчлалт болон газрын тос дамжуулах хоолой дагасан таван байршилд бүтээн байгуулалт үргэлжилж байна.
- Төслийн хэрэгжилтийн явц: 88.3%
  - Инженерчлэлийн ажил – 93.9%
  - Барилга угсралт – 80.5%
- Гүйцэтгэгч - Norinco International Cooperation (БНХАУ-ын төрийн өмчит компани)

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Монгол Улсын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангаж, шатахууны импортын хамаарлыг бууруулна.
- Түүхий тосны тээвэрлэлтийн зардал, хугацаа багасна.
- 150-200 орчим байнгын ажлын байр бий болно.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

## 19. "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн парк, нүүрс баяжуулах коксын үйлдвэр

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2024** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /“Си Өү Эй Эл” ХХК/ | **2028** | **Дорноговь аймаг** |

| нийт төсөвт өртөг: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **487.3 тэрбум ₮** | 125.9 тэрбум ₮ | 120.4 тэрбум ₮ | 120.4 тэрбум ₮ | 120.4 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Эцсийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргаж эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах

#### Төслийн ач холбогдол:

Улсын төсөвт төвлөрөх татвар хураамжийн хэмжээ нэмэгдэж, үйлдвэрийг дагаж ажлын байрууд нэмэгдэх ба үйлдвэр дагаж орон нутгийн дэд бүтэц сайжирч, улсын төсөвт чухал хувь нэмэр оруулах зэрэг нийгэм эдийн засгийн олон ач холбогдолтой. Түүнчлэн кокс-химийн үйлдвэрээс коксоос гадна дагалдах дайвар бүтээгдэхүүн гарах бөгөөд тэдгээрээс хийн дайвар бүтээгдэхүүн ашиглаж эрчим хүч гарган авах боломжтой.

#### Төслийн зорилго, зорилт:

Гурван сая тонн нүүрс баяжуулах үйлдвэр, 600 мянган тонн коксын үйлдвэр барихаар төлөвлөж байна. Коксын зуухнаас өндөр температурт гаргаж авсан хийгээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж НБҮ болон коксын үйлдвэр, уурхайн ойр орчмын хэрэглэгчдэд түгээхээс гадна илүү гарсан цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системд нийлүүлэх юм.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 100%, паркийн төмөр замын барилга угсралтыг 100%, коксын үйлдвэр, цахилгаан хангамжийн системийн барилга угсралтыг 32%, ус хангамжийн системийн барилга угсралтыг 100%-д хүргээд байгаа бөгөөд металлургийн коксын үйлдвэр, цахилгаан станцыг 2027 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.
- 2025 оны 08 дугаар сарын байдлаар нийт бүтээн байгуулалтын гүйцэтгэл 78.8 хувьтай байна

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг цогц байдлаар хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Гурван сая тонн нүүрс баяжуулах үйлдвэр, 600 мянган тонн коксын үйлдвэр барихаар төлөвлөж байна. Коксын зуухнаас өндөр температурт гаргаж авсан хийгээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж НБҮ болон коксын үйлдвэр, уурхайн ойр орчмын хэрэглэгчдэд түгээхээс гадна илүү гарсан цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системд нийлүүлэх юм.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

## 20. "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн парк

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2024** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Болдтөмөр Ерөө гол" ХХК/ | **2030** | **Дорноговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1.59 их наяд ₮** | 264.9 тэрбум ₮ | 316.4 тэрбум ₮ | 254.3 тэрбум ₮ | 254.3 тэрбум ₮ | 254.3 тэрбум ₮ | 254.3 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Эцсийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргаж эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах

#### Төслийн ач холбогдол:

- Төсөл хэрэгжсэнээр зах зээлд өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг шингэсэн, шинэ төрлийн экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.
- Төмрийн хүдрээ дотооддоо боловсруулдаг болж, түүхийгээр экспортлох хэмжээ буурч, дагалдах үйлдвэрүүд хөгжинө.
- Шинэ төрлийн мэргэжилтэй боловсон хүчин бий болж, орчин үеийн техник, технологийг нутагшуулна.
- Улс орон, нутагт орох татварын орлого нэмэгдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Алтанширээт ҮТП-ийн тогтвортой хөгжил, найдвартай үйл ажиллагааг хангах, байгаль орчинд хал багатай, шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж эрдэс, түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд цахилгаан хангамжийн систем, төмөр замын барилга угсралтыг 100%, ус хангамжийн системийн барилга угсралтыг 15% гүйцэтгээд байна.

- Жилд 600 мянган тонн цутгуурын кокс үйлдвэрлэх хүчин чадалтай коксын үйлдвэрийн бүтээн байгуулалт 40%-н гүйцэтгэлтэй байна

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Төслийн хугацаанд нийт 27.8 сая.тн нүүрс боловсруулж, 6.0 сая.тн цутгуурын кокс, 14.7 сая.тн металлургийн коксын бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулна.
- Төслийн эдийн засгийн тооцоолол нийт 17.8 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олж, 15.7 их наяд төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж нийт 1.5 их наяд төгрөгийн цэвэр ашиг олно.
- 2000 гаруй шууд ажлын байр бий болно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

# 21. "Зөөвч-Овоо төсөл (Уран олборлох, боловсруулах)"

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Орано майнинг" ХХК/ | **2030** | **Дорноговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **5.9 их наяд ₮** | - | 1.18 их наяд ₮ | 1.18 их наяд ₮ | 1.18 их наяд ₮ | 1.18 их наяд ₮ | 1.18 их наяд ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 32 орны нийт 437 цөмийн реакторт 389.5 ГВт хүчин чадалтайгаар эрчим хүч үйлдвэрлэж дэлхийн эрчим хүчний хэрэглээний 10 хувийг хангаж байна. WNA-н 2021 оны тайланд тусгасан тооцоонд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл 2040 онд 615 ГВт хүрч өнөөдрийн үйлдвэрлэлтэй харьцуулахад 58%-иар өсөх төлөвтэй байна.

### Төслийн ач холбогдол:

- Төслийн хугацаанд улс, орон нутгийн хэмжээнд 2 тэрбум гаруй ам.долларын татвар төвлөрнө.
- Улс, орон нутгийн хэмжээнд томоохон хэмжээний худалдан авалт хийснээр бизнесийн олон боломж нэмэгдэнэ.
- Орон нутгийн дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулна.
- Өндөр ур чадвартай боловсон хүчин бэлтгэх төрөл бүрийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

### Төслийн зорилго, зорилт:

Гадны хөрөнгө оруулалт татах, ажлын байр нэмэгдүүлэх, АМНАТ-ын төлбөр, холбогдох татварууд, бүтээн байгуулалт, орон нутгийн санхүүжилтыг дэмжих, ноогдол ашиг, Үндэсний баялагийн сангийн төвлөрүүлэлтэд нэмэр болно.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Зөөвч-Овоо ордын үйлдвэрлэлийн туршилтыг 2022 онд хийж дууссан.
- Бадрах Энержи ХХК Зөөвч-Овоо ураны орд дээр газар доор уусган олборлох үйлдвэрлэлийн туршилт, нарийвчилсан ТЭЗҮ боловсруулан, МУ-ын ЗГ-тай 2025 оны 01 сарын 17-ний өдөр "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулсан.
- Хувьцаа эзэмшигчдийн гэрээг хөрөнгө оруулагч талтай байгуулах ажил хүлээгдэж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Төслийн хугацаанд үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаанд нийт 795 хүний урт хугацааны үндсэн ажлын байр бий болгоно.
- Уурхайн үйл ажиллагаа эхэлснээр төслийн хугацаанд 1707.65 сая ам.доллар, жилд дунджаар 51.74 сая ам.долларын ханган нийлүүлэлтийн боломж бүрдэнэ.
- Шинэ орд бий болсноор уул уурхайн салбар дахь нүүрс, зэсийн хамаарлыг бууруулна.
- Цөмийн эрчим хүчний түлшний түүхий эд үйлдвэрлэж эхэлснээр эдийн засгийг солонгоруулж, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

# 22. Хөтөлийн "Цемент шохой" үйлдвэрийн урьдчилсан халаагчтай эргэх зуухны технологитой шохойн үйлдвэрийн өргөтгөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
| **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** | **2025** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Цемент шохой" ХХК/ | **2026** | **Сэлэнгэ аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **57.9 тэрбум ₮** | 16.0 тэрбум ₮ | 41.9 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Автоклавын хөнгөн бетоны үйлдвэрүүдийг шаардлага хангасан технологийн шохойгоор хангах улмаар өсөн нэмэгдэж байгаа уул уурхай, өнгөт хар металлургийн үйлдвэрүүдийн баяжуулах болон хаягдлыг саармагжуулах технологи, эрчим хүчний үйлдвэрүүд, кокс химийн үйлдвэрүүд зэрэг шинэ хэрэглэгчдэд үндэсний үйлдвэрийн өртөг зардал багатай, техник технологи бүхий эрчим хүчний хэмнэлттэй, хаягдалгүй, экологийн цэвэр чанартай шохойгоор хангах.

### Төслийн ач холбогдол:

Дагаж хөгжих үйлдвэрүүдийг хувийн хэвшил, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид байгуулна. Мөн ойр орчмын шохойн чулууны нөөцөд тулгуурлан цаашид шохойн үйлдвэрлэлийг өргөтгөн кальцийн карбонат үйлдвэрлэх боломжтой байна. Мөн цементийн үйлдвэрлэлийг өргөтгөж зам гүүрний болон угсармал барилгын төмөр бетон хавтан үйлдвэрлэл, бетон хийцлэлүүдийг үйлдвэрлэх зэрэг барилгын материалын томоохон цогцолбор болох боломжтой.

### Төслийн зорилго, зорилт:

Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын хөгжлийг түүчээлж, цемент, шохойн төрлийн бүтээгдэхүүнээр барилгын материалын үйлдвэрлэлийг бүрэн хангаж, чанар, үнэ, хүртээмжийг хангасан логистикийн сүлжээг бий болгох замаар хот байгуулалтыг дэмжиж, иргэдийн ая тухтай, амьдрах орчныг бий болгоно.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Цемент шохойн үйлдвэрийг байгуулснаар 600 мян.тн шохой үйлдвэрлэх ба Эрдэнэт УБҮ-т нийлүүлэх шохойн чанарыг нэмэгдүүлж, дагаж хөгжих ариутгал, арьс ширний үйлдвэр, бордоо, шахмал түлшний бэхжүүлэгч зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүдэд илүүдэл бүтээгдэхүүнээ нийлүүлнэ.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

Төслийн хэрэгжилтийн явц 30%

- **Нарийвчилсан зураг төсөл:**

Үйлдвэрийн 10 багц нарийвчилсан зураг төслийн ажил төлөвлөгдсөнөөс эхний 2 багцын ажил 100% гүйцэтгэлтэй, 8 багцын зураг төслийн ажил 90%-тай боловсруулагдаад байна.

- **Бүтээн байгуулалт:**

Үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажил бүрэн боловсруулагдсанаар 2025 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар экспертизээр батлагдан, бүтээн байгуулалт 2026 оны 03 дугаар сард эхэлж 2026 оны 12 дугаар сард бүтээн байгуулалт дуусахаар төлөвлөөд байна.

## 23. "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнасан 19.5 км холболтын төмөр зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Эрдэнэс Тавантолгой" ХК/ | **2027** | **Өмнөговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **848.86 тэрбум ₮** | 254.5 тэрбум ₮ | 424.4 тэрбум ₮ | 169.96 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Гашуунсухайт–Ганцмод боомт нь Монгол Улсын хамгийн их ачаа эргэлттэй, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гол гарц юм. Одоогоор нүүрс болон бусад бүтээгдэхүүнийг ихэвчлэн авто тээврээр экспортолж байгаа нь боомтын ачаалал нэмэгдүүлэх, байгаль орчны доройтол, хил дээрх саатал, тээврийн зардлын өсөлт зэрэг асуудал үүсгэж байна. Тиймээс тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх, боомтын ачааллыг бууруулах зайлшгүй шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Энэхүү хил дамнасан төмөр замын төсөл хэрэгжсэнээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч Ханги-Мандал, боомтуудыг үе шаттайгаар төмөр замаар холбох нөхцөл бүрдэнэ. Эдгээр Монгол, Хятадын хилийн боомтууд төмөр замаар холбогдсоноор жилд 160 сая тонн нүүрсийг экспортлох боломж бүрдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 30 сая.тн-оор нэмэгдэж, хил дамнасан тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- **Бүтээн байгуулалтын ажлын нийт явц:** 4%
  Барилгын ажлын бэлтгэл ажлын хүрээнд бетон зуурмагийн үйлдвэрийн угсралтын ажил 51.5 хувь, арматур бэлтгэх талбайн ажил 81.5 хувь, дайрга хадгалах агуулах 37.67 хувь, ажилчдын кемп байгуулах ажил 83.33 хувь.
- **Гүйцэтгэгч:** БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш болгоно.
- Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл нэмэгдүүлнэ.
- Нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 24. "Ханги-Мандал" боомтын хил дамнасан 0.6 км холболтын төмөр зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Төр, хувийн хэвшлийн түншлэл** | **2027** | **Дорноговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **36.0 тэрбум ₮** | - | 18.0 тэрбум ₮ | 18.0 тэрбум ₮ | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Тус боомт нь МУ-ын зүүн бүсийг БНХАУ-ын төмөр замын сүлжээнд холбох стратегийн чухал гарц бөгөөд экспорт, импортын урсгалыг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай бүс юм. Одоогоор боомтод авто тээврийн ачаалал өндөр, тээврийн зардал болон саатал их байгаа нь эдийн засгийн үр ашгийг бууруулж байна. Иймээс хоёр улсын хил дамнасан төмөр зам барих шаардлага үүссэн бөгөөд энэ нь төмөр замын тээврийг үр ашигтай, найдвартай, байгальд ээлтэй хэлбэрт шилжүүлэх үндэс болно.

### Төслийн ач холбогдол:

Төмөр замын холболт бий болсноор экспорт, импортын тээврийн хугацаа, зардал буурч, боомтын нэвтрэх чадвар нэмэгдэнэ. Ингэснээр бүс нутгийн эдийн засгийн эргэлт, худалдаа, ложистикийн урсгал эрчимжиж, улсын хэмжээнд төмөр замын тээврийн сүлжээ өргөжих стратегийн ач холбогдолтой. Мөн авто тээврийн ачааллыг бууруулж, боомтын орчны агаар, хөрсний бохирдлыг багасгах экологи, нийгмийн давуу тал бий болно.

### Төслийн зорилго, зорилт:

Улаанбаатар төмөр замын Замын-Үүд- Эрээн боомтоор нэвтэрч буй ачаа тээврийн ачааллыг бууруулж, экспорт болон транзит тээврийн урсгалыг нэмэгдүүлэх.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” 2004 оны Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмж тусгахаар ажлын хэсэг ажиллаж байна.
- **ТХХТ:** "Монголиан транслайн" ХХК болон" Монголиан транс логистик" ХХК-иудын түншлэл

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Экспортын тээврийн хэмжээг 10 сая.тн-оос 20 сая.тн хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- МУ-ын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нүүрсний тээврийн зардлыг 2.5-4 дахин бууруулна.
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугатын аж үйлдвэрийн бүсэд зориулан экспортлох уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэх зайг 318 км-ээр дөт болгоно.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 25. "Шивээхүрэн-Сэхээ" боомтын хил дамнасан 6.9 км төмөр зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Нарийсухайтын төмөр зам" ХХК/ | **2027** | **Дорноговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **278.0 тэрбум ₮** | 248.0 тэрбум ₮ | 15.0 тэрбум ₮ | 15.0 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Шивээхүрэн–Сэхээ боомт нь Монгол Улсын зүүн болон төвийн бүсийг БНХАУ-ын төмөр замын сүлжээнд холбох стратегийн чухал гарц юм. Одоогоор боомтод авто тээврийн ачаалал өндөр, тээврийн саатал, зардал нэмэгдэж байгаа нь экспорт, импортын урсгалд хүндрэл учруулж, эдийн засгийн үр ашгийг бууруулж байна. Иймд боомтын тээврийн үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Төмөр зам ашиглалтад орсноор боомтын нэвтрэх чадвар нэмэгдэж, экспорт, импортын хугацаа, зардал буурч, логистикийн урсгал сайжирна. Бүс нутгийн эдийн засгийн эргэлт нэмэгдэж, тээвэр, худалдааны үйл ажиллагаа өргөжих бөгөөд авто тээврийн ачаалал буурч, байгаль орчны сөрөг нөлөө багасна.

#### Төслийн зорилго, зорилт:

Монгол Улсын төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх, дотоодын төмөр замын сүлжээг нэмэгдүүлэх, хилийн боомтын шинэ гарц бий болгох, уул, уурхай бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Монголын талын бүтээн байгуулалт бүрэн дууссан бөгөөд Хятадын талаас хил хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх хүлээгдэж байна.
- Хил дамнасан төмөр зам барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах шаардлагатай.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Өнөөгийн экспортын тээврийн хэмжээг 10 сая.тн-оос 20 сая.тн хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нүүрсний тээврийн зардлыг 2.5-4 дахин бууруулна.
- Нарийнсухайтын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн экспортод гаргах шинэ хилийн гарц нээгдэх.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 26. Өмнөговь аймгийн "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2019** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Төр, хувийн хэвшлийн түншлэл** | **2026** | **Өмнөговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтий н гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1.48 их наяд ₮** | 1.22 их наяд ₮ | 259.3 тэрбум ₮ | - | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Өмнөговь аймгийн Тавантолгой ордын уул уурхайн бүтээгдэхүүнийг Гашуунсухайт боомтод аюулгүй, үр ашигтай тээвэрлэхэд 250 км урт тусгай зориулалтын авто зам шаардлагатай. Одоогийн авто замын нөхцөл хангалтгүй, борооны болон өвлийн улиралд тээвэр саатаж, тээврийн зардал нэмэгддэг нь экспортын урсгалд хүндрэл учруулж байна. Иймээс тусгай зориулалтын авто зам барьж уул уурхайн бүтээгдэхүүний тээврийг найдвартай, үр ашигтай болгох чухал шаардлагатай.

#### Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр экспортын тээврийн үр ашиг нэмэгдэж, нэгж бүтээгдэхүүнд ногдох тээврийн зардал буурна. Бүс нутгийн эдийн засгийн эргэлт, логистикийн урсгал эрчимжиж, авто замын ачаалал буурч, байгаль орчны нөлөө багасна. Мөн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн боломж нэмэгдэж, дэд бүтцийн хөгжилд түлхэц болно.

#### Төслийн зорилго, зорилт:

Тавантолгойн нүүрсийг экспортлох шинэ гарц бий болгох, коксжих нүүрсээ Бугатын төмрийн үйлдвэр буюу эцсийн хэрэглэгчид шууд хүргэхэд оршино.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

2025.09.30-ны өдрийн байдлаар нийт далангийн ажил 96%, дэд суурийн ажил 77%, хиймэл байгууламжийн ажил 94%, цементээр бэхжүүлсэн суурийн ажил 67%, хайрган хөвөөний ажил 58% байна.

- **Барилга угсралтын ажил:** 81.5 %
- **Концесс эзэмшигч: “**Тал нутгийн хөгжлийн зам” ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Экспортын урсгал нэмэгдэж, улсын валютын орлого нэмэгдэнэ.
- Өмнөговь аймгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, дэд бүтэц, үйлчилгээний хөгжил нэмэгдэнэ.
- Нүүрс тээврийн хугацаа, зардал, ослын түвшин буурна.
- Байгаль орчны тоосжилт, эвдрэл багасна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 27. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой, Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл-Уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Төр, хувийн хэвшлийн түншлэл** | **2028** | **Өмнөговь аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **881.12 тэрбум ₮** | - | 293.7 тэрбум ₮ | 293.7 тэрбум ₮ | 293.7 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Тавантолгой болон Барууннарангийн бүлэг ордууд нь Монгол Улсын нүүрсний экспортын чухал ордуудын нэг бөгөөд одоогоор экспортын урсгал хэт төвлөрсөн, нэг чиглэлд (Гашуунсухайт) хамааралтай байна. Энэхүү хамаарлыг бууруулж, шинэ экспортын гарц бий болгохын тулд Цагаандэл-Уул боомт чиглэлд тусгай зориулалтын авто зам байгуулах зайлшгүй шаардлагатай.

#### Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр МУ-ын өмнөд бүсийн экспортын урсгал олон чиглэлтэй болж, логистикийн уян хатан байдал дээшилнэ. Тээврийн хугацаа, зардал, байгаль орчны сөрөг нөлөөлөл буурч, бүс нутгийн эдийн засгийн идэвх сэргэнэ. Мөн тус зам нь “Тавантолгой–Цагаандэл-Уул” чиглэлд стратегийн ач холбогдол бүхий экспортын шинэ гарц нээж, улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Тавантолгой, Барууннарангийн бүлэг ордоос “Цагаандэл-Уул” боомт хүртэл уул уурхайн бүтээгдэхүүнийг үр ашигтай, аюулгүй, байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр тээвэрлэх 270 км урт тусгай зориулалтын авто замыг шинээр барьж байгуулах.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Одоогийн байдлаар концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдаж, концессын гэрээ хүчин төгөлдөр болсон, авто замын техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл хийгдэж батлагдсан.
- **Гүйцэтгэл:** Орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс шалтгаалж барилга угсралтын ажил концессын гэрээнд заасан хугацаанд (2025 оны 6 сард) эхлээгүй байна.
- **Концесс эзэмшигч: “**Үндрах говь” ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Экспортын урсгал нэмэгдэж, улсын валютын орлого нэмэгдэнэ.
- Тээвэрлэлтийн үр ашиг, аюулгүй байдал, орчны нөхцөл сайжирна.
- Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, үйлчилгээ, бизнес сайжирна.
- Нүүрс тээврийн хугацаа, зардал, ослын түвшин буурна.
- Байгаль орчны тоосжилт, эвдрэл багасна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 28. Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2022** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Дорнод аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **185.51 тэрбум ₮** | 40.6 тэрбум ₮ | 45.9 тэрбум ₮ | 49.5 тэрбум ₮ | 49.5 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Дорнод аймаг нь Монгол Улсын зүүн бүсийн эдийн засаг, худалдаа, тээврийн төв бөгөөд Хавиргын боомтоор дамжин БНХАУ-тай холбогддог стратегийн ач холбогдолтой бүс юм. Одоогийн авто зам нь хайрган хучилттай, жил бүрийн улирлын нөхцөлд зорчих боломж хязгаарлагдмал, тээврийн хугацаа урт, зардал өндөр байгаа нь худалдаа, аялал жуулчлал, бүс нутгийн эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж байна.

#### Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр Дорнод аймгийг хил дамнасан худалдаа, тээврийн гол гарцтай холбож, экспорт, импортын урсгал болон бүс нутгийн эдийн засгийн эргэлт эрчимжинэ. Хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч, тээврийн хугацаа, зардал буурч, орон нутгийн үйлчилгээ, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн хүртээмж нэмэгдэнэ. Мөн хил орчмын дэд бүтэц хөгжиж, улсын зүүн бүсийн эдийн засгийн чадавх бэхжинэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Бүс нутгийн авто замын сүлжээг сайжруулах, хил дамнасан худалдаа, тээвэр логистикийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой.

### Төслийн Хэрэгжилтийн явц /2025.10.23-ны байдлаар/:

**Багц-1 /31км/**
- Ажлын явц: 36.9%
- Гүйцэтгэгч: "ЗБИБ" ХХК болон "ЗББ" ХХК түншлэл

**Багц-2 /32.5км/**
- Ажлын явц: 45.6%
- Гүйцэтгэгч: "Анандын зам" ХХК

**Багц-3 /30км/**
- Ажлын явц: 30.9%
- Гүйцэтгэгч: "Рүн Хэ Жиү Жөү Констракшн Инженеринг" ХХК

**Багц-4 /31км/**
- Ажлын явц: 43.3%
- Гүйцэтгэгч: "Их монгол барилга" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Зүүн бүсийн дэд бүтэц, логистик сайжирч, тээврийн хугацаа 30–40 хувиар багасаж, зардал буурна.
- Хил дамнасан тээврийн урсгал нэмэгдэж, бүс нутгийн эдийн засгийн идэвх нэмэгдэнэ.
- Аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбар хөгжиж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 29. Өндөрхаан-Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 248.3 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2022** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Хэнтий, Дорнод аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтий н гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **311.80 тэрбум ₮** | 93.2 тэрбум ₮ | 30.0 тэрбум ₮ | 47.15 тэрбум ₮ | 47.15 тэрбум ₮ | 47.15 тэрбум ₮ | 47.15 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Хэнтий аймгийн Өндөрхаан хотоос зүүн чиглэлд орших Норовлин, Баян-Уул, Ульхан сумуудыг холбосон зам нь бүс нутгийн хүн, бараа, үйлчилгээний урсгалыг хангах чухал тээврийн коридор юм. Одоогийн нөхцөлд шороон болон хайрган зам ашиглаж байгаа нь улирлын нөлөөнд өртөмтгий, зорчих нөхцөл хүнд, эдийн засгийн идэвхжил сул байхад нөлөөлж байна.

#### Төслийн ач холбогдол:

Чингис хот-Батноров-Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан чиглэлийн улсын чанартай авто зам ашиглалтад орсноор зүүн гурван аймаг ОХУ-ын Дэвд Ульхан хилийн боомттой шууд холбогдоно. Чита мужаар дамжин ОХУ-тай хатуу хучилттай авто замаар холбогдсон хилийн боомтын тоо нэгээр нэмэгдэнэ. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн иргэд ОХУ-руу аялал жуулчлал хөгжүүлэх, бизнес эрхлэх таатай боломж бүрдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Хэнтий аймгийн зүүн бүсийн авто замын сүлжээг сайжруулах, зорчих нөхцөлийг бүрдүүлэх, тээвэр логистикийн үр ашиг, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилготой.

### Төслийн Хэрэгжилтийн явц /2025.10.23-ны байдлаар/:

**Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км**
- Ажлын явц: 66.0%
- Гүйцэтгэгч: "Билэгт зам" ХХК болон "Нано экологи" ХХК түншлэл, "Дашин" ХХК

**Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км**
- Ажлын явц: 71.3%
- Гүйцэтгэгч: "Монгол зам групп" ХХК

**Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км**
- Ажлын явц: 95.0%
- Гүйцэтгэгч: "Наранбулагхан" ХХК, "Мотор Сервис" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Тээврийн хугацаа, зардал буурч, зорчих нөхцөл сайжирна.
- Бүс нутгийн худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээний салбар идэвхэжнэ.
- Иргэдийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.
- Орон нутгийн эдийн засгийн өсөлт, нийгмийн дэд бүтцийн хүртээмж сайжирна.
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засгийн төвлөрлийг сааруулж, бүс нутгийн хөгжлийг тэгш хангаж, бүсүүдийн уялдаа холбоог сайжруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 30. Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2026** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Завхан аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **366.85 тэрбум ₮** | 17.5 тэрбум ₮ | 13.25 тэрбум ₮ | 84.02 тэрбум ₮ | 84.02 тэрбум ₮ | 84.02 тэрбум ₮ | 84.02 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Увс аймгийн Арцсуурь боомт нь МУ-ыг ОХУ-тай холбох чухал хилийн гарц бөгөөд Нөмрөг–Улаангом чиглэлийн А18 авто замаас уг боомт хүртэлх хэсэгт хатуу хучилттай авто зам байхгүйгээс тээвэр логистикийн урсгал удаан, худалдаа, хамтын ажиллагаа хязгаарлагдмал байна.

#### Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр Увс аймгийн төвийг Арцсуурь боомттой холбосон олон улсын чанартай авто зам бий болж, Монгол–Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжих, хил орчмын сумдын хөгжлийг дэмжих, хүн амын хөдөлгөөнийг хөнгөвчлөх, бүс нутгийн тээвэр логистикийн чадавх сайжрах ач холбогдолтой.

#### Төслийн зорилго, зорилт:

Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх, хил орчмын эдийн засгийн бүсийн хөгжлийг дэмжих, аюулгүй, тасалдалгүй тээвэрлэлтийг хангах.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засгийн төвлөрлийг сааруулж, бүс нутгийн хөгжлийг тэгш хангаж, бүсүүдийн уялдаа холбоог сайжруулна.
- Монгол–Оросын худалдаа, эдийн засгийн урсгал нэмэгдэнэ.
- Тээврийн хугацаа, зардал буурна.
- Хил орчмын бүсийн нийгэм, эдийн засгийн идэвхжил сайжирна.
- Аялал жуулчлал, үйлчилгээний салбар өргөжиж, орон нутгийн орлого нэмэгдэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц /2025.10.23-ны байдлаар/:

- Тус авто замын эхлэл болох 20.2 км /16.6 км авто зам,1.5 м өргөн явган зам бүхий, Түдэвтэй сумын төв хүртэлх 3.36 км гудамж зам, 18.6 урт метр төмөр бетон гүүр/-ийн барилгын ажил 40.1% гүйцэтгэлтэй явагдаж байна.

  **Гүйцэтгэгч:** "Эйч Кей Би интернэйшнл холдинг" ХХК

- Бусад 139.3 км авто замын бүтээн байгуулалт эхлээгүй байна.

## 31. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 152 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Сүхбаатар аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **324.00 тэрбум ₮** | 31.7 тэрбум ₮ | 23.0 тэрбум ₮ | 134.7 тэрбум ₮ | 134.7 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос Бичигт боомт хүртэлх зам нь Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн гол тээврийн коридорын нэг бөгөөд одоогийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдал, чанар хангалтгүй байгаа нь гадаад худалдааны урсгал, бүс нутгийн хөгжлийг хязгаарлаж байна.

#### Төслийн ач холбогдол:

Тус зам нь хатуу хучилттай болсноор МУ-аар дайран өнгөрөх Ази Европыг холбосон авто замын сүлжээ нэгээр нэмэгдэж, Бичигтийн боомт нь Замын-Үүд боомтын дараа орох томоохон боомт болон хөгжиж улмаар БНХАУ-ын Тяньжин, Жинзоу, Далиан зэрэг боомтоор дамжин Зүүн хойд Азийн улстай худалдаа хийх боломжийг бүрдүүлж өгөх эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

#### Төслийн зорилго, зорилт:

Баруун-Урт–Бичигт чиглэлд олон улсын чанартай хатуу хучилттай авто зам барьж, улсын хэмжээний авто замын сүлжээг өргөтгөх, гадаад худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Нийт 152 км замын эхний ээлжийн 50км-ийн хөрс хуулалт, шороон орд нээх, шороон ордоос далан байгуулах, далангийн үе шатны ажлууд хийгдэж байна. Нийт барилгын ажил 5% гүйцэтгэлтэй байна.

  **Гүйцэтгэгч:** "Монгол зам групп" ХХК

- Бусад 102 км авто замын бүтээн байгуулалт эхлээгүй байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засгийн төвлөрлийг сааруулж, бүс нутгийн хөгжлийг тэгш хангаж, бүсүүдийн уялдаа холбоог сайжруулна.
- Монгол–Хятадын худалдаа, тээврийн урсгал нэмэгдэнэ.
- МУ-аар дайран өнгөрөх Ази Европыг холбосон авто замын сүлжээ нэгээр нэмэгдэнэ.
- Тээврийн хугацаа, зардал буурч, экспортын үр ашиг дээшилнэ.
- Хил орчмын сумдын эдийн засаг, үйлчилгээний салбар хөгжиж, ажлын байр нэмэгдэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 32. Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төсөл /Хавирга, Цагааннуур, Булган боомт/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Сангийн яам** | **2023** | **Баруун, Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ – 95%/<br>**Гадаад тусламж** /АХБ – 5%/ | **2030** | **Дорнод, Баян-Өлгий, Ховд аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **382.68 тэрбум ₮** | Гадаад зээл 364.7 тэрбум ₮ | 8.46 тэрбум ₮ | 28.3 тэрбум ₮ | 82.0 тэрбум ₮ | 82.0 тэрбум ₮ | 82.0 тэрбум ₮ | 82.0 тэрбум ₮ |
| | Гадаад тусламж 18.0 тэрбум ₮ | - | - | 6.0 тэрбум ₮ | 6.0 тэрбум ₮ | 6.0 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Боомтын сэргэлтийг хязгаарлаж буй нийтлэг хүчин зүйлст боомтын дэд бүтэц, барилга, байгууламж, тоног төхөөрөмж элэгдэж хуучирсан, дутмаг, ашиглалтын шаардлага хангадаггүй зэрэг шалтгаанууд зонхилж байгаа бөгөөд хилээр нэвтрүүлэх үйлчилгээ, иргэд зорчиход тав тухтай орчин, эрүүл, аюулгүй байдал, хамгаалалт, шалган нэвтрүүлэх стандартын шаардлага хангалтгүй, хил орчмын гадаад худалдааны одоогийн болон ирээдүйд хүлээгдэж буй эргэлтийг дэмжих чадавх сул, орчин нөхцөл хангагдаагүй байна.

### Төслийн ач холбогдол:

Боомтуудыг өргөтгөн шинэчилснээр хилийн боомтод албан хаагчид, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бий болж, боомтын нэвтрэх хүчин чадал нэмэгдэн, олон улсын жишигт нийцэхүйц болж, аялал жуулчлал, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, хилийн үйлчилгээний орчин нөхцөл сайжрах ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

МУ-ын худалдааны салбарыг бэхжүүлэх, экспортын төрөлжилтийг дэмжих, авто замын боомтоор нэвтрэх зорчигч, бараа бүтээгдэхүүний хөдөлгөөний үр ашгийг дээшлүүлэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- АХБ-ны техникийн туслалцаагаар Хавирга хилийн боомтын зураг төслийн нэмэлт өөрчлөлт, төсөвт шинэчлэлт хийх, техникийн тодорхойлолт боловсруулах худалдан авалтыг хийхээр ажиллаж байна.
- Цагааннуур, Булган хилийн боомтууд дээр АХБ-ны дэд төслийн шалгуур хангуулах баримт бичгийн ажлуудыг гүйцэтгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Хавирга хилийн боомтын барилга угсралтын багцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Хавирга, Цагааннуур, Булган хилийн боомтуудын худалдааны эргэлтийг 4-5 дахин нэмэгдүүлнэ.
- Хилээр нэвтрүүлэх үйлчилгээ, иргэд зорчиход тав тухтай орчин, эрүүл, аюулгүй байдал, хамгаалалт, шалган нэвтрүүлэх стандартыг бүрдүүлнэ.
- Худалдаа хөнгөвчлөх системийг сайжруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боомтын зорчигч, ачаа тээврийн нэвтрэлтийг нэмэгдүүлнэ.

# 33. Хилийн Цагаандэл-Уул боомтын барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээ, авто зам талбайн барилга

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Сангийн яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад тусламж** /БНХАУ-ӨМӨЗО, Альшаа/ | **2028** | **Өмнөговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **145.73 тэрбум ₮** | - | 48.58 тэрбум ₮ | 48.58 тэрбум ₮ | 48.58 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Альшаа аймгийг зорьсон жуулчдын хөдөлгөөн жил ирэх тутам нэмэгдэхээр байна. Хил орчмын аялал жуулчлал, гадаад худалдаа, бүс нутгийн иргэдийн ахуйн хэрэгцээг хангах зэргээс шалтгаалан том оврын автобус, иргэдийн хувийн суудлын автомашины хилээр нэвтрэх тоо нэмэгдэх болно. Боомтоор экспортлох нүүрсний хэмжээ боомт ашиглалтад орсны дараа жилд 6 сая тонн байхаар төлөвлөж байгаа бөгөөд энэ хэмжээ 2031 он гэхэд 30 сая тонн хүрэх төлөвтэй байна.

### Төслийн ач холбогдол:

Боомт нь Монгол Улсын эдийн засагт чухал ач холбогдолтой, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх, бүс нутгийн худалдааны эргэлт ихсэхэд чухал нөлөө үзүүлэх бүтээн байгуулалт юм. Мөн аялал жуулчлал хөгжих, түүнийг дагасан бүтээн байгуулалт бий болох, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Боомт нь олон улсын транзит тээвэр хийгээд экспортыг нэмэгдүүлэх гол гарц болж, хоёр улсын жишиг боомт болгохоор шинэ боомт барихаар төлөвлөгдсөн.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Боомтын гадна хашааны ажил баригдаж дууссан.
- Барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Хилээр нэвтрүүлэх үйлчилгээ, иргэд зорчиход тав тухтай орчин, эрүүл, аюулгүй байдал, хамгаалалт, шалган нэвтрүүлэх стандартыг бүрдүүлнэ.
- Ачаа тээврийн орох, гарах чиглэлийн нийт 12 эгнээ бүхий хүнд даацын автозам барина.
- Зорчигч тээврийн орох, гарах чиглэлийн тус бүр 3 эгнээ бүхий авто зам барина.
- Гаалийн лаборатори, мэргэжлийн хяналтын лаборатори, химийн агуулах, хилийн шалган нэвтрүүлэх застав зэрэг байгууламжуудыг барина.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Боомтын зорчигч, ачаа тээврийн нэвтрэлтийг нэмэгдүүлнэ.

# 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ

Сүүлийн жилүүдэд аж үйлдвэржилтийн бүс нутгийн эрчим хүчний эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, хүн амын өсөлт, хот хөдөөгийн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй суурьшлын бүсүүдэд эрчим хүчний хэрэглээ шаардлага тасралтгүй өсөж байна. Монгол улсын хувьд эдийн засгийн өсөлттэй уялдан эрчим хүчний хэрэглээ жил бүр 7-8 хувиар нэмэгдэж байгаа ч үүнийг дан ганц дотоодын эх үүсвэрээр бүрэн хангах боломжгүй байгаагаас шалтгаалан нийт хэрэглээний 24 хувийг хөрш орнуудаас импортолж байна.

Манай улсын хувьд дийлэнх ДЦС-уудын ашиглалтын хугацаа хэтэрч, тоног төхөөрөмжийн насжилт өндөр байгаагаас бүрэн хүчин чадлаар ажиллах боломжгүй болоод байна. Түүнчлэн түгээх дамжуулах шугамын алдагдал 13-19 хувьд хүрээд байгаа нь алслагдсан бүс нутагт төвлөрсөн төвийн эх үүсвэрээс эрчим хүч дамжуулах нь эдийн засгийн үр ашгүй байдлыг нэмэгдүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчинд ээлтэй технологи инновацыг нутагшуулах чиглэлээр сэргээгдэх эрчим хүчний үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ирсэн боловч сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл нийт хэрэглээний 8 хүрэхгүй хувийг эзэлж байна.

Дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд одоо ашиглагдаж буй ДЦС-уудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, аж үйлдвэржилт эрчимжиж байгаа болон алслагдсан бүс нутагт тархмал эрчим хүчний эх үүсвэрүүдийг шинээр бий болгох сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар импортын хэрэглээг хязгаарлахад чиглэгдсэн 18.8 их наяд төгрөг бүхий 16 төсөл хөтөлбөрийг дараагийн таван жилд төлөвлөөд байгаагаас шууд хөрөнгө оруулалтаар 13.5 их наяд төгрөг бүхий 5 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Нийт 16 төслүүдийг ач холбогдлоор нь багцалбал:

- ДЦС-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх төрлийн төслүүд,
- Хуучирсан, шугамын алдагдал өндөртэй ЦДАШ-ын өргөтгөл шинэчлэлийн төслүүд,
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, дэд бүтцийн төслүүд тус тус багтсан байна.

Эрчим хүчний багц төслийг хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын суурилагдсан хүчин чадал 2024 онд 1,350 МВт байгаагаас 2030 онд 2,100 МВт-д хүрч, импортын хамаарлыг 40 хувиар бууруулах боломж бүрдэхээс гадна томоохон уул уурхай, үйлдвэрлэлийн бүсийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэснээр эдийн засгийн эргэлт сайжрах ач холбогдолтой. Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг эрчимжүүлснээр эзлэх хувь 9 хувиас 25 хувьд хүрч, нүүрстөрөгчийн ялгарал жилд 3 сая тонноор буурах тооцоолол гарсан.

Тархмал эх үүсвэрүүдийг нэмэгдүүлснээр бүс нутгийн хэрэглээг хангахаас гадна, эрчим хүчний алдагдал 15 хувиар буурч, дамжуулах хүчин чадал хоёр дахин нэмэгдэнэ.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг (сая төгрөг) | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц | 2025-2030 | 865,800.00 | Гадаад зээл | ЭХЯ |
| 2 | Багануур-Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 188 км ЦДАШ, "Чойр" дэд станцын өргөтгөл | 2026-2028 | 145,291.93 | Гадаад зээл | ЭХЯ |
| 3 | Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 287 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, "Өвөрхангай" дэд станц | 2025-2028 | 241,991.80 | Гадаад зээл | ЭХЯ |
| 4 | 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв | 2020-2030 | 535,320.00 | Гадаад зээл | ЭХЯ |
| 5 | Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг дээшлүүлэх төсөл | 2026-2028 | 147,600.00 | Гадаад зээл | ЭХЯ |
| 6 | Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 220.04 км ЦДАШ, "Сайншанд", "Чойр" дэд станцыг өргөтгөх төсөл | 2025-2028<br>2025-2026 | 194,074.04<br>52,436.20 | Гадаад зээл<br>Гадаад тусламж | ЭХЯ<br>ЭХЯ |
| 7 | Дамбадаржаа дэд төвд дулааны станц барих | 2025-2028 | 139,120.00 | Гадаад тусламж | НЗДТГ |
| 8 | Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц /Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сум/ | 2026-2028 | 108,595.40 | Улсын төсөв | ЭХЯ |
| 9 | Налайх дүүргийн дулааны 216 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр | 2026-2028 | 56,354.90 | Улсын төсөв | НЗДТГ |
| 10 | Өмнөговь аймаг дахь Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц | 2026-2030 | 2,093,805.00 | Шууд хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| 11 | Баянгийн 660 МВт-ын дулааны цахилгаан станц | 2024-2028 | 4,304,737.50 | Шууд хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| 12 | Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын дулааны цахилгаан станц | 2026-2028 | 521,900.00 | Шууд хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| 13 | Шивээ-Овоогийн 660 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих | 2026-2030 | 4,954,317.12 | Шууд хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| 14 | Их чадлын өөрийгөө цэнэглэх батарей хуримтлуурын төсөл | 2026-2030 | 1,672,900.80 | Шууд хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| 15 | Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5) | 2026-2028 | 1,855,768.16<br>463,942.04 | Төр, хувийн хэвшлийн түншлэл<br>Орон нутгийн төсөв | ЭХЯ<br>ЭХЯ |
| 16 | Даланзадгадийн 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих | 2026-2028 | 500,000.00 | Орон нутгийн төсөв | ЭХЯ |

# 34. Өмнөговь аймаг дахь Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл, сонгон шалгаруулалтын шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Эрдэнэс Тавантолгой" ХК/ | **2030** | **Өмнөговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **2,093.8 тэрбум ₮** | - | 418.7 тэрбум ₮ | 418.7 тэрбум ₮ | 418.7 тэрбум ₮ | 418.7 тэрбум ₮ | 418.7 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Эрчим хүчний дийлэнх хэрэглээг уул уурхайн компани бүрдүүлж байгаа өмнөд бүсийн тухайд 2024 онд 1,714.2 сая кВт.ц хэрэглэсэн нь өмнөх оноос 4.3%-иар өссөн бөгөөд үүний 93% (1,594.2 сая кВт.ц)-ийг БНХАУ-ын ӨМӨЗО-оос импортлон авч байна.
- Энэхүү импортын эрчим хүчний төлбөрт жилд дунджаар 120–140 сая ам.доллар төлж байгаа бөгөөд цаашид уул уурхайн үйлдвэржилт эрчимжихийг дагаад хэрэгцээ шаардлага улам өсөн нэмэгдэх хандлагатай байна.

### Төслийн ач холбогдол:

- Говийн бүсийн аж үйлдвэржилтийн эрчим хүчний гол эх үүсвэр болно.
- Импортын хэрэглээг хязгаарлаж, улс, орон нутгийн төсөвт жилд 34.5 сая ам.долларын татвар, хураамж төвлөрүүлнэ.
- Хөрөнгө оруулалтыг 8 жилд нөхөж, дараагийн 25 жилд жил бүр 90–100 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллана.

### Төслийн зорилго, зорилт:

- Эрдэнэс Тавантолгой, Оюутолгой уурхайн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах ДЦС барих төсөл юм.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Тавантолгой ДЦС эхний ээлжийн 300МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах (EPC+F) тендерийн маргааны улмаас төслийн сонгон шалгаруулалтын ажлыг дахин явуулах шаардлагатай болсон.
- Тавантолгой ДЦС төслийн хүрээнд Оюутолгой ХК-тай цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг 2022.01 сард байгуулсан.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилтийн гэрээ | X |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Эхний ээлжид 300 МВт цахилгаан эрчим хүчийг ашиглалтад оруулж, нийлүүлнэ.
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд жилдээ 1.88 тэрбум кВт.ц цахилгаан нийлүүлж, Оюутолгой уурхайг 1.3 тэрбум кВт.ц, Өмнийн бүс 0.5 тэрбум кВт.ц-аар хангана.
- Бүтээн байгуулалтын үед 2500 орчим түр ажлын байр бий болно.
- Ашиглалтын үед 220 байнгын ажлын байр бий болгоно.
- Агаар мандалд хаягдах дэгдэмхий үнсийг 99.9 хүртэл хувиар бууруулах боломжтой.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

## 35. Баянгийн 660 МВт-ын дулааны цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2024** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Касэн пауэр грийн энержи" ХХК/ | **2028** | **Төв аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **4,304.7 тэрбум ₮** | 1,721.9 тэрбум ₮ | 860.9 тэрбум ₮ | 860.9 тэрбум ₮ | 860.9 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах шаардлагатай байна.
- Улаанбаатар хотын Багахангай дүүргийн өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

- Цахилгааны импортыг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.
- Эрчим хүчний импортын хараат байдлыг бууруулахад шууд нөлөө үзүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

- Суперкритикал технологийн нэгж блок нь 330 МВт-ын хүчин чадал бүхий 2 блок 660 МВт-ын дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ 2024.6 сард хийгдсэн.
- Барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- Үндсэн тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Өсөн нэмэгдэж буй төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээг хангана.
- Жилд 4,135.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 3,722.1 сая кВт.ц-ийг нэгдсэн сүлжээнд нийлүүлнэ.
- Жилд 576 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, Багахангай дүүрэг, Баян сумыг хангана.
- 1,600 орчим ажлын байр бий болно.
- Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1.04 тэрбум ам.долларын татвар, хураамж, шимтгэлийн орлого төвлөрүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Цахилгаан эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 36. Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Орон нутгийн төсөв** /Өмнөговь ЗДТГ/ | **2028** | **Өмнөговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **500.0 тэрбум ₮** | - | 166.7 тэрбум ₮ | 166.7 тэрбум ₮ | 166.6 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Даланзадгад хотын одоогийн ДЦС-ын тоноглолын 24 жилийн ашиглалтын хугацаа дуусаж эрэлт хэрэгцээг бүрэн хангах хүчин чадалгүй болоод байна.
- Даланзадгад хот жилд 367.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 56.5 мянган Гкал дулааны эрчим хүч шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

- Өмнөговь аймаг, Даланзадгад хотод орчин үеийн хөгжил, дэвшилтэд нийцсэн, ашигт үйлийн коэффициент өндөр технологитой эрчим хүчний дэд бүтцийг бүрдүүлнэ.
- Тавантолгойн нүүрсний эдийн засгийг даган тухайн бүс нутагт эдийн засаг тэлэх суурь нөхцөлийг бүрдүүлж эрчим хүчний найдвартай хангамжийг сайжруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

- Даланзадгад, Номгон, Ханхонгор, Хүрмэн, Булган, Баяндалай сумд болон бүсийн уул уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах 2x25 МВт хүчин чадалтай ДЦС барих төсөл бөгөөд төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд илүүдэл эрчим хүчийг нийлүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Засгийн газрын 2025.08.13-ны хуралдаанаар төслийг санхүүжүүлэх зорилгоор 500 тэрбум төгрөг хүртэлх аймгийн үнэт цаасыг тухайн жилийн төсвийн тухай хууль, Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн дотоодын зах зээлд үе шаттайгаар арилжаалахыг Өмнөговь аймгийн Засаг даргад зөвшөөрсөн.
- 2026 онд бондыг арилжаалах болон тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа тус тус хийгдэнэ.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | - |

### Төслийн хүрэх үр дүн:

- Даланзадгад хотын 2030 он хүртэлх 403 ААНБ, 2,684 айл өрх, нийт 3,148 хэрэглэгчийн дулааны эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангана.
- Жилд 367.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 56.5 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэнэ.
- Станцын хүрээнд 170 байнгын ажлын байр нэмэгдэнэ.
- 500-с дээш түр ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

# 37. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2025** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /БНХАУ Эксим банк/ | **2030** | **Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **865.8 тэрбум ₮** | 230.1 тэрбум ₮ | 99.4 тэрбум ₮ | 134.1 тэрбум ₮ | 134.1 тэрбум ₮ | 134.1 тэрбум ₮ | 134.1 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Баруун бүсийн эрчим хүчний систем нь хэрэглээнийхээ 74 хувийг ОХУ-аас, 2 хувийг БНХАУ-аас, 24 хувийг “Дөргөн УЦС”-аас тус тус авч, Улсын төсвөөс баруун бүсийн эрчим хүчний системд жил бүр 16-22 тэрбум төгрөгийн татаас төлж байна.
- Хүнд ба хөнгөн үйлдвэр, уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ цаашид жил бүр 8-11 хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

### Төслийн ач холбогдол:

- Баруун бүсийн эрчим хүчний импортоос хараат байдлыг бууруулж, дотоодын хямд эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах боломж бүрдэнэ.
- СЭХ-н эх үүсвэр бүхий цэвэр эрчим хүчээр хэрэглэгчдийн хэрэгцээг хангана, найдвартай, хямд эрчим хүчний нийлүүлэлтийг даган эдийн засаг тэлэх ач холбогдолтой.
- Ойр орчмын агаарын чийгшил нэмэгдэж бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлд эерэг нөлөөтэй.
- УЦС дагасан аялал жуулчлал нэмэгдэж иргэдийн орлого нэмэгдэх боломжтой болно.

### Төслийн зорилго, зорилт:

- 90 МВт-н усан цахилгаан станцын барилга
- Усан цахилгаан станцын ус түрэлтийн тунель
- Усан цахилгаан станцын боомт

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- 2024.11.05 зээлийн хэлэлцээр байгуулсан.
- Нийт 266.4 сая ам.долларын төсөвт өртгөөс 2025 оны 9-р сарын 30-ны байдлаар санхүүжилтийн гүйцэтгэл 45 сая ам.доллар байна.
- Барилгын гүйцэтгэл 17% байна.
- Үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Баруун бүсийн эрчим хүчний системд жил бүр 90 МВт-ийг нийлүүлнэ.
- Жилд 329 мянган тонн нүүрсхүчлийн хий ялгаралтыг бууруулна.
- УЦС барилгын ажлын үед 800-1000 түр ажлын байр, ашиглалтад орсноор 60-80 байнгын ажлын байр бий болно.
- Усан сангийн дагуу аялал жуулчлал, загасчлал, усалгаатай газар тариалан хөгжинө.
- Усан сан нь орчны агаарын чийгшил, цэвэр усны нөөцийг нэмэгдэнэ.
- Улсын төсвийн татаасыг бууруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ.
- Баруун бүс: Эрчим хүчний найдвартай хангамжийг нэмэгдүүлнэ.

## 38. Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Төр, хувийн хэвшлийн түншлэл, орон нутгийн төсөв** | **2028** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **ТХХТ-1,855.7 тэрбум ₮** | - | 618.6 тэрбум ₮ | 618.6 тэрбум ₮ | 618.6 тэрбум ₮ | - | - |
| **ОНТ- 463.9 тэрбум ₮** | - | 154.6 тэрбум ₮ | 154.6 тэрбум ₮ | 154.6 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- 2024 оны байдлаар Улаанбаатар хотын 1.6 сая оршин суугчийн дулааны эрчим хүчний хэрэглээний 80 гаруй хувийг гурван станц хангаж байна.
- Төвийн бүсийн цахилгаан, дулаан хангамжийг хангаж буй одоогийн станцууд насжилт өндөр, хүчин чадал муудсан, тоног төхөөрөмж нь хуучирсан учраас үйл ажиллагааны зардал өндөр, системийн доголдол их, цахилгаан тасалдал болон аюулгүй ажиллагааны эрсдэл нэмэгдэж байна.
- Өвлийн их ачааллын үед бүрэн чадлаараа ажиллах ёстой үед нөөц тоног төхөөрөмжгүй, аваарын нөхцөлд үйл ажиллагаа явуулж, оргил ачааллын үед хэсэгчилсэн хязгаарлалт хийх хүртэл арга хэмжээ авч байна.

#### Төслийн ач холбогдол:

- Нийслэлийн оршин суугчид, хэрэглэгчдийг найдвартай, өндөр үр ашигтай цахилгаан, дулааны эрчим хүчээр хангахаас гадна, бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийг дэмжиж, орон нутгийн эрчим хүчний хүртээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой.

#### Төслийн зорилго, зорилт:

- Нийт 300 МВт хүчин чадалтай станц нь төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд тогтвортой эх үүсвэрийг бий болгож, хот суурин газрын цахилгаан, дулааны хэрэглээг хангана.
- Ус хангамж, эргэлтийн системийн шугам сүлжээ байгуулах боломжтой, түлш (хүрэн нүүрс) нийлүүлэх авто болон төмөр замын холболттой бүс, түүнчлэн бэлэн логистикийн дэд бүтэцтэй.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг зураг төсөл, төсвийг боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх нөхцөлөөр гадаадын хөрөнгө оруулалттай “Ми Тайм” ХК-тай 25 жил ашиглах нөхцөлтэй гэрээг байгуулсан бөгөөд барилга угсралтын ажлын бэлтгэлийг хангаж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 300 МВт цахилгаан эрчим хүч, 340Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж хотын дулааны хэрэгцээний тэн хагасаас илүү хувийг хангах боломж бүрдэнэ.
- 100 мянган айл, өрх цахилгаан эрчим хүчээр хангана.
- 40 мянгат буюу Таван шар, 21 дүгээр хороолол, Хилчин хотхон, Баянхошуу, 3, 4 дүгээр хороолол болон 1-р хороолол зэрэг хүн ам төвлөрсөн бүсүүдийг дулаанаар хангана.
- Бүтээн байгуулалтын үед 1600 орчим түр ажлын байр бий болно.
- Ашиглалтын үед 732 байнгын ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

# 39. Багануур-Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 188 км ЦДАШ, "Чойр" дэд станцын өргөтгөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаадын зээл** /Дэлхийн банк/ | **2028** | **Говьсүмбэр аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **145.3 тэрбум ₮** | - | 2.7 тэрбум ₮ | 71.3 тэрбум ₮ | 71.3 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Говийн болон зүүн бүсэд төлөвлөгдсөн бүтээн байгуулалтын төслүүдийг найдвартай эрчим хүчээр хангах хэрэгцээ шаардлагатай байна.
- Одоогийн байгаа нэг хэлхээт ЦДАШ нь энэхүү өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангаж чадахгүй байна.

### Төслийн ач холбогдол:

- Говийн бүсийн сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг дамжуулах, эрчим хүчний нэгдсэн системд сэргээгдэх эрчим хүчийг нийлүүлэх, улмаар СЭХ-ийн тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой болно.
- Бүс нутгийн айл өрх, аж ахуйн нэгжийн нийт 355,640 хэрэглэгчийг найдвартай эрчим хүчээр хангах боломжтой болно.

### Төслийн зорилго, зорилт:

- 188 км урттай 220 кВ-н 2 хэлхээт ЦДАШ барих, дэд станцыг өргөтгөнө.
- 1.75-3.15 тэрбум.кВт.цаг дамжуулах цахилгаан эрчим хүчийг дамжуулна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах ажил явагдаж байна.
- Сонгон шалгаруулах тендерийн материалыг боловсруулж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Говийн бүсийн Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Өмнөговь, Зүүн бүсийн Хэнтий, Сүхбаатар аймгуудын 70,740 айл өрх, 46,261 аж ахуйн нэгж, 114 уул уурхай болон тухайн бүс нутгийн нийт 355,640 хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаа, тогтвортой байдал хангагдана.
- Бүтээн байгуулалтын үед 300 ажлын байр бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна.

# 40. Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 220.04 км ЦДАШ, "Сайншанд", "Чойр" дэд станцыг өргөтгөх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2025** | **Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаадын зээл, тусламж** /ЕСБХБ/ | **2028** | **Говьсүмбэр, Дорноговь аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **ГЗ-194.0 тэрбум ₮** | - | 27.9 тэрбум ₮ | 83.0 тэрбум ₮ | 83.0 тэрбум ₮ | - | - |
| **ГТ-52.4 тэрбум ₮** | - | 52.4 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Говийн бүсийн болон Сайншандын аж үйлдвэрийн комплекс, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс, Хөхцав, Өргөний цементийн үйлдвэр г.м. олон тооны томоохон хэрэглэгчид найдвартай эрчим хүчээр хангах хэрэгцээ шаардлагатай байна.
- Одоо ашиглаж байгаа нэг хэлхээт 110 кВ Чойр- Сайншандын дамжуулах шугамын хүчин чадал хүрэлцэхгүй байна.

### Төслийн ач холбогдол:

- Говийн бүсийн стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн мега төслүүдийн (Тавантолгой, Оюутолгой, Цагаансуварга, Газрын тос боловсруулах үйлдвэр, Замын-Үүдийн худалдааны чөлөөт бүс) цахилгаан эрчим хүчний дэд бүтцийг сайжруулна.
- Төвийн эрчим хүчний системтэй холбох, Сайншанд дахь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс цахилгаан эрчим хүч нийлүүлнэ.
- "Тавантолгой" ДЦС-ыг Төвийн эрчим хүчний системтэй холбоно.
- "Оюутолгой" уурхайг дотоодын найдвартай цахилгаан эрчим хүчээр хангана.
- "Багануур"-ын 400 МВт-ын ДЦС болон "Багахангай" ДЦС-уудтай "Багануур-Чойр-Сайншанд-Цагаансуварга-Оюутолгой-Тавантолгой" гэсэн 220 кВ-ын ЦДАШ-аар холбогдоно.

### Төслийн зорилго, зорилт:

Дорноговь аймгийн цахилгаан хангамжийг тогтвортой, найдвартай болгож, бүс нутгийн цахилгаан дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд тасралтгүй эрчим хүч хүргэх, дэд станцуудын хүчин чадлыг сайжруулахаас гадна 2 хэлхээ 220.04 км урттай ЦДАШ баригдана.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан.
- Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн үнэлгээ явагдаж байна.
- Үнэлгээ хийгдэж гүйцэтгэгч сонгон шалгаруулсны дараа зээлийн хүсэлтийг ЕСБХБ-нд илгээх ажил хийгдэнэ.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гүйцэтгэгчийн гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Говийн бүсийн аймгууд болох Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр аймгуудын нийт 51,432 хэрэглэгчийн ЦЭХ-ний чанар хүртээмж сайжирна.
- Жилд 1,75-3,15 тэрбум.кВт.цаг эрчим хүчийг дамжуулна.
- Бүтээн байгуулалтын үед 1000 ажлын байр бий болно.
- Байнгын 50 ажлын байр бий болно.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна.

# 41. Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км урт ЦДАШ-ыг барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Ховд аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **108.6 тэрбум ₮** | - | 15.0 тэрбум ₮ | 46.8 тэрбум ₮ | 46.8 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Баруун бүсийн аймгууд эрчим хүчний тодорхой хувийг импортоор авч байгаа бөгөөд Эрдэнэбүрэнгийн УЦС-н үйлдвэрлэх эрчим хүчийг түгээх, дамжуулах шугам шаардлагатай байна.

### Төслийн ач холбогдол:

- Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын нийт 420,000 хэрэглэгчдийг дотоодын хямд ЦЭХ-ээр хангаж, импортын ЦЭХ-ний хараат байдлыг бууруулна.
- ЦДАШ, дэд станцууд ашиглалтад орсноор Баруун бүсийн эрчим хүчний системийг Төвийн эрчим хүчний системтэй нэгтгэнэ.
- Зэрэгцээ ажиллуулах боломж бүрдэхээс гадна улсын төсвөөс жил бүр ББЭХС-д олгодог татаасыг тэглэхэд чухал ач холбогдолтой юм.

### Төслийн зорилго, зорилт:

- Ховд, Увс, Завхан, Говь-Алтай аймгуудын цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөж, тогтвортой, найдвартай цахилгаан хангамжийг хангах, бүс нутгийн эрчим хүчний ачааллыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд тасралтгүй эрчим хүч хүргэх 220 кВ-ын 2 хэлхээ 69 км урт ЦДАШ-ыг барих төсөл.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Баруун бүсийн эрчим хүчний системийн найдвартай байдлыг баталгаажуулна.
- 420,000 хэрэглэгчдийг дотоодын хямд ЦЭХ-ээр хангана.
- Бүтээн байгуулалтын үед 250 орчим түр ажлын байр бий болно.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийн зураг төсөл, ТЭЗҮ зэрэг ажлууд хийгдсэн.
- Байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээг дахин хийх шаардлагатай болсон.

## 42. Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 287 км ЦДАШ шугам, "Өвөрхангай" дэд станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Төв, Хангай бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаадын зээл** /Дэлхийн банк/ | **2028** | **Дундговь, Өвөрхангай аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **242.0 тэрбум ₮** | - | 24.2 тэрбум ₮ | 121.0 тэрбум ₮ | 96.8 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

- Хангайн бүсийн хэвтээ чиглэлийн 110 кВ-ын "Булган-А/Б" ЦДАШ нь 11 аймгийн 150 сумын хэрэглэгчдийг хангаж хэт өндөр ачааллыг үүсгэж байгаа нь цахилгаан эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаанд өндөр эрсдэл учруулж байна.
- 110 кВ-ын ЦДАШ-ын цахилгаан дамжуулах чадвар нь бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах боломжгүй, алдагдал өндөртэй байна.

Төслийн ач холбогдол:

- Монгол Улсын эрчим хүчний ухаалаг системийг нэвтрүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээс гадна хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаа, тогтвортой байдлыг хангана.
- Сэргээдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчнийг дамжуулах, импортын эрчим хүчийг бууруулахад чухал нөлөөтэй.
- Баянхонгор, Арвайхээр, Мөрөн чиглэлийн хүчдэлийн түвшнийг хэвийн хэмжээнд байлгах боломжийг олгоно.
- Бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах боломжтой болно.

Төслийн зорилго, зорилт:

- Цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөж, тогтвортой, найдвартай цахилгаан хангамжийг хангах, бүс нутгийн эрчим хүчний ачааллыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд тасралтгүй эрчим хүч хүргэх 220 кВ-ын 2 хэлхээ 287 км урт ЦДАШ-ыг барих төсөл.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийн бэлэн байдал хангагдсан бөгөөд Дэлхийн банктай хамтран төсөл хэрэгжүүлэх гарын авлага, худалдан авах төлөвлөгөөг боловсруулсан.
- Зээлийн хэлэлцээрийг ЗГ-аар хэлэлцэж УИХ-д өргөн барихаар бэлдэж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Сэргээгдэх эрчим хүчний томоохон төслүүдийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системд нийлүүлэх техникийн боломж бүрдэнэ.
- Шинэ Хархорум хотын цахилгаан хангамжийн асуудал шийдвэрлэгдэнэ.
- Ашиглалтын үед 20 орчим ажлын байр бий болно.
- Дундговь аймгийн 46 мянган иргэн, 15 мянган өрх, Өвөрхангай аймгийн 114 мянган иргэн, 35 мянган өрх найдвартай цахилгаан эрчим хүчээр хангагдна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна.

## 43. 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2020** | Баруун бүс, Хангайн бүс, Говийн бүс, Зүүн бүс, Төвийн бүс |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /БНСУ Эксим банк/ | **2028** | Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **535.3 тэрбум ₮** | 352.7 тэрбум ₮ | 24.3 тэрбум ₮ | 79.2 тэрбум ₮ | 79.2 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Төслийн зорилтот 10 аймгийн төвийн дулаан хангамжийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан бөгөөд одоогийн зуухнуудын ашигт үйлийн коэффициент 40 хувиас доош байна.
- Зуухны ажиллагаа болон хүчин чадал хангалтгүй байгаа нь хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй, ахуйн хэрэглээний халуун усны систем шаардлага хангахгүй, найдвартай ажиллагаа доголдож байна.
- Тухайн бүс нутгуудад агаарын бохирдол өндөр, ажиллах орчны нөхцөл тааруу байгаа нь асуудлыг улам хүндрүүлж байна.

#### Төслийн ач холбогдол:

- Байгаль орчинд сөрөг нөлөө багатай дэвшилтэт технологийн, найдвартай, төвлөрсөн дулаан хангамжийн систем барьж, иргэдийг халаалт, хэрэгцээний халуун усаар ханган, амьдрах орчныг сайжруулах.
- Шинэ технологид суурилсан учир үр ашиг өндөртэй байгальд ялгарах нүүрс хүчлийн хий уламжлалт технологитой харьцуулахад бага байна.
- Уг төсөл хэрэгжсэнээр тухайн аймгийн төвийн иргэдийг тогтвортой, найдвартай дулааны эрчим хүч болон хэрэглээний халуун усаар хангаж, амьдрах орчныг сайжруулах, агаарын бохирдлыг 60-70 хувь бууруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

- Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн төвд нийт 10 орчин үеийн дулааны станц шинээр баригдах юм.
- Эдгээр дулааны станцууд нь дэвшилтэт технологид суурилсан, автомат удирдлагын системтэй байна.
- Шинээр суурилагдах эргэлтэт буцламтгай үет шаталттай зуух нь 85–90 хувийн ашигт үйлийн коэффиценттэй байх тул түлш бүрэн шатаж, нүүрсний хэрэглээ болон үнсний гаралт буурна.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

| Аймаг | Гүйцэтгэл, % | Аймаг | Гүйцэтгэл, % |
|---|---|---|---|
| Баянхонгор | 46.15 | Өвөрхангай | 47.44 |
| Говь-Алтай | 47.44 | Сүхбаатар | 50.74 |
| Говьсүмбэр | 47.33 | Төв | 46.05 |
| Дундговь | 45.69 | Хэнтий | 46.78 |
| Завхан | 44.93 | | |

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 10 аймгийн төвд нийт 255Гкал/ц (20, 25, 30 Гкал/ц) хүчин чадалтай 10 дулааны станц, 66 км дулаан дамжуулах шугам, 88 дулаан дамжуулах төв, төвлөрсөн дулаан хангамжийн системийг шинээр баригдана.
- Хүхэр, азот, тоосонцрыг 70-90 хувь, нүүрсхүчлийн хийг 50 гаруй хувиар тус тус бууруулна.
- Нийт 600 гаруй төсөвт байгууллага, 1000 орчим ААН, 700 орон сууц, 1400 амьны орон сууц, шинээр 50,000 м2 талбай бүхий 9,800 айл өрх дулаан хангамжийн системд холбогдоно.
- 1400 ажлын байр шинээр бий болно.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна.

## 44. Налайх дүүргийн дулааны 216 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр /эхний ээлж 79 МВт/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Улаанбаатар, Налайх дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **56.3 тэрбум ₮** Гэрээний дүн /55,729.6/ | 16.9 тэрбум ₮ | 15.7 тэрбум ₮ | 23.7 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Тус станцын хоёр зуух бүрэн хүчин чадлаараа ажиллах үед өвлийн оргил ачааллын үеэр 26.4 Гкал/цаг дулаан үйлдвэрлэж байгаа бөгөөд нийт дулааны ачаалал болох 39.5 Гкал/цагийн дөнгөж 66.8 хувийг л хангаж байна.
- Цаашид дулааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэх төлөвтэй байгаа тул энэ асуудал улам хүндрэх эрсдэл үүсээд байна.

#### Төслийн ач холбогдол:

- Тухайн аймгийн төвийн иргэдийг тогтвортой, найдвартай дулааны эрчим хүч болон хэрэглээний халуун усаар хангаж, амьдрах орчныг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, цаашлаад эрчим хүчний импортыг хязгаарлах чухал үр нөлөөтэй.
- Энэхүү шинэ үүсгүүр бүхий дулааны цахилгаан станц нь дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлтийг 2030 он хүртэл бүрэн хангах боломжтой болох юм.

#### Төслийн зорилго, зорилт:

- Дулааны станц нь 58x3 МВт болон 21x2 МВт-ын ус халаах зуухтай байх бөгөөд зуух тус бүр орчин үеийн өндөр үр ашигт үйлийн коэффициенттой уутат шүүлтүүр бүхий үнс барих тоноглогдсон байна.
- Тус станц нь орчин үеийн дэвшилтэт технологийн шийдэлтэй утааны хийн цэвэрлэгээний систем, удирдлагын автомат систем, ус боловсруулах систем, хүхэргүйжүүлэх системүүдээр тоноглогдсон байна.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад нийт 56,354.9 сая төгрөг үнээс 2025 онд санхүүжих дүн нь 16,906.5 сая төгрөгөөр батлагдсан.
- Төслийн гүйцэтгэгч: “МЭЭ” ХХК /2025.05.26-нд гэрээ байгуулсан/
- Барилга угсралтын ажил эхлээгүй байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Налайх дүүргийн нийт 39,5 Гкал/цаг эрэлт хэрэгцээг бүрэн хангаж 79МВт хүчин чадалтай дулааны станцтай болно.
- Орчны агаарын бохирдлыг 60-70 хувь бууруулна.
- Налайх дүүргийн 41 мянган иргэн, эрчим хүчээр хангана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

# 45. Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | **Хэрэгжилтийн шатанд** | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2020** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /Дэлхийн банк/ | **2025 (2026 он хүртэл сунгасан)** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **147.6 тэрбум төгрөг** | 133.9 тэрбум ₮ | 13.7 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Нийслэл хотын хүн ам 2035 он гэхэд 1.9 сая хүрч, дулааны эрчим хүчний хэрэглээ 2035 он хүртэл жилд 5–6 хувиар тогтмол өсөх төлөвтэй байгаа нь эрчим хүчний хомсдол бий болох эрсдэлийг үүсгэж байна.
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн төвийн дулаан хангамжийн сүлжээний техникийн алдагдал 19 хувьд хүрсэн байна.
- 370 км дамжуулах шугам хоолойн 30 хувь буюу ойролцоогоор 103.6 км урт шугам хоолой насжилт хэтэрсэн, техникийн хэвийн ажиллах нөхцөлгүй болсон тул солих шаардлагатай гэсэн тооцоо гарсан.

### Төслийн ач холбогдол:

- Төслийн удирдлага ба хэрэгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа нь УБДС-ийн техникийн чадавхи болон үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлнэ.
- Энэ арга нь нүүрсний хэрэглээ, $CO_2$ болон PM2.5-ын ялгаралтыг ихээхэн бууруулах үр нөлөөтэй.
- Сайжруулсан халаалтын үйлчилгээ нь хотын төв болон хотын ойролцоох гэр хорооллын айл өрхүүдэд онцгой ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

- Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу бий болох орон сууцны хороолол, нийгэм, ахуйн барилга байгууламжуудын дулааны хэрэглээг эх үүсвэрүүдийн хүчин чадлын өргөтгөлтэй уялдуулах төсөл.
- Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийг “УБДС” ТӨХК дээр хэрэгжүүлж байна.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төсөл нь 2021-2025 оны хооронд Дэлхийн банкны 41,000,000,0 ам долларын зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн.
- Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд 2022 онд 3172 м хос дулааны шугам, 2023 онд 5501 м хос дулааны шугам, 2024 онд нийт 3280 м хос шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийгдэж одоогийн байдлаар нийт 11.953 м хос шугамын өргөтгөл хийгдээд байна.
- Хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОННҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн үр дүн:

- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр 2025 оны 10-р сарын 01-ний байдлаар дулааны ф250-1000мм-ийн голчтой нийт 14.7 хос.км дулааны магистраль шугам сүлжээ,
- ф100-350мм-ийн голчтой 3.93км уурын түр болон үндсэн шугам сүлжээ,
- ф200-400мм-ийн голчтой 6.7км цэвэр ус хангамжийн магистраль шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
- Үр дүнд нь дулааны шугамын нэвтрүүлэх чадварыг 1284 т/ц-аар нэмэгдүүлж,
- CO2-ыг 1,294,253.3 тн-оор бууруулна.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

## 46. Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2024** | **Төв** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Райд Монголиа" ХХК/ | **2026** | **Сэлэнгэ, Сүхбаатар сум** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **521.90 тэрбум ₮** | 393.6 тэрбум ₮ | 128.3 тэрбум ₮ | - | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Урьдчилсан тооцооллоор 2030 он гэхэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот нь 39,800 оршин суугчид, 11,372 айл өрхтэй болж цахилгаан эрчим хүчний хэрэглээ нь 34 МВт хүрэх төлөвтэй байна.
- Одоогоор ажиллаж байгаа станцийн тоног төхөөрөмж, зуух нь хуучирч хамгийн ихдээ 25 МВт-ийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой байгаа нь цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангах боломжгүй болоод байна.

#### Төслийн ач холбогдол:

- Сүхбаатар хотын дулаан хангамжийг сайжруулна.
- Бүс нутгийн цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг сайжруулна.
- Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжинэ.
- ОХУ-аас импортлох цахилгаан эрчим хүчний хэмжээг бууруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

- 70 МВт-ын цахилгаан станц барих
- Жилд 446.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Эрчим хүч удалдах худалдан авах гэрээ нь 2024.10 сард хийгдсэн.
- ТЭЗҮ бүрэн хийгдэж, зураг төсөл нь төслийн явцтай уялдан хэсэгчилсэн байдлаар хийгдэж байна.
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75 хувьтай үргэлжилж байна.
- Нийт төсөвт өртөг нь 521.9 тэрбум төгрөг байснаас одоо 40 сая доллар буюу 128,2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 70 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай ба жилд 446.6 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэнэ.
- Бүтээн байгуулалтын үед 450 орчим түр ажлын байр, ашиглалтын үед 120 байнгын ажлын байр бий болгоно.
- Агаар мандалд хаягдах дэгдэмхий үнсийг 99.9 хүртэл хувиар бууруулах боломжтой.
- Сүхбаатар аймгийн 36 мянган иргэнийг эрчим хүчээр хангана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

# 47. Шивээ-Овоогийн 660 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2027** | **Говь** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"Ар И Си Си Эм Жи" ХХК/ | **2030** | **Говьсүмбэр аймаг** |

| **Нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **4,954.3 тэрбум ₮** | - | - | 1,486.3 тэрбум ₮ | 1,981.7 тэрбум ₮ | 990.8 тэрбум ₮ | 495.4 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Говийн бүсэд байгуулагдах Бор-Өндөр үйлдвэрлэл, технологийн парк, зэрэг томоохон үйлдвэржилтийн бүтээн байгуулалтыг даган цахилгаан эрчим хүчний хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна.
- Улл уурхайн бүсэд байгуулагдаж байгаа Бөөрөлжүүт 450 МВт, Багахангай 660 МВт болон Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станцууд тус тус ашиглалтад орсон ч дахин 590-890 МВт чадлыг нэмж шаардагдах тооцоо гарсан.

### Төслийн ач холбогдол:

- Говийн бүсэд байрлах томоохон уурхайнууд болох Оюу толгой, Тавантолгой, Цагаан суваргын уурхайнуудыг цахилгаан эрчим хүчээр хангах найдвартай эх үүсвэртэй болно.
- Нүүрс тээвэрлэлтийн зардал багасаж Шивээ-Овоогийн уурхайн нүүрсийг нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн болгох ач холбогдолтой.
- Эрчим хүчний хангамж сайжирснаар тухайн орон нутгийн хөгжилд илүү өгөөж өгөх төсөл юм.

### Төслийн зорилго, зорилт:

Монгол улсын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлыг 660 МВт-аар нэмэгдүүлэх, найдвартай тогтвортой үйл ажиллагааг хангах, нөөц чадлыг зохистой хэмжээнд хүргэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Тус төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.
- Төсөл хэрэгжүүлэгч компани нь Эрчим хүчний зохицуулах хорооноос 2025 оны 06 дугаар сард эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг авсан.
- Газрын баталгаажуулалтын ажил болон эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлцэл хийгдэж байна.
- БОНБҮ тайланг БОУАЯ-д хүргүүлсэн.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- 660 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай ба жилд 4,683 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэх боломжтой.
- Бүтээн байгуулалтын үед 1500 орчим түр ажлын байр бий болно.
- Ашиглалтын үед 200 байнгын ажлын байр бий болгоно.
- Цахилгаан статик шүүлтүүр бүхий дэвшилтэт технологитой тул станцаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Цахилгаан эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 48. Дамбадаржаа дэд төвд дулааны станц барих

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад тусламж** /АХБ-60 хувь, Нийслэл-40 хувь/ | **2027** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **80.9 тэрбум ₮** | 34.8 тэрбум ₮ | 24.3 тэрбум ₮ | 21.8 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

- Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь гэр хороололд, ахуйн хэрэгцээний анхан шатны дэд бүтэцгүй нөхцөлд амьдарч байна. Гамшгийн хэмжээнд хүрсэн агаарын бохирдлын 80 хувь нь гэр хорооллын яндангийн утаа, сул шорооноос үүдэлтэй байна.
- Дамбадаржаа дэд төвийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлттэй холбоотой дулааны эрэлт нэмэгдэж, одоогийн эх үүсвэрүүд шаардлага хангахгүй болсон.

#### Төслийн ач холбогдол:

- Дамбадаржаа дэд төвд төдийгүй орчмын гэр хорооллын дулаан хангамжийг сайжруулах, тогтвортой, найдвартай дулаан нийлүүлж, дэд төвийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой.
- Байгаль орчинд ээлтэй, найдвартай эрчим хүчний эх үүсвэр бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

- 63 МВт суурилагдсан чадалтай Дамбадаржаа дулааны станцын барилга угсралтын ажлыг хийнэ.
- Сэлбэ дэд төв барихаар төлөвлөсөн 10,068 өрхийн орон сууцны хойд талын хэсэг, Дамбадаржаа дэд төвийн 2000 гаруй айлыг дулаанаар хангана.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Тус станцын барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятадын “Хоёрдугаар металлурги групп” корпорац ажиллаж буй бөгөөд өнөөдрийн байдлаар төслийн нийт хэрэгжилт 40 хувьтай үргэлжилж байна.
- Үндсэн зуух, нүүрсний агуулах, конвейер, захиргаа, аж ахуйн байр, хими ус бэлтгэлийн болон механик цехийн 10 гаруй үндсэн болон туслах барилгын газар шороо, төмөрбетон суурийн ажлууд бүрэн хийгдсэн. Мөн 86 метрийн өндөр цутгамал төмөрбетон утааны яндангийн цутгалт болон өндөр температур тэсвэртэй дотор өрлөгийн ажил дууссан.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Улаанбаатар хотын анхны жишиг “20 минутын хот” болох Сэлбэ дэд төв орчмыг дулаанаар хангах 63 МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай. Эргэлтэт буцламтгай үе давхаргат технологи бүхий 3x21МВт хүчин чадалтай зуухтай.
- Зуухны ашигт үйлийн коэффициент 86 хувь бөгөөд хорт бодис, нарийн үнс, тоос зэрэг бохирдлыг 95-98 хувиар бууруулах, байгаль орчинд ээлтэй шийдэл юм.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

## 49. Их чадлын өөрийгөө цэнэглэх батарей хуримтлуурын төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эрчим хүчний яам** | **2026** | **Хангай, Говийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Шууд хөрөнгө оруулалт** /"РОКС Энержи групп"/ | **2030** | **Орхон, Өвөрхангай, Дундговь** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1,672.9 тэрбум ₮** | - | 167.3 тэрбум ₮ | 167.3 тэрбум ₮ | 501.9 тэрбум ₮ | 501.9 тэрбум ₮ | 334.5 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

- Эрчим хүчний системд горим тохируулгын эх үүсвэр дутагдалтайн улмаас нар, салхины эрчим хүчний эх үүсвэрүүд буюу тогтворгүй эх үүсвэрүүдийн оролцох хувь хэмжээ нэмэгдэх тусам горим ажиллагаа хүндрэх, импортын хазайлт үүсэх, системийн тогтворжилт алдагдах гэх мэт нэгдсэн сүлжээний тогтвортой, найдвартай ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд нэгдсэн системд нар, салхины хувьсах эх үүсвэрүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой эрчим хүч хуримтлуурын станцыг шинээр барьж байгуулах шаардлагатай.

Төслийн ач холбогдол:

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний найдвартай байдлыг дээшлүүлнэ.
- Эрчим хүчний хангамжийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.
- Диспетчерийн зохицуулалтад дэмжлэг үзүүлнэ.

Төслийн зорилго, зорилт:

- Нийт 400 МВт-ын хүчин чадалтай, 1600 МВт.цагийн багтаамжтай өөрийгөө цэнэглэх нарны эх үүсвэр бүхий батарей хуримтлуур бий болно.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалтаар буюу Вьетнам Улсын 100 хувийн хөрөнгө оруулалтаар нийт 400 МВт-ын хүчин чадалтай, 1600 МВт.цагийн багтаамжтай өөрийгөө цэнэглэх нарны эх үүсвэр бүхий батарей хуримтлуурын төслийг Дундговь, Өвөрхангай, Орхон аймаг гэсэн 3 байршилд тархмал хэлбэрээр тус улсын "ROX energy" группээс хэрэгжүүлэхээр төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Төслийн ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Оргил ачааллын үед импортын эрчим хүчийг бууруулах, хүчдэлийн давтамж тохируулга хийнэ.
- Дулааны цахилгаан станцуудыг "0" зогсолтоос сэргийлнэ.
- Цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх зэрэг туслах үйлчилгээг эрчим хүчний нэгдсэн системд үзүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Импортын эрчим хүчний хэрэглээг багасгана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулна.

# 4. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

# БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Монгол Улсын хүн амын тал хувь Нийслэл Улаанбаатар хотод амьдарч, нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 70 гаруй хувь, худалдаа үйлчилгээний 80-аас илүү хувь, их дээд сургуулийн 96 хувь нь төвлөрч, ДНБ-ний дийлэнх хувийг үйлдвэрлэгдэж байгаа нь хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал үүссэнийг харуулж байна. Хүн амын төвлөрлийг дагаж иргэд чанартай боловсрол, нийгэм, соёлын олон төрлийн үйлчилгээ, эдийн засаг, санхүүгийн боломжийг эрэлхийлэн хот, суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн хийснээр хөдөө, орон нутагт ажиллах хүчин хомсдож, эдийн засаг, хөгжлийн тэнцвэргүй байдал үүсээд байна.

Иймд Нийслэл хотын авто замын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, нийгмийн үйлчилгээний хүртээмжгүй байдлыг бууруулах, алслагдсан сум, аймгийн төвүүдийг улсын болон хил дамнасан авто замаар холбох, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал, тогтвортой хөдөө аж ахуйн төсөл хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан. Тухайлбал,

- Улаанбаатар хотын хэмжээнд: Замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн Туулын хурдны зам, Шинэ тойрог зам, иргэдийг амьдрах орчныг сайжруулах, гэр хорооллын дахин төлөвлөлтийн чиглэлээр Сэлбэ, Баянхошуу дэд төвийн орон сууцжуулах төсөл, орчны бохирдлыг бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр бий болгох зорилгоор Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн төсөл.
- Улсын хэмжээнд: Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл, хөдөө аж ахуйн шинэчлэлийг дэмжих төсөл.
- Бүс нутгийн хэмжээнд: Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк байгуулах төсөл, Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, түүнчлэн алслагдсан бүс нутгуудыг авто замаар холбох, аялал жуулчлалын замын төслүүд хэрэгжинэ.

Нийслэл хотын бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжсэнээр замын түгжрэл болон зардлыг бууруулах, экспортын зах зээлийг өргөжүүлэх, иргэдийг орон сууцаар хангах, амьжиргааны нөхцөлийг сайжруулах, бохирдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах зэрэг нөлөөллийг бий болгоно.

Баруун, зүүн, хангай, төвийн бүсийг холбосон авто замын шинэ төслүүд хэрэгжиж, ашиглалтад орсноор дотоодын тээвэр логистикийн үр ашиг нэмэгдэж, аймгуудын хоорондын тээврийн хугацаа 40 хувиар богиносож, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлнэ.

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг (сая төгрөг) | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр | 2025-2034 | 2,083,325.20 | Гадаад зээл | ЭЗХЯ |
| | | 2025-2034 | 172,413.12 | Гадаад тусламж | ЭЗХЯ |
| | | 2025-2034 | 384,337.58 | Бусад эх үүсвэр | ЭЗХЯ |
| 2 | Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл | 2023-2030 | 374,000.00 | Гадаад зээл | ЗТЯ |
| 3 | Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын  нүхэн гарц барих төсөл | 2022-2027 | 106,575.92 | Гадаад зээл | НЗДТГ |
| 4 | Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл | 2020-2027 | 254,940.00 | Гадаад зээл | НЗДТГ |
| 5 | Сэлбэ дэд төв орон сууцжуулах төсөл | 2026-2029 | 1,934,850.00 | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас | НЗДТГ |
| 6 | Баянхошуу дэд төв орон сууцжуулах төсөл | 2025-2028 | 1,444,900.00 | Гадаад зээл | НЗДТГ |
| 7 | Туулын хурдны зам | 2025-2030 | 2,838,500.00 | Улсын болон орон нутгийн төсөв | НЗДТГ |
| 8 | Шинэ тойрог зам (1-р тойрог) | 2026-2030 | 3,213,000.00 | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас | НЗДТГ |
| 9 | Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц | 2025-2030 | 501,300.00 | Улсын болон орон нутгийн төсөв | НЗДТГ |
| 10 | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл | 2019-2027 | 130,560.00 | Гадаад зээл | ССАЖЗЯ |
| 11 | Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих төсөл | 2026-2029 | 118,000.00 | Улсын төсөв | ХББОСЯ |
| 12 | Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх төсөл | 2025-2027 | 97,738.30 | Улсын болон орон нутгийн төсөв | НЗДТГ |
| 13 | Улиастай-Алтай чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам | 2026-2029 | 171,810.00 | Гадаад зээл | ЗТЯ |
| 14 | Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам | 2026-2029 | 234,462.00 | Гадаад зээл | ЗТЯ |
| 15 | Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн 487.73 км хатуу хучилттай авто зам | 2025-2032 | 874,758.60 | Улсын төсөв | ЗТЯ |

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг (сая төгрөг) | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 16 | Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл | 2026-2030 | 38,400.00 | Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 17 | "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл"-ийн хоёр-үе шаттай төсөл | 2025-2029 | 205,217.40 | Гадаад зээл | ХХААХҮЯ |
| 18 | Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төселл | 2022-2028 | 55,740.00 | Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 19 | Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолборын дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төсөл | 2024-2028 | 79,262.41 | Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 20 | "Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл"-ийн II үе шат | 2026-2029 | 36,715.89 | Гадаад зээл | ХХААХҮЯ |
| 21 | Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн 179.7 км хатуу хучилттай авто зам | 2024-2030 | 216,979.70 | Улсын төсөв | ЗТЯ |
| 22 | Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто зам | 2024-2028 | 58,696.20 | Улсын төсөв | ЗТЯ |
| 23 | Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн 152.5 км хатуу хучилттай авто зам | 2024-2030 | 263,595.40 | Улсын төсөв | ЗТЯ |
| 24 | Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто замын дуусгал | 2025-2028 | 103,600.00 | Улсын төсөв | ЗТЯ |
| 25 | Орхонтуул-Цээл чиглэлийн 62.56 км хатуу хучилттай авто зам | 2025-2028 | 118,449.50 | Улсын төсөв | ЗТЯ |
| 26 | Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн 28.5 км хатуу хучилттай авто зам | 2025-2027 | 44,973.40 | Улсын төсөв | ЗТЯ |
| 27 | Солонготын давааны 12.08 км хатуу хучилттай авто зам | 2025-2027 | 46,282.40 | Улсын төсөв | ЗТЯ |
| 28 | Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.18 км хатуу хучилттай авто зам | 2024-2027 | 66,766.50 | Улсын төсөв | ЗТЯ |
| 29 | Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хучилттай авто зам | 2022-2028 | 182,566.30 | Улсын төсөв | ЗТЯ |
| 30 | Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх 43.3 км хатуу хучилттай авто зам | 2024-2027 | 69,512.60 | Улсын төсөв | ЗТЯ |
| 31 | Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн 66 км хатуу хучилттай авто замын дуусгал | 2025-2030 | 163,736.30 | Улсын төсөв | ЗТЯ |
| 32 | Ховд-Дөргөн сум чиглэлийн 40.7 км хатуу хучилттай авто зам | 2024-2027 | 49,854.20 | Улсын төсөв | ЗТЯ |
| 33 | Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох 32.4 км хатуу хучилттай авто зам | 2024-2027 | 32,470.10 | Улсын төсөв | ЗТЯ |
| 34 | Увс нуур-Улаангом чиглэлийн 26.39 км хатуу хучилттай авто замын эхний үе шат | 2024-2027 | 46,659.10 | Улсын төсөв | ЗТЯ |

## 50. Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Эдийн засаг, хөгжлийн яам** | **2024** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ, УАНС, ЕХОБ - 79%/<br>**Гадаад тусламж** /АХБ, УАНС, ЕХОБ - 6%/<br>**Бусад эх үүсвэр** – 15% | **2034** | **17 аймгийн 52 суманд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.64 их наяд ₮** | Гадаад зээл 2.1 их наяд ₮ | 5.0 тэрбум ₮ | 41.8 тэрбум ₮ | 279.1 тэрбум ₮ | 383.5 тэрбум ₮ | 509.5 тэрбум ₮ | 201.1 тэрбум ₮ |
| | Тусламж 172.4 тэр ₮ | - | 24.7 тэрбум ₮ | 18.5 тэрбум ₮ | 18.5 тэрбум ₮ | 18.5 тэрбум ₮ | 18.5 тэрбум ₮ |
| | Бусад 384.3 тэр ₮ | 98.0 сая ₮ | 3.4 тэрбум ₮ | 51.8 тэрбум ₮ | 67.3 тэрбум ₮ | 118.8 тэрбум ₮ | 38.9 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Нийслэлийн хэт төвлөрөл, хөдөөгийн хөгжил нь улсын тулгамдсан асуудал болоод байна. Аймаг, сумдын усан хангамж, бохир ус цэвэрлэгээ, үерийн хамгаалалт, хог хаягдлын менежмент, төрийн үйлчилгээний барилга байгууламжийн нөхцөл хангалтгүй байгаа нь орон нутгийн хөгжлийг саарууулж байна. Иймээс хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, хөдөөгийн сэргэлтийг дэмжих шаардлагатай байна.

Төслийн ач холбогдол:

Тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газрыг байгуулж, ХАА-н бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийг дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлнэ.

Төслийн зорилго, зорилт:

Төслийн хүрээнд хүнсний нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд амьдрах таатай орчин бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Дэд бүтэц, мал аж ахуй, бэлчээрийн менежментийн зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж, хамгаалагдсан аж ахуй болон усалтын системийн байршлууд сонгогдон газрын гэрчилгээ авч байгаа бөгөөд малчдын хоршоодыг чадавхжуулж, GIRAF сангийн менежер томилон зээл, гэрээ болон дотоодын зөвлөхийн сонгон шалгаруулалтын бэлтгэл хийгдэж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | X |

### Төслийн хүрэх үр дүн:

- Дэд бүтэц ба үйлдвэрлэл: 317 км инженерийн шугам, 1.86 МВт нарны станц, 5 цэвэрлэх байгууламж, 50 га үйлдвэрлэлийн парк, 5 бизнес инкубатор, дижитал төв, 970 хүүхдийн дотуур байр байгуулна.
- Хөдөө аж ахуй ба бэлчээр: 30 сумын түвшний болон бүсийн хоршоо, 5 хамгаалагдсан аж ахуй, 5 лаборатори байгуулж, 1,400 га талбайд 4 усалтын систем суурилуулан 28.8 сая га бэлчээр хамгаална.
- Төслийн үр дүнд 11,400 ажлын байрыг шууд, 150,000 ажлын байрыг дам байдлаар бий болгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Бэлчээрийн ачааллыг багасгана.
- Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.

## 51. Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2023** | **Зүүн, Хангай, Баруун, Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /Дэлхийн банк/ | **2028** | **Хэнтий, Сүхбаатар, Төв, Өвөрхангай, Архангай, Увс, Булган, Хөвсгөл** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **374.0 тэрбум ₮** | 1.4 тэрбум ₮ | 50.9 тэрбум ₮ | 160.8 тэрбум ₮ | 160.8 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

МУ-ын эдийн засаг уул уурхай, хөдөө аж ахуй, экспортын түүхий эдийн тээвэрлэлтийн салбарт төвлөрсөн бүтэцтэй бөгөөд дотоодын болон хил дамнасан тээвэр, логистикийн дэд бүтэц хангалтгүй байна. Зам, тээврийн сүлжээний холболт сул, логистикийн төвүүдийн нэгдсэн зохион байгуулалт дутмаг, тээврийн зардал өндөр байгаа нь экспорт, импортын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр замын нөхцөл сайжирч, орон нутагт аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбар хөгжих боломж нэмэгдэх ба малчид, оршин суугчид, жуулчид, дотоодын хүн тээвэр, ачаа тээврийн цаг хугацаа хэмнэх, тээврийн зардал буурах, тухайн орон нутгийг бусад газартай холбох, тээвэр, логистикийг сайжруулах ач холбогдолтой юм.

Төслийн зорилго, зорилт:

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй зам, тээврийн холболтыг сайжруулах замаар МУ-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (махны өртгийн сүлжээ)-ий тээврийн үр ашгийг сайжруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.09.30-ны байдлаар/*

- Нийт 208 км авто замын/Улаанбаатр-Өндөрхаан 68 км, Арвайхээр-Баянхонгор 35 км, Улаанбаатар-Арвайхээр 105 км, Өндөрхаан-Чойбалсан 50 км/ засварын ажлын талбайг хүлээж авсан.
- Өндөрхаан-Чойбалсан 50 км замын их засварын ажлын болон зам барилгын хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээ тус тус байгуулагдаж, ажлууд хийгдэж байна.
- 90 км авто зам болон 197.5 у/м 3 гүүрийн засварын 2 гэрээт ажилд шалгарсан гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулах шатандаа байна.
- Орон нутгийн чанартай Өвөрхангай аймгийн Ёсөнзүйл сум чиглэлийн 14.7 км хатуу хучилттай авто зам барих 1 гэрээт ажлын худалдан авах ажиллагааг зарласан. 4 гүүрийн зураг төсөл боловсруулах зөвлөх шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | - |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | - |

### Төслийн хүрэх үр дүн:

- Улсын чанартай нийт 361 км авто зам, нийт 1205у/м, 8 гүүрийг шинэчлэн сайжруулах засварын ажил хийгдэнэ.
- 51 км 2 сумыг холбох орон нутгийн чанартай авто зам барина.
- Төсөл хэрэгжих 8 аймагт оршин суух 146,711 малчин (98,400 малчин өрх) шууд ашиг хүртэнэ.
- Авто замын ашиглалтын нөхцөл сайжирснаар зорчих хугацаа одоо байгаагаас 30%-иар буурч, тээвэр логистикийн үйлчилгээний зардал 8 ам.доллараар буура.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр логистикийн үйлчилгээний зардал буурна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

# 52. Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2022** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /БНХАУ/ | **2026** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **106.57 тэрбум ₮** | 52.97 тэрбум ₮ | 53.60 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын авто зам, төмөр замын огтлолцлын бүсэд хөдөлгөөний түгжрэл их, ослын эрсдэл өндөр байгаа тул авто замын хөдөлгөөнийг саадгүй, тасралтгүй болгох шаардлагатай. Энэхүү нүхэн гарц нь төмөр замын хаалттай гармын аюулгүй байдлыг хангаж, тээврийн үр ашиг, зорчигчдын аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

### Төслийн ач холбогдол:

Улаанбаатар хотод төмөр замыг авто замтай өөр түвшинд буюу нүхэн гарцаар огтлолцуулах төслийг хэрэгжүүлсэнээр авто зам болон төмөр замын хөдөлгөөнийг саадгүй, үр ашигтай нэвтрэн өнгөрүүлэх, төмөр замын хаалттай гармын аюулгүй байдлыг бүрэн хангуулах ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Авто замын хөдөлгөөнийг саадгүй, үр ашигтай нэвтрэн өнгөрүүлэх мөн төмөр замын хаалттай гарам дээрх авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдал бүрэн хангагдана.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

**Нүхэн гарц-1** Таван шар, төмөр замын гарам - Дууссан
- Авто замын ажил бүрэн дуусаж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвртүүлж байна. Авто замын ажил бүрэн дуусаж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж байна.

**Нүхэн гарц-2** Геологийн төв лабораторийн уулзвар орчмын нүхэн гарц
- Зураг төсөл 90%, Барилга угсралтын ажил улирлын нөхцөл байдлаас үүдэн түр зогсолт хийсэн.

**Нүхэн гарц-3** Гермес төвийн урд, төмөр замын зоорины урд нүхэн гарц
- Зураг төсөл 80%, Барилга угсралтын ажил улирлын нөхцөл байдлаас үүдэн түр зогсолт хийсэн.

**Нүхэн гарц-4** Нарны зам болон Их хүрээний гудамжны нүхэн гарц
- Зураг төсөл 30%, Барилга угсралтын ажил эхлээгүй

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Улаанбаатар хотын 4 байршилд нүхэн гарц, авто зам, ногоон байгууламж, явган зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, инженерийн шугам сүлжээний ажлууд хийгдэнэ
- Төмөр замын хаалттай гармын эрсдэл багасч, зорчигч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал сайжирна.
- Хөдөлгөөний түгжрэл буурч, тээврийн үр ашиг нэмэгдэж, цаг хугацаа хэмнэгдэх болно.
- Хотын төв, эрчимтэй хөдөлгөөнтэй бүс нутгийн замын хүртээмж, дэд бүтцийн тогтвортой байдал сайжирна.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

## 53. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2020** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /БНФУ/ | **2027** | **Улаанбаатар хот** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтий н гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **260.0 тэрбум ₮** | 116.2 тэрбум ₮ | 143.8 тэрбум ₮ | - | - | - | - |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүжин тээврийг нэвтрүүлэх нь зорчих хугацааг богиносгож, байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэд бүтцийг бүрдүүлэх.

Төслийн ач холбогдол:

Дүүжин тээврийн төсөл нь нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулж, иргэдийн зорчих нөхцөлийг сайжруулах стратегийн ач холбогдолтой бөгөөд нийтийн тээврийн шинэ хэлбэр бий болж, зорчигч тээврийн сүлжээг тэнцвэржүүлэх, байгальд ээлтэй тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

- Эдийн засаг: Ажлын байр нэмэгдэнэ, түгжрэлээс үүдэлтэй эдийн засгийн хохирлыг бууруулна
- Хот төлөвлөлт, байгуулалт: Авто замын түгжрэл түүнээс шалтгаант орчны бохирдол буурна, нийтийн тээврийн шинэ төрөл нэвтэрнэ, аялал жуулчлал хөгжих, хотын дүр төрх сайжирна.

Төслийн зорилго, зорилт:

Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон төрлийн нийтийн тээврийн үйлчилгээ болон Улаанбаатар хотын дэд төвүүдийг хооронд нь холбох, авто замын түгжрэлийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны өдрийн байдлаар/*

- **ТЭЗҮ, зураг төсөв:** 100%
- **Барилга угсралтын гүйцэтгэл:** 40% /Туул голын ай сав газар байрлалтай тулгуур баганын шон суурийн өрөмдлөгийн ажил эхэлсэн, нийт 40 шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн/
- **Ерөнхий гүйцэтгэгч:** "ПОМА" групп

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Яармаг орчмын авто замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадвар 15%-иар нэмэгдэнэ.
- Нийслэлийн замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадвар 4%-иар нэмэгдэнэ.
- Иргэдийн зорчих хугацаа богиносож, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
- Хотын авто замын ачаалал буурч, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ багасна.
- Аялал жуулчлал, үйлчилгээний салбарт эдийн засгийн эерэг нөлөө үзүүлж, хотын орчны төлөвлөлт сайжирна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

## 54. Сэлбэ дэд төв орон сууцжуулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас** | **2029** | **Улаанбаатар хот, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1,934.9 тэрбум ₮** | - | 483.7 тэрбум ₮ | 483.7 тэрбум ₮ | 483.7 тэрбум ₮ | 483.7 тэрбум ₮ | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй иргэдийн дийлэнх нь анхан шатны дэд бүтэцгүй нөхцөлд амьдарч, агаарын бохирдлын ихэнх хувь нь яндангийн утаа, сул шорооноос үүдэлтэй байна. Иймд гэр хорооллын ачааллыг бууруулж, дэд бүтцийг сайжруулан, хотын хөрс, гүний усны бохирдлыг багасгах шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалт:
- 1260 хүүхдийн 3 блок сургууль
- 240 хүүхдийн 5 блок цэцэрлэг
- 100 ортой хэвтэн эмчлүүлэх эмнэлэг
- Өрхийн эмнэлэг, цагдаагийн хэлтэс
- Соёл олон нийтийн цогцолбор
- Спорт цогцолбор

#### Төслийн зорилго, зорилт:

Сэлбэ дэд төв орон сууцжуулах төсөл нь Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, гэр хорооллын иргэдэд орон сууц, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой. Төслийн хүрээнд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл спортын цогцолборуудыг байгуулж, орчны бохирдлыг бууруулан иргэдийн амьдрах орчинг сайжруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц: : */2025.10.23-ны өдрийн байдлаар/*

Тендер шалгаруулалтыг 1-4 багц болгон зарлаж, шалгаруулсан.
Багц-1
- **Ажлын явц: 28%**
- **Гүйцэтгэгч:** "Хоёр дахь металлурги групп корпораци"

Багц-2
- **Ажлын явц: 15%**
- **Гүйцэтгэгч:** "Барилгын зургаадугаар инженерийн товчоо"

Багц-3 болон Багц-4 ажлуудын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 8565 өрхийн орон сууц баригдана.
  Багц 1: 20 блок орон сууц
  Багц 2: 26 блок орон сууц
  Багц 3: 37 блок орон сууц
  Багц 4: 22 блок орон сууц
- Эхний төслийн хүрээнд 2868 яндан, цаашлаад 15,600 яндан цөөрнө.
- Эхний төслийн хүрээнд 2,206 нүхэн жорлон, цаашлаад 12,000 нүхэн жорлон цөөрнө.
- Гэр хорооллоос үүдэлтэй агаарын болон хөрсний бохирдлыг эхний ээлжид 1.4%, хэтдээ 6%-р буурна.

Үндсэн чиглэлийн үр дүн:
- Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

## 55. Баянхошуу дэд төв орон сууцжуулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2030** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1,444.9 тэрбум ₮** | 361.2 тэрбум ₮ | 108.4 тэрбум ₮ | 216.7 тэрбум ₮ | 325.1 тэрбум ₮ | 325.1 тэрбум ₮ | 108.4 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй иргэдийн дийлэнх нь анхан шатны дэд бүтэцгүй нөхцөлд амьдарч, агаарын бохирдлын ихэнх хувь нь яндангийн утаа, сул шорооноос үүдэлтэй байна. Иймд гэр хорооллын ачааллыг бууруулж, дэд бүтцийг сайжруулан, хотын хөрс, гүний усны бохирдлыг багасгах шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалт:
- 1260 хүүхдийн 3 блок сургууль
- 240 хүүхдийн 5 блок цэцэрлэг
- 100 ортой хэвтэн эмчлүүлэх эмнэлэг
- Өрхийн эмнэлэг, цагдаагийн хэлтэс
- Соёл олон нийтийн цогцолбор
- Спорт цогцолбор

#### Төслийн зорилго, зорилт:

Баянхошуу дэд төв орон сууцжуулах төсөл нь Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, гэр хорооллын иргэдэд орон сууц, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой. Төслийн хүрээнд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл спортын цогцолборуудыг байгуулж, орчны бохирдлыг бууруулан иргэдийн амьдрах орчинг сайжруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны өдрийн байдлаар/*

- **ТЭЗҮ-ийн явц: 19%**
- 162 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоосон
- Авто зам, дулаан, цахилгаан, холбоо, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үерийн хамгаалалтын далан, тохижилт ногоон байгууламжийн ажлууд хийгдсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 5000 айлын орон сууц баригдана.
- Түрээсийн болон түрээслэгчээд өмчлөх 2,816 өрхийн орон сууцны бүтээн байгуулалт бий болно.
- Эхний төслийн хүрээнд 2868 яндан, цаашлаад 15,600 яндан цөөрнө.
- Эхний төслийн хүрээнд 2,206 нүхэн жорлон, цаашлаад 12,000 нүхэн жорлон цөөрнө.
- Гэр хорооллоос үүдэлтэй агаарын болон хөрсний бохирдлыг эхний ээлжид 1.4%, хэтдээ 6%-р буурна.

Үндсэн чиглэлийн үр дүн:
- Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

## 56. Туулын хурдны зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын болон орон нутгийн төсөв** | **2028** | **Улаанбаатар хот, Баянзүрх, Баянгол, Сонгино-Хайрхан дүүрэг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **2,384.0 тэрбум ₮** | 500.0 тэрбум ₮ | 1,000.0 тэрбум ₮ | 442.0 тэрбум ₮ | 442.0 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Төслийн хүрээнд нийт 6 эгнээ 32 км хурдны зам, 9878 урт метр гүүрэн байгууламж шинээр баригдахаар төлөвлөгдсөн бөгөөд Улаанбаатар хотын гол болон туслах гудамж замын "VCR" 1.19 болж замын сүлжээний түгжрэл 10-20%-аар буурах, сүлжээний дундаж хурд 7-13км/ц байгааг 10-25 км/цаг болж нэмэгдэх урьдчилсан тооцоолол гарсан.

#### Төслийн ач холбогдол:

Туулын хурдны зам нь Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулж, тээврийн зардал, цаг хугацааг хэмнэх замаар эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна нийгмийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Улаанбаатар хотын төв болон туслах гудамжны замын түгжрэлийг бууруулж, иргэдэд илүү хурдан, аюулгүй, тав тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэн ажил, амралтын цагийг хэмнэж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. Мөн энэхүү төсөл нь тээврийн зардал болон цаг алдалтыг бууруулах замаар бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, хотын эдийн засгийн өсөлтийг тэнцвэртэй, тогтвортой болгоход бодитой хувь нэмэр оруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны өдрийн байдлаар/*

- **ТЭЗҮ-ийн явц:** 100%
- **Гүйцэтгэгч:** "ХаоЮань групп" ХХК
- **Барилга угсралтын ажлын гүйцэтгэл:** 5%

- Төслийн талбайн 4 байршилд түр зам барих ажил эхэлсэн, 11 дүгээр сард тус ажлыг бүрэн дуусгахаар ажиллаж байна.
- 2000 м.кв дайрга дэвсэж тэгшлэх, дам нурууны угсрах талбайг хусаж нягтруулах, 24000 м.куб хайрга дайрга дэвсэж тэгшлэх ажлууд бүрэн дууссан.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Улаанбаатар хотын замын түгжрэлийг 10-20%-иар бууруулна.
- Тээврийн дундаж хурдыг 7-13 км/цагас 10-25 км/цаг болгоно.
- Иргэдийн цагийг хэмнэн, амьдралын чанарыг сайжруулна.
- Тээврийн зардлыг бууруулж, эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- Нийгмийн үйлчилгээ болон аялал жуулчлалын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 7 орц гарцтай бөгөөд Улаанбаатар хотын төвийн хэсгийн ачааллыг хуваалцаж Нисэх, Яармагийн түгжрэлийг бууруулна.

#### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

# 57. Шинэ тойрог зам (1-р тойрог)

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2026** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас** | **2030** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **3,213.0 тэрбум ₮** | - | 200.0 тэрбум ₮ | 200.0 тэрбум ₮ | 200.0 тэрбум ₮ | 1,306.5 тэрбум ₮ | 1,306.5 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын замын ачааллыг бууруулж, хөдөлгөөний хурдыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн хотын төвлөрлийг сааруулж, иргэдэд аюулгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй юм.

### Төслийн ач холбогдол:

Тойрог зам нь нийтийн тээвэр, явган хүний зам болон дугуйн замын сүлжээг уялдуулах, ногоон байгууламж нэмэх, шинэ эдийн засгийн бүс үүсгэх зэрэг боломжийг бүрдүүлдэг ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Хотын төвлөрлийг бууруулж, замын хөдөлгөөний урсгалыг тогтвортой болгох. Иргэдэд аюулгүй, тав тухтай зорчих орчин бүрдүүлэх. Хотын дэд бүтцийг сайжруулахад хувь нэмэр оруулах.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- **ТЭЗҮ гүйцэтгэл: 100%**
- **Гүйцэтгэгч:** БНХАУ-ын ШУА-ийн Хотын хүрээлэн буй орчны судалгааны хүрээлэн болон Си-Эс-Си-И-Си Айком консалтантс ХХК
- Санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдэгдэж, тендерийн үйл ажиллагаа амжилттай явагдаж байна.
- Замын дэд бүтцийн холболт, газар шорооны ажил зарим хэсэгт эхэлсэн.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

Төсөл хэрэгжсэнээр
- Хотын төвийн замын хөдөлгөөний дундаж хурд 23.3 хувиар нэмэгдэнэ.
- Иргэдийн зорчих хурд 10-20 км/ц нэмэгдэх боломжтой болно
- Шууд бусаар нийт 14160, байнгын 3540 ажлын байр бий болно.
- Тээврийн зардал, цаг хугацаа хэмнэгдэж, эдийн засгийн бүтээмж нэмэгдэнэ
- Иргэдэд аюулгүй, тав тухтай зорчих нөхцөл бүрдэнэ
- Хотын дэд бүтцийн хөгжлийг дэмжинэ

Үндсэн чиглэлийн үр дүн:
- Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

## 58. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын болон орон нутгийн төсөв** | **2030** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **503.4 тэрбум ₮** | 30.0 тэрбум ₮ | 96.9 тэрбум ₮ | 94.0 тэрбум ₮ | 94.0 тэрбум ₮ | 94.0 тэрбум ₮ | 94.5 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Туул голын бохирдлыг бууруулах, байгаль орчны тэнцвэрийг хадгалах үүднээс үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх шаардлага тулгарч байна. Мөн малын гаралтай түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортын зах зээлийг өргөжүүлэх хэрэгцээ байна.

Төслийн ач холбогдол:

Уг төсөл нь газар тариалан, агуулах ойн аж ахуй, худалдааны төв, тээвэр логистик, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.

**Хөнгөн үйлдвэр:**
- 7.5 сая ширхэг арьс шир
- 3 мян.тн ноос
- 5.8 мян.тн ноолуур
- 25 мян.тн мах
- 8 мян.тн дайвар түүхий эд

**Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төв:**
- Арьс шир, ноос, ноолуур, мах, хүнс, дайвар бүтээгдэхүүн, гаалийн баталгаат агуулах
- Лаборатори, судалгаа шинжилгээний хүрээлэн
- Мод үржүүлгийн аж ахуй
- Хүлэмжийн аж ахуй
- Гаалийн хяналтын талбай
- Олон улсын тээвэр зуучлал

Төслийн зорилго, зорилт:

Дэлхийн жишигт нийцсэн хөдөө аж ахуйн паркийг байгуулах замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, эдийн засгийн өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортын чиг баримжаатай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

Дэд бүтцийн гүйцэтгэл
- **ДЦСтанц ТЭЗҮ:** 100%
- **Бохир ус цэвэрлэх байгууламж ТЭЗҮ:** 100%

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Нийт 5600 гаруй тогтвортой ажлын байрыг бий болгоно.
- Малаас гарч байгаа түүхий эдийг хаягдалгүй боловсруулж, импортыг орлох экспортыг нэмэгдүүлэх эцсийн бүтээгдэхүүн бий болгоно.
- Улаанбаатар хотын суурьшлын бүсэд үйл ажиллагаа эрхлэж буй 24 арьс,шир, ноос боловсруулах үйлдвэрүүдийг суурьшлын бүсээс нүүлгэн шилжүүлж төвлөрлийг бууруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

# 59. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | **Хэрэгжилтийн шатанд** | **Ашиглалтад орсон** |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам** | **2019** | **Зүүн болон Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2026** | **Хөвсгөл, Хэнтий аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **130.5 тэрбум ₮** | 61.7 тэрбум ₮ | 68.8 тэрбум ₮ | - | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсаас эко-аялал жуулчлалын хөгжлийг турших, хурдасгах таван газрыг сонгосны дотор Хөвсгөл аймагт байрлах Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар (ХНБЦГ), Хэнтий аймагт байрлах Онон-Балжийн байгалийн цогцолборт газар (ОББЦГ) хоёрыг нэн тэргүүлэх ач холбогдолтойд тооцсон. Гэвч тус бүс нутгуудад БЦГ-уудын менежмент, дэмжих дэд бүтэц хангалтгүй, аялал жуулчлалын хүртээмжтэй төлөвлөлт, үр өгөөж хязгаарлагдмал, хог хаягдлын зохистой менежмент байхгүй, санхүүжилтын хуваарилалт дутмаг байгаа тул экологийн болон соёлын сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлсэн.

### Төслийн ач холбогдол:

Төслийн хүрээнд Хөвсгөл, Хэнтий аймгуудад орших хоёр БЦГ-уудад дэд бүтэц, ариун цэврийн байгууламжийг сайжруулан, аялал жуулчлалын салбарын өсөлтөд тогтвортой менежмент хийх чадварыг нь дээшлүүснээр тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээн дэх эдийн засгийн хувьд хүртээмжтэй аялал жуулчлал, байгаль орчны хамгааллыг цогцлоосон жишиг БЦГ-ууд болгон өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх. Нутгийн орших суугчдын хүртэх үр өгөөж, байгалийн өв баялгийн хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байгууламжууд барих.

### Төслийн зорилго, зорилт:

Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний загварыг бий болгох, төсөл хэрэгжиж буй орон нутгийн байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

- Нутгийн иргэдэд түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт ба чадавхыг сайжруулах
- Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах
- Хог хаягдлын менежментийг сайжруулах
- Тусгай хамгаалалттай газрын менежментийг сайжруулах

## Төслийн Хэрэгжилтийн явц:

**Төслийн хэрэгжилтийн явц:** 75%.
Төслийн хүрээнд бүх худалдан авах ажиллагаа болон нийт 13 зорилтот ажлыг хэрэгжүүлж дууссан. Хоёр орон нутагт бодлогын баримт бичгүүд боловсруулах, 2600 орчим хүнийг хамруулан орон нутгийг чадавхжуулах, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлууд хийгдэж дууссан. Хог хаягдлын ландфилл болон бохир ус цэвэрлэх нийт 5-н байгууламжийг ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжөөр хангасан. Хөвсгөл аймгийн Ханх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг жишиг хэлбэрээр боловсруулж, орон нутагт хүлээлгэн өгсөн. 3-н байршилд бие даасан ариун цэврийн байгууламж барьж дуусгасан. Орон нутгийн оролцоотой нийт 6-н жижиг тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар 3-н зам болон барилга бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн гэрээт ажлыг захиалагч, зохиогчийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээнүүдийн хамт хэрэгжүүлж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Тусгай зөвшөөрөл | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолбор байгуулна.
- ХУТХГ-н Хамгаалалтын захиргаа ба жуулчдын мэдээллийн төвийн барилга барина.
- ХНБЦГ-т нэвтрэх төлбөр авах цэг барих
- Орон нутгийн санаачилга, оролцоотой 11-н жижиг төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.
- Хөвсгөл аймгийн “Ханх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2020-2040”, ХНБЦГ-ын, ОББЦГ-ын менежментийн төлөвлөгөө,” Дадал сумын аялал жуулчлалын төлөвлөгөө 2023-2032” боловсруулах, ХНБЦГ, ОББЦГ-ын Аялал жуулчлалын зөвлөл байгуулна.
- Эко-аялал жуулчлалын магадлан итгэмжлэлийн хөтөлбөр боловсруулж, 5-н жуулчны баазад нэвтрүүлнэ.
- 3,057 өрх буюу 11,009 мянган иргэн төслийн үр шимийг шууд хүртэнэ.
- Нийт 2685 орчим иргэн, албан хаагчдыг аялал жуулчлал, хог хаягдал, байгаль хамгааллын чиглэлээр мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, чадавхжуулах сургалтад хамруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлнэ.
- Зүүн бүс: Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

# 60. Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам** | **2025** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2029** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **118.0 тэрбум ₮** | 81.4 тэрбум ₮ | 3.2 тэрбум ₮ | 11.1 тэрбум ₮ | 11.1 тэрбум ₮ | 11.1 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Төв, суурин газарт ялангуяа Улаанбаатар хотод 2000 оноос эхлэн хөдөө орон нутгийн шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гэр хорооллын бүсүүд хурдацтай өргөжин бий болсон.Гэр хорооллын бүсэд байгалийн гамшигт өртөх эрсдэл нэмэгдэж, эрүүл аюулгүй амьдрах орчиноор хангагдах эрх нь хязгаарлагдмал, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломж хязгаарлагдмал байна.

### Төслийн ач холбогдол:

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаа нь агаар орчны бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх төвлөрөл, түгжрэлийг бууруулах ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Хот суурины экологи, эдийн засаг, нийгмийн хөгжил, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгох, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах таатай орон зайн орчныг бүрдүүлэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,247 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд 3,404 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн.
- Төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажилд 2013-2024 онд улс, нийслэлийн төсвөөс нийт 196.9 тэрбум төгрөгийг зарцуулсан.
- Нийслэл Улаанбаатар хотын 8 дүүрэгт 69 төсөл, бусад орон нутагт 8 төсөл хэрэгжиж, 2 төсөл сонгон шалгаруулах шатанд байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | - |

## Төслийн хүрэх үр дүн:

- Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаа нь агаар орчны бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх төвлөрөл, түгжрэлийг бууруулах

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хүн амыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана.
- Хүн амыг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.
- Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

# 61. Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **НЗДТГ** | **2025** | **Улаанбаатар** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын болон орон нутгийн төсөв** | **2027** | **Улаанбаатар хот** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **97.7 тэрбум ₮** | - | 48.8 тэрбум ₮ | 48.8 тэрбум ₮ | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улаанбаатар хотын хүн амын тал гаруй нь инженерийн дэд бүтэц хангалтгүй, утаа, хөрсний бохирдол өндөр, нийтийн үйлчилгээ дутмаг гэр хороололд амьдарч байна. Эдгээр асуудлаас үүдэн хотын төвлөрөл, замын түгжрэл, байгаль орчны доройтол ноцтой түвшинд хүрээд байна. Иймд гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах нь иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, бохирдлыг бууруулах, хотын төлөвлөлт, эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай арга хэмжээ юм.

### Төслийн ач холбогдол:

Нийслэл хотын иргэдийн амьдрах аятай орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэр хорооллын иргэдийн ахуй амьдралыг сайжруулах, хүрээлэн байгаа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын айл өрхийн янданг буулгаж, хүүхэд багачуудын сурч боловсрох нийгмийн дэд бүтэц бий болж, дэд бүтцээ дагаад ажлын байр нэмэгдэх боломжтой болно.

### Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, инженерийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, ажлын байр бүхий орчин үеийн орон сууцны шинэ хороолол болгон хөгжүүлэх замаар Улаанбаатар хотын иргэдийн амьдрах ая тух, хүрээлэн буй орчны чанарыг сайжруулахад оршино.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Зураг төсөл болон техникийн тодорхойлолт батлагдсан бөгөөд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил хэсэгчилэн эхэлсэн байна.
- 2013 оноос хойш Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийт 34 төсөл хэрэгжүүлэгч шалгаран төсөл хэрэгжүүлж байгаагаас инженерийн зураг төсөл бүхий 43 төсөл амжилттай хэрэгжиж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | X |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Төслийг хэрэгжүүлснээр гэр хорооллын айл өрхийн амьдрах орчин эрс сайжирч, инженерийн дэд бүтэцтэй орон сууцанд амьдрах боломж бүрдэнэ.
- Нийтийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ногоон байгууламжийн хүртээмж сайжирна.
- Барилга, дэд бүтэц, үйлчилгээний салбарт ажлын байр шинээр бий болж, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ.
- Хотын зохион байгуулалт сайжирч, төвлөрлийг бууруулах бодлого хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- Агаарын бохирдол, хөрсний доройтол буурч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Хүн амыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана.
- Хүн амыг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.
- Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

# 62. Улиастай-Алтай чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
| **Зам тээврийн яам** | **2026** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2029** | **Завхан, Говь-Алтай аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **171.81 тэрбум ₮** | - | 42.95 тэрбум ₮ | 42.95 тэрбум ₮ | 42.95 тэрбум ₮ | 42.95 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсад бүс нутгийн болон орон нутгийн замын чанар, холболт, засвар арчлалт хангалтгүй байгаа нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хязгаарлаж байна. Одоогийн авто замуудын ихэнх нь шороон болон хайрган хучилттай, цаг уурын нөлөөнд амархан эвдрэх, тээврийн саатал ихтэй байна.

### Төслийн ач холбогдол:

Төсөл нь Монгол Улсын орон нутгийн болон бүс нутгийн авто замын холболтыг сайжруулж, тээврийн үр ашиг, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой. CAREC 4A коридорын дагуух тээврийн сүлжээг сайжруулснаар ОХУ, БНХАУ-ын хил дамнасан эдийн засгийн урсгал нэмэгдэж, орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн боломж өргөжих юм. Мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгаль орчинд ээлтэй замын менежментийн тогтолцоог бий болгоно.

### Төслийн зорилго, зорилт:

Улсын чанартай авто замын ангилалд багтах Улиастай-Алтай чиглэлийн хөрсөн замыг хатуу хучилттай болгож сайжруулж авто замын тээврийн үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулж, бүс нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.09.30-ны байдлаар/*

2025 онд гүйцэтгэлийн хувийг 10%-15%-д хүргэхээр зам барилгын ажлыг гүйцэтгэж байна. Төслийн талбайд хийгдэж буй ажлууд:

- Үндсэн хөрс хуулалт
- Хадан хөрсөөр ул хөрсийг тогтворжуулах ажил
- Хоолойн суурийн ажлууд
- Гүүрийн ажлууд зэрэг

**Ажлын явц: 4.8%**

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | |
| ТЭЗҮ | |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- АН4 болон CAREC 4A олон улсын тээврийн коридорын дагуух сүлжээний холболт сайжирч, ОХУ, БНХАУ-ын хоорондын хил дамнасан худалдаа, эдийн засгийн урсгал нэмэгдэнэ.
- Бүс нутгийн тээвэр, логистик сайжирч, орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн оролцоо, бизнес, аялал жуулчлалын боломж нэмэгдэнэ.
- Олон улсын iRAP 3 одтой авто замын зэрэглэлд хүргэнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, үр ашигтай авто замын менежментийг сайжруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 63. Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2026** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2029** | **Ховд, Увс аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **234.4 тэрбум ₮** | - | 58.6 тэрбум ₮ | 58.6 тэрбум ₮ | 58.6 тэрбум ₮ | 58.6 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсад бүс нутгийн болон орон нутгийн замын сүлжээний чанар, холболт, засвар арчлалтын тогтолцоо хангалтгүй байгаа нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хязгаарлаж байна. Одоогийн авто замуудын ихэнх нь шороон болон хайрган хучилттай, цаг уурын нөлөөнд амархан эвдрэх, тээврийн саатал ихтэй байна.

### Төслийн ач холбогдол:

Төсөл нь Монгол Улсын орон нутгийн болон бүс нутгийн авто замын холболтыг сайжруулж, тээврийн үр ашиг, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой. CAREC 4A коридорын дагуух тээврийн сүлжээг сайжруулснаар ОХУ, БНХАУ-ын хил дамнасан эдийн засгийн урсгал нэмэгдэж, орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн боломж өргөжих юм. Мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгаль орчинд ээлтэй замын менежментийн тогтолцоог бий болгоно.

### Төслийн зорилго, зорилт:

Улсын чанартай авто замын ангилалд багтах Улиастай-Алтай чиглэлийн хөрсөн замыг хатуу хучилттай болгож сайжруулж авто замын тээврийн үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулж, бүс нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.09.30-ны байдлаар/*

- Төслийн талбайд хэмжилтийн ажлууд хийгдэж, зураг төслийг шинэчлэх ажил үргэлжилж байна. Үүний дагуу холбогдох газрын зөвшөөрлүүдийг орон нутгаас авсан ба кемп байгуулах, үйлдвэр заводуудыг байршуулах зэрэг бэлтгэл ажил үргэлжилж байна.
- Ховд-Улаангом чиглэлийн авто замын барилгын ажлыг 2026 оны 3 дугаар сарын 1-ний өдөр эхлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна.

**Ажлын явц: 0.0%**

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- АН4 болон CAREC 4A олон улсын тээврийн коридорын дагуух сүлжээний холболт сайжирч, ОХУ, БНХАУ-ын хоорондын хил дамнасан худалдаа, эдийн засгийн урсгал нэмэгдэнэ.
- Бүс нутгийн тээвэр, логистик сайжирч, орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн оролцоо, бизнес, аялал жуулчлалын боломж нэмэгдэнэ.
- Олон улсын iRAP 3 одтой авто замын зэрэглэлд хүргэнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, үр ашигтай авто замын менежментийг сайжруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 64. Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн 487.73 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
| **Зам тээврийн яам** | **2025** | **Говь, Хангайн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2032** | **Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **874.7 тэрбум ₮** | 62.4 тэрбум ₮ | - | 135.4 тэрбум ₮ | 135.4 тэрбум ₮ | 135.4 тэрбум ₮ | 135.4 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай аймгуудыг холбох Чойр–Мандалговь–Арвайхээр чиглэлийн авто зам нь зүүн, төв, баруун бүсийг холбох стратегийн ач холбогдолтой тээврийн шугам юм. Одоогийн замын даац, чанар хангалтгүйгээс тээвэр, зорчигч урсгал саатдаг, эдийн засгийн харилцаа, бараа бүтээгдэхүүний солилцоо хязгаарлагдаж байна.

### Төслийн ач холбогдол:

Төсөл хэрэгжсэнээр төвийн болон баруун бүсийн аймгуудыг холбосон үндэсний хэмжээний тээврийн коридор бий болж, дотоодын худалдаа, аялал жуулчлал, логистикийн сүлжээ өргөжих юм. Мөн аймгуудын хоорондын бараа, үйлчилгээний урсгал нэмэгдэж, бүс нутгийн эдийн засаг тэнцвэртэй хөгжих боломж бүрдэнэ.

### Төслийн зорилго, зорилт:

Бүс нутгийн авто замын сүлжээг өргөтгөх, улсын чанартай тээврийн коридор байгуулах, эдийн засгийн эргэлтийг хурдасгах, хүн амын хөдөлгөөнийг багасгах.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Эхний үе шатын барилгын ажил үргэлжилж байна.
**Говьсүмбэр – 6.7 км**
- Ажлын явц: 85.2%
- Гүйцэтгэгч: "Хүслэнт бүтээмж" ХХК

**Дундговь – 9.1 км**
- Ажлын явц: 62.0%
- Гүйцэтгэгч: "Мянган тэмүүлэл" ХХК

**Өвөрхангай – 6.1 км**
- Ажлын явц: 93.6%
- Гүйцэтгэгч: "Хулжийн голын зам" ХХК

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Баруун аймгуудаас Замын-Үүд рүү зорчихдоо Улаанбаатар хотоор дамжих шаардлагагүй болно.
- 200-400 орчим км дөт замаар ачаа бараа татаж, тээврийн зардал, цаг хугацаа хэмнэнэ.
- Төвийн болон баруун бүсийг холбосон үндэсний авто замын коридортой болно.
- Орон нутгийн эдийн засгийн идэвхжил, аялал жуулчлал, үйлчилгээний салбар өргөжнө.
- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил бий болно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 65. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** | **2025** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **38.4 тэрбум ₮** | 1.5 тэрбум ₮ | 2.6 тэрбум ₮ | 9.5 тэрбум ₮ | 9.5 тэрбум ₮ | 9.5 тэрбум ₮ | 5.8 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол орны нийт бэлчээрийн талбайн доройтол, нэгж талбайд ногдох малын тооны өсөлт, ашиглалтын ачаалал зэрэг нь усан хангамжийн хомсдолтой шууд холбоотой. Бэлчээрийн усны хүртээмж багатай бүс нутагт мал сүрэг төвлөрч, эргэлтийн менежмент алдагдан, хөрсний доройтол, ургамлын бүрхцийн алдагдал, цөлжилт нэмэгдэж байна. Одоогоор нийт 330 сумын ихэнх нь өвөл, хаврын бэлчээрт усны хомсдолтой, худаг, услах цэг дутагдалтай байна. Судалгаагаар өнөөдрийн байдлаар ашиглагдаж буй худгийн тоо 36,620 байгаа ч энэ нь нийт мал сүрийг усаар хангах, бэлчээрийн сэлгээг баримтлах, эргэлтийн нөөцийг ашиглахад хангалтгүй байна.

Төслийн ач холбогдол:

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр малчин өрх болон мал сүргийг найдвартай ундны эх үүсвэрээр хангах, нэг худгаас услах малын тоог цөөрүүлснээр бэлчээрийн эргэлтийн нөөцийг бүрэн ашиглах, даац хэтрэлтийг сааруулах нөхцөл бүрдэнэ.

Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, уст цэгийн зохистой менежментийг хэрэгжүүлэх замаар бэлчээрийн даац, эргэлтийн нөөцийг нэмэгдүүлэх, малчдын амьжиргааг дэмжих, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 21 аймаг, отрын бүс нутагт инженерийн хийцтэй 1000 гаруй худаг шинээр барьж ашиглалтад оруулснаар 3.0 орчим мал сүрэг, 5000 орчим малчин өрхийг усаар хангана.
- Бэлчээрийн нөөцийг бүрэн ашиглах, даац хэтрэлтийг сааруулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- 2020-2025 онд хөдөөгийн хүн, ам мал аж ахуйн ус хангамжийг сайжруулах ажлын хүрээнд улсын төсөв, орон нутаг, төсөл хөтөлбөрийн 53.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3017 худаг шинээр барьж ашиглалтад оруулсны үр дүнд 9.1 сая мал сүрэг, 15.7 мянган малчин өрхийг найдвартай ундны эх үүсвэрээр усаар хангах боломжийг бүрдүүлсэн.
- 2025 он хүртэл 1.5 тэрбум төгрөгийн төсвийн нийт 19 аймаг, отрын бүс нутагт инженерийн хийцтэй 46 шинээр барьж байгуулах ажлыг гүйцэтгүүлж байгаа ба санхүүжилтийн 80%-ийг олгосон.

# 66. “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хоёр-үе шаттай төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** | **2025** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2029** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **205.2 тэрбум ₮** | - | 51.3 тэрбум ₮ | 51.3 тэрбум ₮ | 51.3 тэрбум ₮ | 51.3 тэрбум ₮ | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Төсөл нь агробизнесийн аж ахуйн нэгжүүд технологи нэвтрүүлэхийг эрчимжүүлэх, нэн түрүүнд хөдөө аж ахуйн түүхий эдийн боловсруулалтын хүчин чадал, түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ингэснээр хөдөө аж ахуйн нөөцөд шингээх нэмүү өртгийг нэмэгдүүлнэ.

### Төслийн ач холбогдол:

Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн АА-н нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байр бий болгох, Монгол Улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах

### Төслийн зорилго, зорилт:

- 2030 он гэхэд Төсөлд оролцогч аж ахуйн нэгж (ТОААН)-үүд нийт борлуулалтад нэмүү өртөг шингэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бүтээгдэхүүний эзлэх хувийг 10%-р нэмэгдүүлнэ;
- ТОААН-үүд шинээр 1,500 ажлын байр бий болгоно (үүнээс 50% нь эмэгтэйчүүд: ур чадвар шаардсан 167, ур чадвар шаардахгүй 583 ажлын байрыг эмэгтэйчүүд нөхнө);
- Экспортын баримжаатай ТОААН-дийн экспорт 10%-иар өснө.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- АХБ-ны 57.1 сая ам.долларын санхүүжилтийн 89.3% буюу 51.0 сая ам.долларыг хүнс, хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээл олгохоор төлөвлөсөн.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | X |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Аж ахуйн нэгжүүд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хүчин чадал дээшилнэ.
- Нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалт хийгдэнэ.
- Малчид/фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал дээшилнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

## 67. "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** | **2022** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Ховд аймаг, Жаргалант сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **55.7 тэрбум ₮** | 40.6 тэрбум ₮ | 4.6 тэрбум ₮ | 5.2 тэрбум ₮ | 5.2 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бүлгийн 3.4.2-т заасан Баруун бүсэд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шинэ ховд үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар тусгасан.

#### Төслийн ач холбогдол:

Баруун бүс нийт мал сүргийн 24 орчим хувь буюу 15 орчим сая толгой малтай, түүхий эдийн нөөц бүрдүүлэх боломжтой болович төвийн үйлдвэрлэлийн бүсээс алслагдмал байдаг. Ховд аймгийн хувьд баруун бүсийн тулгуур төв, хилийн 2 боомттой ба бүтээгдэхүүнийг импортлох боломжтой.

#### Төслийн зорилго, зорилт:

Ховд аймгийн Жаргалант суманд хөнгөн үйлдвэрлэлийн технологийн парк байгуулж, малын гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулах, хүнсний болон барилгын материал үйлдвэрлэн баруун бүс нутгийн хэрэгцээг хангах, экспортлох, орон нутгийн иргэдийн байнгын тогтвортой ажлын байраар хангах.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 онд паркийн автозам, уурын дулааны станц, усан хангамж, саарал ус зайлуулах байгууламж, цахилгаан хангамж, мэдээлэл холбооны сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Тус 5 ажлын гүйцэтгэл 85.1 хувьтай.
- 2026, 2027 онд арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж, парк доторх цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажлыг гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

Тус төсөл нь хэрэгжсэнээр мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлж, баруун аймгуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг бий болгож дэвшилтэт техник технологи бүхий 19 үйлдвэр баригдан, нийт 51.8 сая долларын экспорт бий болж, ховд аймгийн ДНБ-нд 232 сая доллар, улсын төсөвт 30 орчим тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлэхээр урьдчилсан тооцоо гарсан.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

# 68. Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** | **2024** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Дархан-Уул аймаг, Хонгор сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **79.2 тэрбум ₮** | 23.8 тэрбум ₮ | 8.3 тэрбум ₮ | 15.0 тэрбум ₮ | 32.1 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг, нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулж, аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх.

### Төслийн ач холбогдол:

Уг төсөл нь импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний хэмжээний төсөл бөгөөд төсөл хэрэгжсэнээр нутаг дэвсгэрийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологийг нутагшуулах, ажлын байр бий болгох, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг стратегийн ач холбогдолтой юм

### Төслийн зорилго, зорилт:

Уг төсөл нь төрөөс шаардлагатай инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар үйлдвэрлэл, үйлчилгээний таатай орчныг бүрдүүлнэ.
Түүнчлэн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг, бохирдол ихээр ялгаруулдаг анхан шатны боловсруулалтын үйлдвэрүүдийг оролцуулахгүй байх бодлогыг баримталж, байгальд ээлтэй, инновац, технологид тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг 2025 онд эхлүүлсэн бөгөөд Төслийн гадна авто замын ажлын гүйцэтгэл 84,5 хувь, гадна холбоо дохиоллын ажил 70 хувьтай явагдаж байна.
- Өмнө хийгдсэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон ТЭЗҮ, БОНБҮ зэрэгт үндэслэн Төвийн бүсийн хүнс, хөнгөн ҮТП-ын хөгжлийн төлөвлөгөө, ТЭЗҮ, БОНБҮ-г шинэчлэн боловсруулах ажил, Төслийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт, өндөржилт, картограммын өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээг байгуулан, гэрээт ажлыг гүйцэтгэж байна.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

Уг төслийг хэрэгжүүлсний үр дүнд төвийн бүсийн үйлдвэрлэл, технологийн дэд бүтэц иж бүрнээр бүрдэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн идэвх сэргэнэ. Үүний зэрэгцээ дараах бодит үр дүн гарна:

- 500–1000 хүртэл байнгын ажлын байр шинээр бий болно.
- Бүс нутгийн ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, иргэдийн орлого, орон нутгийн татварын орлого өснө.
- Байгальд ээлтэй, технологид суурилсан үйлдвэрүүдийг дэмжсэнээр байгаль орчны бохирдол буурна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

## 69. "Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл"-ийн II үе шат

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /ХААХОУС/ | **2029** | **Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Хэнтий аймаг** |

| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **36.7 тэрбум ₮** | - | - | 12.2 тэрбум ₮ | 12.2 тэрбум ₮ | 12.2 тэрбум ₮ | - |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Мал аж ахуйн үйлдвэрлэл дотоодын нийт бүтээгдэхүүний 20-иос дээш хувийг бүрдүүлдэг боловч малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин хангалтгүй, нийлүүлэлтийн ба өртгийн сүлжээ сул хөгжсөн, малын тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй зэрэг ас уудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Төслийн ач холбогдол:

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх замаар бэлчээрийн мал аж ахуйн бүтээмж, эрсдэл даван туулах чадварыг нэмэгдүүлэх, орон нутагт малын гаралтай бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлж, малчдын бүлэг, хоршоодыг зах зээлд холбох, хөнгөлөлттэй зээлд хамруулах, мэдлэг чадвар олгох, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг цогцоор нь хэрэгжүүлэх нь мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, малчдын амьжиргааг дэмжих юм.

Төслийн зорилго, зорилт:

"Зах зээл ба бэлчээрийн удирдлага"" төслийн II үе шат нь эхний үе шатны хүрсэн амжилт, үр шимийг өргөжүүлэх, малын тэжээлийн болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах замаар малчдын зудын эрсдэл тэсвэрлэх, даван туулах чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн (IFAD) санхүүжилтээр “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг Архангай, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймагт 2018-2023 онуудад хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд 22 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 16 тэрбум төгрөгийг төслийн зээлийн эх үүсвэрээс, 6.6 тэрбум төгрөгийг орон нутгаас санхүүжүүлсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | X |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- 5000 малчин өрхийн малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлж, хоршоолсон хэлбэрээр жижиг, бичил бизнес эрхлэх 40 дэд төсөлд 5000 малчин өрхийг хамруулж, эдгээр 40 хоршоонд хөнгөлөлттэй зээл олгоно.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.

## 70. Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн 179.7 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Хэнтий аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **216.98 тэрбум ₮** | 31.0 тэрбум ₮ | 40.0 тэрбум ₮ | 36.5 тэрбум ₮ | 36.5 тэрбум ₮ | 36.5 тэрбум ₮ | 36.5 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Сум, тосгодыг шууд холбож, урт зам давах бүс нутгийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү зам нь иргэдийн зорчих нөхцөл, бараа бүтээгдэхүүний урсгалыг түргэн, аюулгүй болгоход чиглэгдсэн.

Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор алслагдсан бүс нутгийн эдийн засгийн идэвх нэмэгдэж, орон нутгийн жижиг, дунд бизнес, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал өргөжинө. Мөн замын инженерийн шийдлүүд нь тээврийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг баталгаажуулж, бүс нутгийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.

Төслийн зорилго, зорилт:

Бор–Хэрлэн чиглэлийн сумдыг чанартай, аюулгүй авто замаар холбож бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжихээс гадна замын дэд бүтцийг сайжруулах, тээврийн тасралтгүй байдлыг хангах, орон нутгийн хөгжлийг түргэсгэх, байгаль орчинд ээлтэй шийдлүүдийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 23.4%**
- **Гүйцэтгэгч:** "Танкштел" ХХК

Багц-2
- **Ажлын явц: 18.3%**
- **Гүйцэтгэгч:** "Ганбүрд" ХХК

Багц-3
- **Ажлын явц: 14.0%**
- **Гүйцэтгэгч:** "Тэгш плант" ХХК

Багц-4
- **Ажлын явц: 19.6%**
- **Гүйцэтгэгч:** "Хөвчийн зам" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Урт, хатуу хучилттай зам нь тасралтгүй, аюулгүй тээвэрлэлтийг хангаж, орон нутгийн иргэдийг тав тухтай зорчуулна.
- Замын ашиглалтаас орон нутгийн жижиг, дунд бизнес, худалдаа, үйлчилгээ идэвхжиж, эдийн засгийн урсгал нэмэгдэнэ.
- Аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ боломж нээгдэж, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 71. Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Хэнтий аймаг** |

| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **58.7 тэрбум ₮** | 21.5 тэрбум ₮ | 22.2 тэрбум ₮ | 7.5 тэрбум ₮ | 7.5 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Сумдыг шууд холбож, бүс нутгийн худалдаа, тээвэр ложистикийн урсгалыг дэмжих шаардлагатай. Энэхүү зам нь урт зам давах орон нутгийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн тасралтгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн.

### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор алслагдсан сум, тосгодын эдийн засгийн идэвх эрчимжиж, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт түргэн шуурхай болно. Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ боломж нээж, бүс нутгийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### Төслийн зорилго, зорилт:

Жаргалтхаан–Биндэр чиглэлийн сумдыг чанартай, аюулгүй авто замаар холбож бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжих явдал юм. Зорилт нь замын дэд бүтцийг сайжруулах, тээврийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг түргэсгэх, байгаль орчинд ээлтэй шийдэл хэрэгжүүлэхэд чиглэнэ.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 95.6%**
- **Гүйцэтгэгч:** "Наранбулагхан" ХХК
- **Замын урт:** 27.42км

Багц-2
- **Ажлын явц: 79.5%**
- **Гүйцэтгэгч:** "Тэгш Плант" ХХК
- **Замын урт:** 28.77км

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Замын урт, хатуу хучилт нь аюулгүй, тасралтгүй тээврийн урсгалыг бүрдүүлж, алслагдсан бүс нутгийг дэмжинэ.
- Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт түргэн шуурхай болж, орон нутгийн жижиг, дунд бизнесийн хөгжлийг идэвхжүүлнэ.
- Замын ашиглалтаас үүдэн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ боломж нээгдэнэ.
- Онцгой инженерийн шийдлүүд (давхар түвшний гарц, давааны засвар зэрэг) замын аюулгүй байдал, тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 72. Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн 152.5 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Зүүн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Хэнтий аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **263.60 тэрбум ₮** | 16.5 тэрбум ₮ | 23.9 тэрбум ₮ | 55.8 тэрбум ₮ | 55.8 тэрбум ₮ | 55.8 тэрбум ₮ | 55.8 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

Төслийн хэрэгцээ шаардлага:

Жаргалтхаан–Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр хүртэлх 152.5 км хатуу хучилттай авто зам нь сумдыг шууд холбож, бүс нутгийн худалдаа, тээвэр ложистикийн урсгалыг дэмжихээс гадна энэхүү зам нь урт зам давах орон нутгийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн тасралтгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн.

Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор алслагдсан сум, тосгодын эдийн засгийн идэвх эрчимжиж, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт түргэн шуурхай болно. Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ боломж нээж, бүс нутгийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Төслийн зорилго, зорилт:

Жаргалтхаан–Биндэр чиглэлийн сумдыг чанартай, аюулгүй авто замаар холбож бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжихээс гадна замын дэд бүтцийг сайжруулах, тээврийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг түргэсгэх, байгаль орчинд ээлтэй шийдэл хэрэгжүүлэхэд чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 5.6%** **Гүйцэтгэгч:** "Борхойн зам" ХХК

Багц-2, 5
- **Ажлын явц:** Гүйцэтгэгч шалгараагүй байна.

Багц-3
- **Ажлын явц: 4.1%** **Гүйцэтгэгч:** "Түм ариважих" ХХК

Багц-4
- **Ажлын явц: 63.7%** **Гүйцэтгэгч:** "Их хайрханы харгуй" ХХК

Багц-6
- **Ажлын явц: 4.1%** **Гүйцэтгэгч:** "Их хайрханы харгуй" ХХК

Багц-7
- **Ажлын явц: 27.5%** **Гүйцэтгэгч:** "Тэргүүн саруул зам" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Жаргалтхаан–Биндэр чиглэлийн 152.5 км авто зам ашиглалтад орж, бүс нутгийн сум, тосгодыг шууд холбосон үндсэн тээврийн гол чиглэл болно.
- Замын урт, хатуу хучилт нь аюулгүй, тасралтгүй тээврийн урсгалыг бүрдүүлж, алслагдсан бүс нутгийг дэмжинэ.
- Замын ашиглалтаас үүдэн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ боломж нээгдэнэ.
- Онцгой инженерийн шийдлүүд (давхар түвшний гарц, давааны засвар зэрэг) замын аюулгүй байдал, тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 73. Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто замын дуусгал

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Орхон, Булган аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **103.60 тэрбум ₮** | 20.9 тэрбум ₮ | 19.7 тэрбум ₮ | 31.5 тэрбум ₮ | 31.5 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Сумдын хоорондын тээврийн урсгалыг нэмэгдүүлэх, орон нутгийн хүн ам болон аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүний хүргэлтийг сайжруулах шаардлагатай. Энэхүү зам нь бүс нутгийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор иргэдийн зорчих нөхцөл аюулгүй, тав тухтай болох бөгөөд худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын идэвх нэмэгдэнэ. Мөн орон нутгийн эдийн засгийн урсгал өргөжиж, бүс нутгийн хөгжлийн тэнцвэр хангагдана.

#### Төслийн зорилго, зорилт:

Орхон–Гурванбулаг сумдыг чанартай авто замын сүлжээгээр холбож, тогтвортой тээврийн орчныг бүрдүүлэхээс гадна дэд бүтцийн чанарыг сайжруулах, тээврийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийг дэмжихэд чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 82.5 %**
- **Гүйцэтгэгч:** "РЭС" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Хойд болон төвийн бүсийн аялал жуулчлал, зорчигчдын урсгалыг дэмжиж, бүсчилсэн хөгжлийн орон нутгийн хөгжлийн төвүүдийг дэмжинэ.
- Орхон–Хишиг–Өндөр–Гурванбулаг сумыг шууд, чанартай авто замаар холбож бүс нутгийн дэд бүтцийн интеграцийг сайжруулна.
- Замын инженерийн шийдлүүд нь аюулгүй, тогтвортой зорчих нөхцөлийг баталгаажуулна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 74. Орхонтуул-Цээл чиглэлийн 62.56 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Хойд бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Сэлэнгэ аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **118.45 тэрбум ₮** | 28.59тэрбум ₮ | 25.0 тэрбум ₮ | 32.43 тэрбум ₮ | 32.43 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Орон нутгийн сум, тосгодыг улсын авто замын сүлжээнд холбох, тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү зам нь иргэдийн зорчих нөхцөлийг сайжруулж, эдийн засгийн идэвхийг дэмжихэд чухал үүрэгтэй.

#### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үр ашиг нэмэгдэж, орон нутгийн худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарууд хөгжих давуу талтай. Мөн хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангана.

#### Төслийн зорилго, зорилт:

Орхонтуул болон Цээл сумдыг чанартай авто замын сүлжээгээр холбож, тогтвортой тээврийн нөхцөлийг бүрдүүлэх явдал нь замын дэд бүтцийг сайжруулах, орон нутгийн эдийн засгийг дэмжих, байгальд ээлтэй, аюулгүй замын шийдлүүдийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 16.6 %**
- **Гүйцэтгэгч:** "Билэгт зам" ХХК
- Захиалагч, гүйцэтгэгч хоорондын гэрээ байгуулсан бөгөөд талбайд хэмжилт хийгдсэн нүүлгэн шилжүүлэлт хийгдэж байна.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Тээврийн урсгал сайжирч, зорчих нөхцөл аюулгүй, найдвартай болно.
- Бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт түргэсэж, тээврийн зардал буурна.
- Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын идэвх нэмэгдэнэ.
- Замын дэд бүтцийн чанар сайжирч, бүс нутгийн хөгжлийн тэнцвэр хангагдана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 75. Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн 28.5 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Хангайн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Архангай аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **44.9 тэрбум ₮** | 17.9 тэрбум ₮ | 13.0 тэрбум ₮ | 14.0 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Өгийнуур–Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн 28.5 км хатуу хучилттай авто зам нь сумыг улсын чанартай авто замын сүлжээнд холбох, тээвэр логистикийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү зам нь орон нутгийн хүн ам, аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөний нөхцөлийг сайжруулахад чиглэнэ.

#### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор аймаг, сумдын хоорондын харилцаа, худалдаа, үйлчилгээ идэвхжиж, нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжинэ. Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлт сайжирч, бүс нутгийн хөгжилд шинэ боломж нээгдэнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Өгийнуур сумыг Мянганы замтай холбож, тогтвортой, аюулгүй тээврийн урсгалыг бүрдүүлэхэд оршино. Үүнд дэд бүтцийн чанар, найдвартай байдлыг сайжруулах, бүс нутгийн хөгжлийн нэгдмэл байдлыг хангах, байгальд ээлтэй шийдэл хэрэгжүүлэх зорилтууд багтана.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 8.0 %**
- **Гүйцэтгэгч:** "Саруул харгуй" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.
- Тээврийн урсгал, зорчих нөхцөл сайжирч, хөдөлгөөний аюулгүй байдал нэмэгдэнэ.
- Тээврийн зардал буурч, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт түргэснэ.
- Замын дэд бүтэц, чанар сайжирч, бүс нутгийн хөгжлийн тэнцвэр хангагдана.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 76. Солонготын давааны 12.08 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Завхан аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **46.3 тэрбум ₮** | 18.5 тэрбум ₮ | 26.9 тэрбум ₮ | 0.8 тэрбум ₮ | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Солонготын давааны 12.08 км хатуу хучилттай авто зам нь энэ чиглэлд байдаг хүндрэлтэй, осол ихтэй хэсгийг шинэчлэн сайжруулах шаардлагатай. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээврийн тасралтгүй урсгалыг бүрдүүлэх зорилготой.

### Төслийн ач холбогдол:

Төслийг хэрэгжүүлснээр тухайн бүсийн замын чанар сайжирч, тээврийн зардал буурах, иргэдийн зорчих нөхцөл аюулгүй, тав тухтай болох ач холбогдолтой. Мөн аймаг, бүс хоорондын эдийн засаг, нийгмийн харилцаа өргөжихөд дэмжлэг үзүүлнэ.

### Төслийн зорилго, зорилт:

Солонготын даваагаар дамжих авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлж, чанартай дэд бүтцийг бүрдүүлэхэд оршино. Үүнд замын техникийн үзүүлэлтийг сайжруулах, урсгал хөдөлгөөний чадавхыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтууд багтана.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 50.71%**
- **Гүйцэтгэгч:** "Гранд макро зам" ХХК

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Улсын чанартай орон нутгийн замын сүлжээ сайжирна.
- Аймаг хоорондын дамжин өнгөрөх тээврийн хөдөлгөөний чөлөөтэй, аюулгүй холболтыг сайжруулна.
- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 77. Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.18 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Хангайн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Баянхонгор аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **66.7 тэрбум ₮** | 17.3 тэрбум ₮ | 42.9 тэрбум ₮ | 6.5 тэрбум ₮ | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Аймгийн төв болон Шаргалжуутын рашаан, сувиллын бүсийн хүртээмжийг сайжруулах, зорчих нөхцөлийг боловсронгуй болгох шаардлагатай. Энэ нь эрүүл мэнд, аялал жуулчлалын чиглэлээр өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах үндэс болно.

### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор рашаан сувилалд зорчих иргэдийн урсгал нэмэгдэж, үйлчилгээний салбар хөгжих, орон нутгийн эдийн засагт шинэ боломж бий болно. Мөн тээврийн найдвартай байдлыг хангаж, бүсийн хөгжилд шууд нөлөө үзүүлнэ.

### Төслийн зорилго, зорилт:

Баянхонгор аймгийн аялал жуулчлал, эрүүл мэндийн чиглэлийн дэд бүтцийг сайжруулж, бүс нутгийн хөгжлийг дэмжихээс гадна авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, орон нутгийн эдийн засгийн урсгалыг нэмэгдүүлэх, чанартай замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 34.5%**
- **Гүйцэтгэгч:** "Бридж бюлдинг" ХХК, "Их богд зам" ХХК
- **Замын урт:** 25км

Багц-2
- **Ажлын явц: 34.2%**
- **Гүйцэтгэгч:** "Их харгуйн зам" ХХК, "Бридж бюлдинг" ХХК "Их богд зам" ХХК
- **Замын урт:** 29км

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.
- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 78. Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2022** | **Төвийн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2028** | **Төв аймаг** |

| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **182.5 тэрбум ₮** | 30.0 тэрбум ₮ | 80.1 тэрбум ₮ | 36.2 тэрбум ₮ | 36.2 тэрбум ₮ | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хучилттай авто зам нь эдгээр сумдын хоорондын хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоог сайжруулах зайлшгүй шаардлагатай. Төслийг хэрэгжүүлснээр орон нутгийн дэд бүтцийн хүртээмж нэмэгдэж, аймгийн төв болон бусад бүс нутгуудтай холбогдох замын сүлжээ бүрдэнэ.

### Төслийн ач холбогдол:

Зам ашиглалтад орсноор тээврийн зардал буурч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа өргөжих, иргэдийн нийгэм, эдийн засгийн боломж нэмэгдэх ач холбогдолтой. Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын хөгжилд түлхэц өгнө.

### Төслийн зорилго, зорилт:

Төв аймгийн сумдыг чанартай авто замын сүлжээгээр холбож, бүсийн хөгжлийн тэнцвэрийг хангах явдал юм. Үүнд тээврийн аюулгүй байдлыг сайжруулах, орон нутгийн эдийн засгийг дэмжих, байгальд ээлтэй замын бүтээн байгуулалт хийх зорилтууд багтана.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 63.5%**
- **Гүйцэтгэгч:** "Туулын Гүүр Далай" ХХК болон "Үри Констек" ХХК түншлэл

Багц-2
- **Ажлын явц: 90.0%**
- **Гүйцэтгэгч:** "Ди Вай Кей Би" ХХК

Багц-3
- **Ажлын явц: 74.2%**
- **Гүйцэтгэгч:** "Билэгт Зам" ХХК

Багц-4
- **Ажлын явц: 56.0%**
- **Гүйцэтгэгч:** "Үйлсийн Зам" ХХК

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

### Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 79. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх 43.3 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Хангайн бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Өвөрхангай аймаг** |

| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **69.5 тэрбум ₮** | 22.4 тэрбум ₮ | 38.6 тэрбум ₮ | 8.5 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Сумын хүн ам, аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөн, тээвэр ложистикийн урсгалыг сайжруулах, аймаг, нийслэлтэй холбогдох замын сүлжээг бүрэн болгох шаардлагатай. Энэхүү зам нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тулгамдаж буй тээврийн саадыг арилгах зорилготой юм.

#### Төслийн ач холбогдол:

Зам баригдсанаар аялал жуулчлал, үйлчилгээний салбар хөгжиж, нутгийн эдийн засагт шинэ боломж нээгдэнэ. Мөн бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт хялбаршиж, иргэдийн амьдралын чанар дээшлэх давуу талтай.

#### Төслийн зорилго, зорилт:

Төслийн зорилго нь Хужирт сумыг улсын чанартай замын сүлжээнд холбож, хөдөлгөөний аюулгүй, найдвартай орчныг бүрдүүлэхэд оршино. Үүнд дэд бүтцийн чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих, байгальд ээлтэй инженерийн шийдлийг хэрэгжүүлэх зорилтууд багтана.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Багц-1
- **Ажлын явц: 48.9%**
- **Гүйцэтгэгч:** "Өндөрсант хайрхан" ХХК

Багц-2
- **Ажлын явц: 43.9%**
- **Гүйцэтгэгч:** "ЗБИБ" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 80. Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн 66 км хатуу хучилттай авто замын дуусгал

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2025** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **Баян-Өлгий аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **163.7 тэрбум ₮** | 29.8 тэрбум ₮ | 23.0 тэрбум ₮ | 27.7 тэрбум ₮ | 27.7 тэрбум ₮ | 27.7 тэрбум ₮ | 27.7 тэрбум ₮ |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Баруун бүсийн сумдын хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний урсгалыг нэмэгдүүлэхэд оршино. Энэхүү зам нь иргэдийн зорчих нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулж, бүс нутгийн хөгжлийг тэтгэх чухал дэд бүтэц болно.

#### Төслийн ач холбогдол:

Бүс нутгийн хүн, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хугацааг богиносгож, эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн иргэдийн амьдрах орчны чанарыг сайжруулж, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын боломжийг өргөжүүлнэ.

#### Төслийн зорилго, зорилт:

Баруун бүсийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, сумдын хөгжлийн тэнцвэрийг хангах явдал юм. Үүний хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй бүтээн байгуулалт хийх, орон нутгийн эдийн засгийн урсгалыг дэмжих зорилтуудыг хэрэгжүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 39.8%**
- **Гүйцэтгэгч:** "Чайна Роуд энд Бридж Корпорейшн" ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд ээлхэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 81. Ховд-Дөргөн сум чиглэлийн 40.7 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Ховд аймаг** |

| **нийт төсөвт өртөг:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **49.8 тэрбум ₮** | 19.2 тэрбум ₮ | 25.1 тэрбум ₮ | 5.5 тэрбум ₮ | - | - | - |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Орон нутгийн хүн амын ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг сайжруулах, тээвэр логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой. Энэхүү зам нь аймгийн төв болон сумдын хоорондын эдийн засаг, нийгмийн харилцааг өргөжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний эргэлтийг түргэсгэх чухал ач холбогдолтой юм.

### Төслийн ач холбогдол:

Шинэ авто зам нь орон нутгийн эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлж, ажиллах хүчний хөдөлгөөнийг хөнгөвчлөх болно. Тээвэрлэлтийн зардал буурч, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж сайжрахын зэрэгцээ бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийг дэмжинэ. өн иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, хот хоорондын холболтыг сайжруулах ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Авто замын аюулгүй, тогтвортой үйл ажиллагааг хангаж, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах. Эдийн засгийн үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээний идэвхийг дэмжин, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхээс гадна орон нутгийн тээвэрлэлтийн хүртээмжийг сайжруулж, иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөхөд оршино.

## Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 36.9%**
- **Гүйцэтгэгч:** "ТОЁО" ХХК болон "Си Эйч Би энд Коллеги" ХХК болон "Алтай Рөүд" ХХК түншлэл

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 82. Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох 32.4 км хатуу хучилттай авто зам

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Ховд аймаг** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **32.4 тэрбум ₮** | 11.6 тэрбум ₮ | 15.7 тэрбум ₮ | 5.1 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Цэцэг сум хатуу хучилттай авто замгүйгээс үүдэн тээврийн зардал өндөр, иргэдийн хөдөлгөөний боломж хязгаарлагдмал байна. Мөн замын чанар муудаж, онцгой нөхцөлд аюулгүй байдлын эрсдэл үүсдэг. Үүнээс үүдэн орон нутгийн эдийн засаг, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага бий болсон

#### Төслийн ач холбогдол:

Нутгийн аялал жуулчлал, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжиж, бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгана. Мөн осол аваарын эрсдэлийг бууруулж, орон нутгийн амьдралын чанарыг сайжруулахад чухал нөлөөтэй.

#### Төслийн зорилго, зорилт:

Цэцэг сумыг хатуу хучилттай авто замтай холбож, аюулгүй, хурдан тээврийн нөхцлийг бүрдүүлэх ба бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжил, аялал жуулчлалын орчныг сайжруулахад чиглэнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

- **Ажлын явц: 35.5%**
- **Гүйцэтгэгч:** “ГЦЦЭ” ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Замын чанар сайжирснаар онцгой нөхцөлд аюулгүй байдал нэмэгдэж, ослын эрсдэл багасна.
- Орон нутгийн эдийн засаг, худалдаа үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ажил эрхлэлтийн боломж өргөжнө.
- Аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

## 83. Увс нуур-Улаангом чиглэлийн 26.39 км хатуу хучилттай авто замын эхний үе шат

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Зам тээврийн яам** | **2024** | **Баруун бүс** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2027** | **Увс, Улаангом сум** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **46.6 тэрбум ₮** | 7.6 тэрбум ₮ | 30.5 тэрбум ₮ | 8.5 тэрбум ₮ | - | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага:

Увс нуур-Улаангом чиглэлийн зам хуучирч муудсаны улмаас аялал жуулчлалын хөдөлгөөнийг дэмжих боломж хязгаарлагдаж, зорчих нөхцөл хүндрэлтэй байна. Тиймээс бүс нутгийн аялал жуулчлалын чадавхийг нэмэгдүүлж, аюулгүй, тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

#### Төслийн ач холбогдол:

Замын шинэчлэл нь бүс нутгийн эдийн засгийн хөгжилд түлхэц өгөх бөгөөд худалдаа, аялал жуулчлалын боломжийг нэмэгдүүлнэ. Иргэдийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулж, хөдөлгөөний саатал, ослын эрсдлийг бууруулна. Улсын стратегийн чухал тээвэрлэлт, логистикийн зангилаа болох тул бүс нутгийн нийгэм, эдийн засгийн амьдралыг сайжруулна.

#### Төслийн зорилго, зорилт:

Энэхүү төсөл нь Увс нуур-Улаангом чиглэлийн замыг шинэчилж, аюулгүй, тав тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Мөн аялал жуулчлалыг дэмжиж, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

### Төслийн Хэрэгжилтийн явц: */2025.10.23-ны байдлаар/*

Одоогийн байдлаар Увс нуур-Улаангом чиглэлийн 26.39 км хатуу хучилттай авто замын зураг төсөл болон техникийн тодорхойлолт батлагдсан байна. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангагдаж, зарим хэсэгт суурь ажил хэсэгчилэн хийгдэж байна.

- **Ажлын явц: 87.7%**
- **Гүйцэтгэгч:** “НКВ холдинг” ХХК

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Санхүүжилт | ✓ |
| Гэрээ | ✓ |

### Төслийн хүрэх үр дүн:

- Байгаль, түүхийн аялал жуулчлалын бүсүүдэд хүрэх хүртээмж сайжирна.
- Орон нутгийн бизнес, үйлчилгээний салбарын хөгжилд шинэ боломж нээгдэнэ.
- Аялал жуулчлалын хөдөлгөөн нэмэгдэж, бүс нутгийн эдийн засаг эрчимжинэ.
- Зорчигчдын аюулгүй, тав тухтай зорчих нөхцөл бүрдэнэ

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.

# 5. НОГООН ХӨГЖИЛ, ЗАСАГЛАЛ

## НОГООН ХӨГЖИЛ

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зуд, усны нөөцийн хомсдол, цөлжилт, байгаль орчны доройтол хурдтай нэмэгдсээр байна. Сүүлийн 84 жилийн хугацаанд Монгол орны дундаж температур 2.5 хэмээр дулаарч, нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилт, газрын доройтолд өртсөн бөгөөд сүүлийн 20 жилд гамшигт үзэгдлийн давтамж 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад өндөр ач холбогдол бүхий ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нийт нутгийн дөнгөж 8.2 хувийг эзэлж байгаа нь манай улсын уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Улмаар байгалийн гамшигт үзэгдлийн давтамж олширч, түүний дээр улсын гамшгийн бэлэн байдал, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах чадавх дутмаг байгаа нь иргэдийн аж амьдрал, эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Уур амьсгалын эдгээр хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр Монгол Улс "Үндэсний дасан зохицох төлөвлөгөө" (NAP) болон "Үндэсний тодорхойлсон хувь нэмэр" (NDC) зэрэг баримт бичгийг Парисын хэлэлцээрийн дагуу баталсан. Үүний хүрээнд ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох төслүүдийг 2026-2030 оны Улсын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөрт тусгахыг зорьсон. Тухайлбал, Эрчим хүчний шинэчлэл бүлэгт: "Эрдэнэбүрэнгийн 90МВт-ын усан цахилгаан станц", түүнийг дамжуулах ЦДАШ, "Их чадлын өөрийгөө цэнэглэх батарей хуримтлуулах" төслүүдийг тусгасан бол, Бүсчилсэн хөгжил бүлэгт: "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл", "Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл"-ийн II үе шат", "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр", "Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл" зэрэг өндөр ач холбогдолтой төслүүд багтсан байна.

Түүнчлэн, ногоон хөгжил бүлэгт дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн систем, гамшгийг сөрөн тэсвэрлэх чадварын төсөл, ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх зэрэг нийт 879.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Эдгээр төслийг хэрэгжүүлснээр уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, түүнд дасан зохицох болон даван туулах чадвар нэмэгдэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

## ЗАСАГЛАЛ

Орчин үеийн тогтворгүй геополитикийн орчин, гэнэтийн аюул гамшгийн эрсдэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авч, төрийн нэгдмэл, оновчтой засаглалыг хангахын тулд зэвсэгт хүчний техник, технологи болон батлан хамгаалахын чадавхыг бэхжүүлэх зайлшгүй шаардлага манай улсад тулгараад байна.

Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, ашиглалт, техникийн хадгалалтын чанарыг дээшлүүлэх, төрлийн цэргийн үүрэг гүйцэтгэх болон энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх, орчин үеийн зэвсэг, техник худалдан авах, үйлдвэрлэх зэрэг төсөл, арга хэмжээг нийт 1.63 их наяд төгрөгийн төсөвт өртгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он | Төсөвт өртөг (сая төгрөг) | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсөл хариуцагч яам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх | 2025-2028 | 406,000.00 | Бусад эх үүсвэр | БОУАӨЯ |
| 2 | Монгол Улсад гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл | 2027-2031 | 116,446.10 | Гадаад зээл | ШС (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн) |
| 3 | Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх төсөл | 2026-2031 | 230,760.00 | Гадаад зээл | ШС (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн) |
| 4 | Батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр-1 /БХЯ-ны арга хэмжээ/ | 2025-2030 | 1,627,210.00 | Улсын төсөв | БХЯ |

## 84. Ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам** | **2025** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Бусад эх үүсвэр** | **2028** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **406.0 тэрбум ₮** | 50.0 тэрбум ₮ | 118.7 тэрбум ₮ | 118.7 тэрбум ₮ | 118.7 тэрбум ₮ | - | - |

### Төслийн танилцуулга:

#### Төслийн хэрэгцээ шаардлага

- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зуд, усны нөөцийн хомсдол, цөлжилт болон байгаль орчны доройтол сүүлийн жилүүдэд манай улсад хурдацтай нэмэгдэж байна.
- Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нийт бүс нутгийн 8 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй байна.
- Ойн арчилгаа, хорт шавжийн устгал зэрэг ой хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны хүртээмж муу байгаагаас шалтгаалан 2030 он гэхэд ой хэмжээ буурах эрсдэлтэй байна.

#### Төслийн ач холбогдол:

- Ойгоор бүрхэгдсэн талбайг 9 хувьд хүргэснээр ойн сангийн хүлэмжийн хийг шингээх чадварыг нэмэгдүүлнэ.
- Ой хээрийн түймэр гарах эрсдэлийг бууруулж ойг зүй зохистой ашиглах тогтвортой менежментийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.
- Мод тарих, арчлан ургуулах дадал бүхий Монгол улсын иргэнийг төлөвшүүлэх, хүүхэд залууст экологийн боловсрол олгох

#### Төслийн зорилго, зорилт:

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн бууруулах, сааруулахад ой, усны нөөцийг хамгаалж, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах чиглэлээр иргэд аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, мод үржүүлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### Төслийн Хэрэгжилтийн явц:

- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хувь хүн, аж ахуйн нэгжүүд болон хариуцлагын гэрээ зэргээр дамжуулан 2025 оны эхний 9 сарын байдлаар 114.9 сая мод таригдаж гүйцэтгэл 7.31 хувьтай хэрэгжиж байна.
- Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааны ажлыг 16 аймгийн 137 сум, Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан Уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын ойн санг хамруулан 2.0 сая.га талбайд гүйцэтгэсэн.

### Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | - |

### Төслийн хүрэх үр дүн:

- Ойгоор бүрхэгдсэн талбайг 9 хувьд хүргэнэ.
- Ойн хөнөөлт шавжаас хамгаалсан ойн хэмжээг 2028 он хүртэл 630 мян.га талбайд хүргэнэ.
- Ойн түймрийн эрсдэлийг 5 хувиар бууруулна.
- Тарьсан модны амьдралтын хувийг 2030 он гэхэд 80 хувьд хүргэнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Доройтсон ойг нөхөн сэргээж, ойжуулалт, ой хамгааллын ажлын үр дүн, чанарыг сайжруулна.

# 85. Монгол Улсад гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Онцгой байдлын ерөнхий газар** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2031** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **114.8 тэрбум ₮** | - | 1.0 тэрбум ₮ | 22.7 тэрбум ₮ | 22.7 тэрбум ₮ | 22.7 тэрбум ₮ | 22.7 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсад “Газар хөдлөлтийн гамшгаас анхааруулах систем” төслийг 2013 онд Улаанбаатар хотод байгуулсан газар хөдлөлтөөс амжиж анхааруулах, зарлан мэдээллийн системийг нэвтрүүлсэн боловч өнөөдрийн байдлаар тоног төхөөрөмж хуучирсан, хамрах хүрээ хязгаартай, систем нь 2G технологид суурилсан байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан гамшгийн давтамж нэмэгдэж буй өнөө үед гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй гэж үзэж байна. Энэ нь гамшгаас амжиж анхааруулах, эрт зарлан мэдээлэх хугацааг удаашруулж, хүний амь нас, эдийн засгийн хохирлыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байна.
Иймээс “Гамшгийн аюулаас эрт зарлан мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

### Төслийн ач холбогдол:

Монгол Улсын хэмжээнд гамшгийн аюулаас эрт сэрэмжлүүлэх, зарлан мэдээллийн тогтолцоо бүрдэж, гамшгаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн болон Онцгой байдлын байгууллагын холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдал дээшлэх, гамшгийн улмаас үүсэх эрсдэл буурах, иргэд, аж ахуйн нэгжид учирч болзошгүй хохирол багасах, гамшиг, аюулт үзэгдэл, ослыг хохирол багатай даван туулах нөхцөл бүрдэнэ.

### Төслийн зорилго, зорилт:

Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийг улсын хэмжээнд байгуулах замаар гамшгийн бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж, гамшгийн улмаас учрах хохирлыг бууруулах зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:
1.Үндэсний хэмжээнд олон төрлийн аюулт үзэгдлийг хянах, эрт сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх чадавхыг бэхжүүлэх
2.Гамшгийн эрсдэлийн мониторингийн системийг хөгжүүлэх
3.Гамшгийн үеийн холбоо зохион байгуулалт, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Засгийн газрын 2023 оны 323/а дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-т туссан
- Азийн хөгжлийн банкны “Түншлэлийн стратегийн хүрээнд 2025-2028 онд хэрэгжүүлэх төсөл”-ийн жагсаалтад багтсан
- 2025 оны 09-р сарын 11-ны өдөр Азийн Хөгжлийн Банк болон Сангийн яам Зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурсан.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | ✓ |
| Зураг төсөл | ✓ |
| БОНБҮ | ✓ |
| Газрын зөвшөөрөл | ✓ |
| Дэд бүтэц | ✓ |
| Тусгай зөвшөөрөл | ✓ |
| Гэрээ | ✓ |

## Төслийн хүрэх үр дүн:

- Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүд бүх төрлийн гамшгийн аюулын сэрэмжлүүлгийг эрт хүлээн авах боломж бүрдэнэ;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ шинэ түвшинд гарна;
- Онцгой байдлын байгууллагын шуурхай удирдлагын төв, гамшгийн голомтод ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн, удирдлагыг холбоо зохион байгуулалт, бодит цагийн мэдээллээр хангаснаар шийдвэр гаргах үйл ажиллагаа шуурхай, үр дүнтэй болно. Онцгой байдлын байгууллагын техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал сайжирна;
- Гамшгийн улмаас нийгэм эдийн засагт учрах хохирол буурна;

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангана.

# 86. Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Онцгой байдлын ерөнхий газар** | **2026** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Гадаад зээл** /АХБ/ | **2031** | **Улсын хэмжээнд** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **359.0 тэрбум ₮** | - | - | 71.8 тэрбум ₮ | 71.8 тэрбум ₮ | 71.8 тэрбум ₮ | 71.8 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол орны газар зүйн байршил, эмзэг экосистем, байгаль цаг агаараас хараат эдийн засгийн тогтолцоо, түүнчлэн байгалийн нөөцийн хомсдол, бэлчээр, газрын доройтол, хотжилт, төлөвлөлтгүй хот байгуулалт, хүн амын хэт бөөгнөрөл, ажилгүйдэл, ядуурал зэрэг улс орны дотоод нөхцөлөөс болж гамшгийн эрсдэл улам бүр нэмэгдэж, илүү нарийн төвөгтэй, нийлмэл шинж чанартай, олон хэмжээст болж байгаа нь Монгол Улсын гамшигтай тэмцэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлын чадавхыг шинэ шатанд гаргах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

### Төслийн ач холбогдол:

Тус төсөл хэрэгжсэнээр байгууллагын техник, тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж, аврагч, гал сөнөөгчдийн үүргээ гүйцэтгэх баталгаа дээшилж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэж, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, мал амьтанд учирч болох хохирлыг бууруулах төдийгүй Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх онцгой ач холбогдолтой.

### Төслийн зорилго, зорилт:

Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын гал түймэр, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг сайжруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлж, гамшигийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:
1.Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
2.Эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд ашиглагдах машин, механизм, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх
3. Орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- АХБ-тай "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг эцэслэн 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн
- 2025 оны 09 дугаар сарын 01-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.
- 2025 09 дугаар сарын 29-ны өдөр болон 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэн дэмжигдсэн
- 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын хамтарсан хороогоор хэлэлцэж дэмжсэн
- Байнгын хорооны санал, дүгнэлт, Засгийн газрын шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайдын захирамж 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гарсан бөгөөд зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурахад бэлэн болоод байна

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗҮС | ✓ |
| ТЭЗҮ | X |
| Зураг төсөл | X |
| БОНБҮ | X |
| Газрын зөвшөөрөл | X |
| Дэд бүтэц | X |
| Тусгай зөвшөөрөл | X |
| Гэрээ | X |

## Төслийн хүрэх үр дүн:

- Ой, хээрийн гал түймэр унтраах зориулалтын автомашин, техник, багаж хэрэгслийн хүчин чадал сайжирч, эрсдэл өндөртэй бүсэд ажилладаг эрэн хайх, аврах нэгжийн хангалт 90 хувьд хүрнэ.
- Гал түймрийн голомтод түргэн шуурхай хүрч ажиллах чадамж нэмэгдэн, гал түймрийг хохирол багатай, богино хугацаанд унтраах боломж бүрдэнэ.
- Үер, усны аюул, уул уурхай, цацраг, химийн болон тэсэрч дэлбэрэх ослын үед эрэн хайх, аврах, сэргээн босгох техник, тоног төхөөрөмж, хувцас, багаж хэрэгслийн хангалт нэмэгдэж, чадавх бэхжинэ.
- Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынхныг сургаж бэлтгэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоо нэмэгдэж, орон нутгийн бэлэн байдал, сөрөн тэсвэрлэх чадвар дээшилнэ.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангана.

# 87. Батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр-1

| Төслийн төлөвлөлтийн шатанд | ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд | Хэрэгжилтийн шатанд | Ашиглалтад орсон |
|---|---|---|---|

| Хариуцагч: | Эхлэх огноо: | Бүс: |
|---|---|---|
| **Батлан хамгаалах яам** | **2025** | **Улсын хэмжээнд** |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Дуусах огноо: | Аймаг/хот: |
| **Улсын төсөв** | **2030** | **-** |

| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | Санхүүжилтийн гүйцэтгэл: | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|
| **1,627.2 тэрбум ₮** | 24.6 тэрбум ₮ | 186.22 тэрбум ₮ | 212.98 тэрбум ₮ | 212.98 тэрбум ₮ | 495.21 тэрбум ₮ | 495.21 тэрбум ₮ |

## Төслийн танилцуулга:

### Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улсын батлан хамгаалах салбарын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчний нөөц хязгаарлагдмал байгаа нь орчин үеийн тогтворгүй геополитикийн асуудал, гэнэтийн аюул гамшгийн эрсдэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг хязгаарлаж байгаа тул зэвсэгт хүчний техник технологи, батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болоод байна.

### Төслийн ач холбогдол:

Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, ашиглалт, техникийн хадгалалтын чанарыг дээшлүүлэх, төрлийн цэргийн үүрэг гүйцэтгэх болон энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх, орчин үеийн зэвсэг, техник худалдан авах, үйлдвэрлэх замаар МУ-ын зэвсэгт хүчний улс орноо батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ биелүүлэх чадавхыг нэмэгдүүлснээр МУ-ын Батлан хамгаалах салбарын чадавх бэхжих юм.

### Төслийн зорилго, зорилт:

Багц төслийн хүрээнд дараах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр оруулсан.

- Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;
- Нисгэгчгүй нисэх төхөөрөмж дрон, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт техник, хэрэгслийг худалдан авах, дотооддоо зохион бүтээх;
- Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлыг хангах “Дата төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх;
- Аэродромын хөөрөх, буух зурвасыг сэргээн сайжруулах;
- Сумны үйлдвэрлэлийг эхлүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлэх.

## Төслийн Хэрэгжилтийн явц:

- Нисгэгчгүй нисэх төхөөрөмж дрон, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт техник, хэрэгслийг худалдан авах, дотооддоо зохион бүтээж, турших төсөл хэрэгжиж эхэлсэн.
- Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлыг хангах “Дата төв”-ийг байгуулсан.
- Аэродромын хөөрөх, буух зурвасыг сэргээн сайжруулах зорилгоор ажлын зураг, төсвийг боловсруулсан.

## Төслийн бэлэн байдал:

| | |
|---|---|
| Урьдчилсан судалгаа, ТЭЗУС | - |
| ТЭЗҮ | - |
| Зураг төсөл | - |
| БОНБҮ | - |
| Газрын зөвшөөрөл | - |
| Дэд бүтэц | - |
| Санхүүжилт | - |
| Гэрээ | - |

## Төслийн хүрэх үр дүн:

- Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавх нэмэгдсэн байна.
- Орон нутгийн хамгаалалт, Улсын дайчилгааны чадавхыг бэхжүүлнэ.
- Төрлийн цэргийг бэхжүүлж, энхийг дэмжих ажиллагааны үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.
- Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг бэхжүүлнэ.

Хүрэх үр дүнгийн тоон үзүүлэлтүүд Төрийн болон албан нууцын тухай хууль, холбогдох журмын дагуу маш нууцад хамаарна.

Үндсэн чиглэлийн үр дүн:

- Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.

# САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

# Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Монгол Улсын 2026–2036 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төслүүд нь техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төслийн бэлэн байдлыг хангасан, ойрын хугацаанд хэрэгжүүлэх боломжтой төслүүд юм. Эдгээрт нийт 72 төсөл, арга хэмжээ багтаж байгаа бөгөөд боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, ногоон хөгжил, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, дэд бүтэц, бүсчилсэн хөгжил, засаглалын салбарыг хамарч, эдийн засгийн бүтцийн шинэчлэл, эрчим хүчний аюулгүй байдал, дэд бүтцийн холболт, төрийн чадавх, инновацийн чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт хэрэгжих “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хоёрдугаар шат, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”, “Судалгааны их сургуулийг хөгжүүлэх”, “Хангайн бүсийн АШУҮИС-ийн цогцолбор” зэрэг төслүүд нь өндөр мэдлэг, ур чадвартай хүний нөөц бэлтгэх, эрүүл мэндийн тусламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ногоон хөгжлийн хүрээнд “Орхон–Онги”, “Хэрлэн–Тооно” усан сангийн төсөл, “Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрүүд ба цахилгаан тээврийн дэд бүтцийн багц төсөл” зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, усны нөөцийн хомсдолыг шийдвэрлэх, сэргээгдэх эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлэх, ногоон дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулна.

Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтэй холбоотой томоохон төслүүд болох Дарханы гангийн цогцолбор, Өмнөговийн “Кокс-эрчим хүчний үйлдвэр”, Багануурын “Нүүрс-химийн үйлдвэр”, Бор-Өндөрийн жонш баяжуулах үйлдвэр, “Багануур” технологийн паркийн дэд бүтэц зэрэг нь боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхайн түүхий эдийг дотооддоо гүн боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын бүтцийг төрөлжүүлнэ.

Дэд бүтэц, тээврийн салбарт “Чойбалсан–Бичигт төмөр зам”, “Дархан–Алтанбулаг 4 эгнээ авто зам”, “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”, “Замын-Үүд чөлөөт бүсийн II үе шат”, “Бургастай, Шивээхүрэн, Ханги” боомтын өргөтгөл зэрэг төслүүд нь экспорт, импортын урсгалыг нэмэгдүүлж, бүс нутгийн худалдаа, ложистикийн нэвтрэх чадварыг сайжруулах стратегийн ач холбогдолтой юм.

Эрчим хүчний шинэчлэлийн хүрээнд “Дулааны III, IV цахилгаан станцын өргөтгөл”, “Бөөрөлжүүтийн цахилгаан станцын II шат”, “Төвийн бүсийн 300 МВт ус хуримтлуурт УЦС”, “Багануур–Чингис–Чойбалсан 220 кВ ЦДАШ”, “Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийн багц” зэрэг төслүүд хэрэгжсэнээр төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагаа нэмэгдэж, импортын хамаарал буурч, сэргээгдэх эх үүсвэрийн хэрэглээ нэмэгдэнэ. Мөн “Монгол Улсын ухаалаг эрчим хүчний систем”, “Байдрагийн УЦС”, “Цагаансуваргын 220 кВ ЦДАШ”, “Багануурын дулаан хангамжийн шинэ эх үүсвэр” зэрэг төслүүд эрчим хүчний системийн горим тохиргоо, аюулгүй байдлыг хангах чухал ач холбогдолтой.

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд “Улаанбаатар–Лүн”, “Улиастай–Мөрөн” авто зам, “Чингис хаан”, “Мөрөн”, “Ховд”, “Гурвансайхан”, “Чойбалсан” нисэх буудлуудын өргөтгөл, “Метро”, “Хөнгөн галт тэрэг (Трамвай)”, “Тусгай замын автобус (BRT)” зэрэг төслүүд нь нийслэл болон орон нутгийн дэд бүтцийн ачааллыг бууруулж, зорчигч тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлал, бүс нутгийн эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд чиглэнэ.

Үүнээс гадна “Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл”, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хоёр үе шаттай зээлийн төсөл”, “Хүннү хотын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”, “Сумдын төвийн инженерийн шугам, сүлжээ, тохижилтын ажил” зэрэг төсөл нь хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжиж, нийгмийн суурь дэд бүтцийг бэхжүүлэхэд чиглэнэ.

Мөн төрийн чадавх, аюулгүй байдлын салбарт “Үндэсний хиймэл дагуулын хөтөлбөр”, “Цагдаагийн байгууллагын холбооны шинэчлэл”, “Батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр-II”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шинэчлэл” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх нь төрийн үйлчилгээний шуурхай байдал, дижитал шилжилт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой юм.

# Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Эдгээр төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлснээр Монгол Улсын 2026–2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гол зорилт болох эдийн засгийн төрөлжилт, эрчим хүчний аюулгүй байдал, дэд бүтцийн холболт, нийгмийн үйлчилгээний чанар, төрийн институцийн чадавх бодитоор бэхжиж, бүс, орон нутгийн тэнцвэрт байдлыг хангах урт хугацааны суурь нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 4. Төслийн тоо, хариуцагч байгууллагаар

| Хариуцагч | Төслийн тоо | Төсөвт өртөг /сая төг/ |
|---|---|---|
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам | 6 | 7,535,468.0 |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам | 4 | 4,338,830.7 |
| Батлан хамгаалах | 1 | 2,795,054.0 |
| Боловсролын яам | 6 | 7,632,180.0 |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 1 | 90,000.0 |
| Зам, тээврийн яам | 15 | 16,006,443.9 |
| НЗДТГ | 5 | 11,956,944.0 |
| Сангийн яам | 4 | 310,419.2 |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт | 3 | 502,926.9 |
| Хууль зүй, дотоод хэргийн яам | 2 | 1,804,354.5 |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 2 | 521,133.0 |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам | 1 | 760,000.0 |
| Шадар сайд | 2 | 309,528.0 |
| Эдийн засаг, хөгжлийн яам | 2 | 1,427,921.1 |
| Эрчим хүчний яам | 18 | 9,435,832.2 |
| **Дүн** | **72** | **65,427,035.48** |

Хүснэгт 5. Төслийн тоо, бүлгээр

| | Бүлгийн нэр | Төслийн тоо | Төсөв | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан | 7 | 7.72 их наяд ₮ | 11.8% |
| 2 | Эдийн засгийн бүтцийн шинэчлэл | 18 | 18.51 их наяд ₮ | 28.3% |
| 3 | Эрчим хүчний шинэчлэл | 20 | 12.12 их наяд ₮ | 18.5% |
| 4 | Бүсчилсэн хөгжил | 18 | 16.17 их наяд ₮ | 24.7% |
| 5 | Ногоон хөгжил | 5 | 5.53 их наяд ₮ | 8.5% |
| 6 | Засаглал | 4 | 5.35 их наяд ₮ | 8.2% |
| | Дүн | 72 | 65.42 их наяд ₮ | 100% |

# ХҮНИЙ ХӨГЖИЛ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Санхүүжилтийн хугацаа /оноор/ | Төсөвт өртөг /сая төг/ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Инженер, технологийн дээд боловсрол" төсөл 2-р үе шат | Улсын хэмжээнд | 2027-2036 | 220,680.0 | БЯ |
| 2 | Хангайн бүсийн АШУҮИС-ийн сувилахуйн сургалт, эрдэм-шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогцолбор /Архангай аймаг, Эрдэнэбулган сум/ | Архангай | 2027-2032 | 54,000.0 | БЯ |
| 3 | "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" /Орхон, Ховд, Өмнөговь, Дорнод, Дархан-Уул, Хөшигийн хөндий/ | Дархан-Уул, Ховд | 2028-2034 | 6,967,700.0 | БЯ |
| 4 | Сум дундын төрөлжсөн ахлах сургууль /Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд нийт 6 бүсийн орон нутгийн хөгжлийн төв тус бүрд нэг төсөл/ | Улсын хэмжээнд | 2027-2030 | 210,000.0 | БЯ |
| 5 | Чадварлаг ажиллах хүчээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах төсөл /мэргэжлийн болон техникийн боловсрол/ | Дархан, Сэлэнгэ | 2027-2031 | 71,920.0 | БЯ |
| 6 | Судалгааны их сургуулийг хөгжүүлэх төсөл | Улсын хэмжээнд | 2027-2031 | 107,880.0 | БЯ |
| 7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг үе шаттайгаар шаардлагатай аймаг, дүүрэгт байгуулах төсөл | Улсын хэмжээнд | 2027-2030 | 90,000.0 | ГБХНХЯ |

# НОГООН ХӨГЖИЛ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Санхүүжилтийн хугацаа /оноор/ | Төсөвт өртөг /сая төг/ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрүүд болон цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтцийн багц төсөл | Улсын хэмжээнд | 2027-2030 | 1,200,000.0 | ЭЗХЯ |
| 2 | Орхон-Онги усан сан, ус дамжуулах хоолой / 1-р үе шат Онги-Цагаан бургастай төсөл / | Өвөрхангай, Өмнөговь | 2026-2031 | 309,500.0 | БОАӨЖЯ |
| 3 | “Орхон-Онги” төслийн хүрээнд “Улаан нуур – Даланзадгад – Тавантолгой” чиглэлийн ус дамжуулах хоолой | Өвөрхангай, Өмнөговь | 2027-2031 | 1,382,130.7 | БОАӨЖЯ |
| 4 | Хэрлэн-Тооно усан сан, ус дамжуулах хоолой | Хэнтий, Дорноговь | 2027-2031 | 1,600,000.0 | БОАӨЖЯ |
| 5 | Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах төсөл | Төв | 2027-2029 | 1,047,200.0 | БОАӨЖЯ |

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Санхүүжилтийн хугацаа | Төсөвт өртөг /сая төг/ | ТЕЗ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гангийн үйлдвэрийн цогцолбор /Дархан/ | Дархан-Уул | 2027-2032 | 2,217,259.8 | АҮЭБЯ |
| 2 | Кокс- Эрчим хүчний үйлдвэр /Тавантолгой/ | Өмнөговь | 2027-2030 | 1,535,700.0 | АҮЭБЯ |
| 3 | Нүүрс-Пиролизын үйлдвэр /Багануур/ | Багануур дүүрэг | 2027-2029 | 338,100.0 | АҮЭБЯ |
| 4 | Жонш баяжуулах үйлдвэр /Бор-Өндөр/ | Хэнтий | 2027-2029 | 35,000.0 | АҮЭБЯ |
| 5 | Шатахууны нөөцийг хадгалах сав барих төсөл /Улсын хэмжээнд 13 байршил/ | Улсын хэмжээнд | 2027-2032 | 3,200,000.0 | АҮЭБЯ |
| 6 | "Багануур" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц | Багануур дүүрэг | 2027-2031 | 209,408.2 | АҮЭБЯ |
| 7 | Бичигт-Зүүнхатавч хил дамнасан холболтын төмөр зам | Дорнод | 2027-2029 | 174,750.0 | ЗТЯ |
| 8 | Хилийн "Ханги" боомтын цогцолборын бүтээн байгуулалт | Дорноговь | 2027-2028 | 45,000.0 | СЯ |
| 9 | Хилийн "Шивээхүрэн" боомтын цогцолборын бүтээн байгуулалт | Өмнөговь | 2027-2028 | 37,300.0 | СЯ |
| 10 | Хилийн "Бургастай" боомтын өргөтгөл, шинэчлэл | Говь-Алтай | 2027-2029 | 46,119.2 | СЯ |
| 11 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын "Дуньзян" боомтод олон улсын тээвэр, логистикийн төв | БНХАУ | 2026-2029 | 76,007.0 | ЗТЯ |
| 12 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2 дугаар ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалт | Дорноговь | 2027-2029 | 182,000.0 | СЯ |
| 13 | Алтанбулаг чөлөөт бүсийн инженерийн бүтээн байгуулалт | Сэлэнгэ | 2027-2030 | 109,528.0 | ШС |
| 14 | Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн эхний үе шатны дэд бүтэц, зам тээвэр, логистикийн бүтээн байгуулалт | Төв | 2027-2029 | 200,000.0 | ШС |
| 15 | Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгох өргөтгөл, шинэчлэл | Дархан, Сэлэнгэ | 2026-2028 | 630,587.5 | ЗТЯ |
| 16 | Хөшигийн хөндий-Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам | Улаанбаатар, Говьсүмбэр, Дорноговь | 2026-2028 | 1,550,000.0 | ЗТЯ |
| 17 | Алтай-Бургастай боомт чиглэлийн 280 км хатуу хучилттай авто зам | Говь-Алтай | 2027-2029 | 455,000.0 | ЗТЯ |
| 18 | Чойбалсан-Хөөт-Бичигт боомт чиглэлийн 426 км төмөр зам | Дорнод, Сүхбаатар | 2028-2032 | 7,471,600.0 | ЗТЯ |

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Хугацаа | Төсөвт өртөг /сая төг/ | ТЕЗ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэл | Улаанбаатар | 2027-2031 | 3,234,049.2 | ЭХЯ |
| 2 | Дулааны IV цахилгаан станцыг нэг зуухаар өргөтгөх | Улаанбаатар | 2026-2028 | 319,837.6 | ЭХЯ |
| 3 | Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах 300 МВт-ын ус хуримтлуурт усан цахилгаан станц | Сэлэнгэ | 2027-2030 | 1,019,147.8 | ЭХЯ |
| 4 | Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станц | Төв, Хэнтий | 2026-2029 | 650,628.0 | ЭХЯ |
| 5 | Бөөрөлжүүтийн цахилгаан станцын хоёрдугаар үе шатны 300 МВт-ын станцын төсөл | Төв | 2026-2028 | 1,968,657.9 | НЗДТГ |
| 6 | Монгол Улсын Эрчим хүчний хүчний ухаалаг систем төсөл | Улаанбаатар | 2027-2029 | 359,337.0 | ЭХЯ |
| 7 | Байдрагийн 30 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц | Баянхонгор | 2026-2029 | 126,562.1 | ЭХЯ |
| 8 | 110/10 кВ-ын 2х63 МВА чадалтай "Парк" дэд станц, 110 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл | Улаанбаатар | 2026-2028 | 70,539.0 | ЭХЯ |
| 9 | Сайншанд-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 204.6 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, "Цагаансуварга" дэд станцыг өргөтгөх төсөл | Дорноговь | 2027-2029 | 98,389.2 | ЭХЯ |
| 10 | Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ | Өмнөговь | 2027-2029 | 91,675.5 | ЭХЯ |
| 11 | Багануур-Налайх-Улаанбаатар чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 114.13 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын "Улаанбаатар" дэд станцын өргөтгөл | Багануур, Налайх дүүрэг | 2026-2028 | 167,800.0 | ЭХЯ |
| 12 | Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах тархмал дулааны эх үүсвэрийг барих | Улаанбаатар | 2027-2030 | 183,601.0 | ЭХЯ |
| 13 | Багануур-Чингис чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 202 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын “Чингис” дэд станц | Багануур дүүрэг, Хэнтий | 2027-2029 | 159,966.0 | ЭХЯ |
| 14 | Чингис-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 312 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын “Чойбалсан” дэд станц | Хэнтий, Дорнод | 2027-2029 | 215,815.3 | ЭХЯ |
| 15 | Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станц | Ховд, Завхан | 2028-2030 | 503,160.0 | ЭХЯ |
| 16 | Улаанбаатар-Дархан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцын өргөтгөл | Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Улаанбаатар | 2027-2030 | 121,654.5 | ЭХЯ |
| 17 | Багануур дүүргийн дулаан хангамжийн шинэ эх үүсвэр | Багануур | 2026-2028 | 157,970.0 | ЭХЯ |
| 18 | Дархан хотын дулаан хангамжийн хоёрдогч эх үүсвэр | Дархан-Уул | 2026-2030 | 254,200.0 | ЭХЯ |
| 19 | Морингийн давааний хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэр (35МВт) | Улаанбаатар | 2026-2029 | 715,977.0 | НЗДТГ |
| 20 | Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр /6 аймагт нийт 115 МВт нар болон 88 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурын станц/ | Нийт 7 аймаг | 2026-2030 | 1,701,500.0 | ЭХЯ |

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Хугацаа | Төсөвт өртөг /сая төг/ | ТЕЗ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км 6 эгнээ хатуу хучилттай авто зам | Улаанбаатар, Төв | 2026-2028 | 1,052,033.6 | ЗТЯ |
| 2 | Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх /Төв, Лүн сум/ | Төв | 2026-2028 | 52,002.0 | ЗТЯ |
| 3 | Улиастай-Мөрөн чиглэлийн 261.65 км авто зам | Завхан, Хөвсгөл | 2027-2028 | 552,000.0 | ЗТЯ |
| 4 | "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг өргөтгөж, "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн нисэхийн сургалтын төв | Төв | 2026-2031 | 3,600,000.0 | ЗТЯ |
| 5 | Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг өргөтгөж, олон улсын статустай болгох | Ховд | 2026-2029 | 69,871.4 | ЗТЯ |
| 6 | Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлыг өргөтгөж, олон улсын статустай болгох | Хөвсгөл | 2026-2029 | 23,752.0 | ЗТЯ |
| 7 | Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг өргөтгөж, олон улсын статустай болгох | Дорнод | 2026-2029 | 97,523.8 | ЗТЯ |
| 8 | Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлыг өргөтгөж, олон улсын статустай болгох | Өмнөговь | 2026-2029 | 171,316.6 | ЗТЯ |
| 9 | Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх төсөл | Улсын хэмжээнд | 2027-2028 | 30,000.0 | ЗТЯ |
| 10 | Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро төсөл | Улаанбаатар | 2027-2032 | 8,174,309.1 | НЗДТГ |
| 11 | Улаанбаатар хотын Хөнгөн галт тэрэг (Трамвай шугам) | Улаанбаатар | 2026-2032 | 690,000.0 | НЗДТГ |
| 12 | Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл төсөл | Улаанбаатар | 2026-2028 | 161,789.0 | ХХААХҮЯ |
| 13 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах Хоёр-үе шаттай зээлийн төсөл | Улсын хэмжээнд | 2027-2031 | 359,344.0 | ХХААХҮЯ |
| 14 | Дундговь аймагт орон нутгийн нөөцөд тулгуурласан археологи, палентлогийн судалгаа, аялал, жуулчлалын цогцолбор | Дундговь | 2027-2030 | 227,921.1 | ЭЗХЯ |
| 15 | Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төсөл | Улаанбаатар | 2026-2028 | 408,000.0 | НЗДТГ |
| 16 | Бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл | Ховд, Баянхонгор, Сэлэнгэ | 2027-2030 | 75,700.0 | ХББОСЯ |
| 17 | Сумдын төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилтын ажил | Ховд, Төв | 2027-2030 | 44,947.1 | ХББОСЯ |
| 18 | "Хүннү хотын ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төсөл" | Төв | 2027-2030 | 382,279.8 | ХББОСЯ |

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | Хугацаа | Төсөвт өртөг /сая төг/ | ТЕЗ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний хиймэл дагуулыг үйлдвэрлэх, хөөргөх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх төсөл | Улсын хэмжээнд | 2028-2033 | 760,000.0 | ЦХИХХЯ |
| 2 | Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл | Улсын хэмжээнд | 2026-2030 | 1,750,000.0 | ХЗДХЯ |
| 3 | ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, албадан эмчлүүлэх байр | Улаанбаатар | 2026-2029 | 54,354.5 | ХЗДХЯ |
| 4 | Батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр-2 /БХЯ-ны арга хэмжээ/ | Улсын хэмжээнд | 2026-2030 | 2,795,054.0 | БХЯ |

# ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

# Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Эдгээр төслүүдийн холбогдох техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон зураг төсөв хараахан хийгдээгүй тул “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах аргачлалын Ач холбогдол” хэсгийн шалгуур, үнэлэх аргачлалын дагуу урьдчилсан үнэлгээг хийсэн болно. Үнэлгээ нь хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэл, нийгмийн ач холбогдол, эдийн засагт үзүүлэх нөлөө, байгаль орчны үр нөлөөг хамарч, нийт 4 үндсэн дэд шалгуураар хийгдсэн.Иймд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд 29 төслийн ТЭЗҮ, зураг төсөл, судалгаа, мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг 2026–2030 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд эдгээр нь дараах үндсэн зорилго, ач холбогдолтой болно.

**Эдийн засгийн бүтцийн шинэчлэл бүхий боловсруулах үйлдвэрүүд.**

- Тавантолгой ҮТП

Тавантолгойн ҮТП нь жилд 30 сая тонн нүүрс баяжуулах, түүнээс 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд кокс-эрчим хүчний болон нүүрс-химийн цогцолборуудыг байгуулснаар дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн төрөлжүүлэх суурь бүрдэнэ.

Кокс-эрчим хүчний үйлдвэрээс гарах хатуу коксыг гангийн үйлдвэрт нийлүүлж, эрчим хүч үйлдвэрлэлд ашигласнаар Өмнөговь бүсийн эрчим хүчний найдвартай байдлыг хангах, нүүрс-химийн үйлдвэрээр дамжуулан метанол, бордоо, шингэн түлш зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

- Багануур ҮТП

Багануурын ҮТП нь нүүрс-химийн үйлдвэрлэл дээр төвлөрөх бөгөөд эхний шатанд 0.5 сая тонн нүүрсийг хийжүүлэх, нийлэгжүүлэх аргаар метанол, нийлэг хий, диметил эфир зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, импорт орлох химийн үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.
Хоёрдугаар шатанд нүүрснээс метанол суурьтай полипропилен (PP), автобензин болон химийн үндсэн элементүүд үйлдвэрлэж, хуванцар, барилгын материал, сав баглаа боодлын үйлдвэрүүдэд дотоодын түүхий эд нийлүүлнэ.

- Дархан ҮТП

Дархан-Уул аймагт хэрэгжих тус парк нь металлургийн үйлдвэрлэл, ган боловсруулах, төмөрлөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой бөгөөд Төмөртэйн төмрийн хүдрийн стратегийн ордыг түшиглэн эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, дотоодын арматурын хэрэгцээг бүрэн хангах хүчин чадалтай.

Тус парк нь “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн одоо байгаа дэд бүтэц, боловсон хүчний нөөцөд тулгуурлан хөгжих ба гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хүнд үйлдвэрлэлийн нэгдсэн гинжин хэлхээ бий болгох зорилготой.
Үр дүнд нь металлургийн салбарын технологийн шинэчлэл хийгдэж, дотоодын барилгын материалын хангамж сайжирч, орон нутгийн эдийн засагт бодит өсөлт авчирна.

# Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

- Үндэсний алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл

Монгол Улсад алтны олборлолт нэмэгдэж буй ч боловсруулалт гадаадад хийгдэж, нэмүү өртгийн дийлэнх нь гадагш алдагдаж байна. Төслийг хэрэгжүүлснээр дотооддоо сорьц тогтоох, стандартын шаардлагад нийцсэн үнэт метал гаргах, гадаад валютын орлого нэмэгдэнэ.

- Химийн бордооны үйлдвэрийн төсөл

Монгол Улсын газар тариалангийн салбарт жил бүр бордооны хэрэгцээний 90 гаруй хувийг импортоор хангаж байгаа тул дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай. Тус үйлдвэрийг ашиглалтад оруулснаар импортын хамаарлыг бууруулах, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах, валютын гадагшлах урсгалыг хязгаарлах ач холбогдолтой. Мөн нүүрс-химийн үйлдвэрлэлээс гарах дэд бүтээгдэхүүнүүдийг ашиглан нэгдсэн үйлдвэрлэлийн гинжин хэлхээ бий болно.

- Геологийн зураглал, эрэл хайгуулын төсөл

Сүүлийн 20 жилийн хугацаанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 10 дахин, 10 жилийн хугацаанд 2 дахин буураад байна.

Геологи хайгуул, судалгааны ажил явуулах талбайн хэмжээ буурсантай холбоотойгоор аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт оруулах хөрөнгө оруулалт буурч экспортыг бүрдүүлэгч уул уурхайн салбарыг тасралтгүй ажиллах нөхцөлөөр хангах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн салбарыг нөөцөөр дутаах эрсдэл үүсэхээр байна. Тиймээс эрэл хайгуулын ажлыг цаг алдалгүй хийж ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

**Эрчим хүч**

- “Эгийн голын усан цахилгаан станц”, “Өндөр түрэлтийн ус хуримтлуурт станц”, “Аймгийн төвүүдийн дулаан хангамжид сэргээгдэх эрчим хүч ашиглах” зэрэг төслүүд нь эрчим хүчний хангамжийг тогтвортой болгох, сэргээгдэх эх үүсвэрийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой.
- “Улаанбаатар–Шинэ Хархорум” Энэхүү 500 кВ-ын цахилгаан дамжуулах шугам нь төвийн болон баруун бүсийн эрчим хүчний системийг нэгтгэж систем хоорондын цахилгаан эрчим хүчний урсгал, нөөцийн хуваарилалтыг оновчтой болгон эрчим хүчний найдвартай байдлыг 30–40 хувиар нэмэгдүүлж, импортын эрчим хүчний хэрэглээ 40 орчим хувиар буурна.

**Тээвэр, ложистикийн дэд бүтэц**

- “Замын-Үүд” бүс нутгийн логистикийн төв, “Улаанбаатар–Шинэ Хархорум” чиглэлийн төмөр зам, нисэх буудал, шинэ тойрог зам зэрэг төслүүд нь бүс нутгийн холболт, ложистикийн урсгал, тээвэрлэлтийн үр ашиг нэмэгдэнэ.
- “Хөшигийн хөндийн нэгдсэн логистикийн төв”, “Сайншандын нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв” зэрэг дэд бүтцийн зураг төсөл боловсруулагдсанаар олон улсын стандарт бүхий тээвэр, агаарын хөдөлгөөний зохицуулалтын шинэ систем бүрдэнэ.

**Ногоон хөгжил, байгаль орчин**

- “Хос тэжээлт автомашины зай хураагуур дахин боловсруулах үйлдвэр”, “Аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр” зэрэг төслүүд нь хог хаягдлын менежмент, ногоон эдийн засгийн шилжилтийг дэмжих ач холбогдолтой.
- “Туул усан цогцолбор”, “Морингийн давааны цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”, “Сумдын ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл” зэрэг нь ус, ариутгах татуургын нөөц, дэд бүтцийг сайжруулах, орчны бохирдлыг бууруулана.

**Хот байгуулалт ба орон нутгийн хөгжил**

- “Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Сумдын төвийн ногоон хөгжлийн дэд бүтэц сайжруулах”, “Ус хангамж, нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөө” зэрэг төслүүд нь төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийн шинэ загварыг төлөвлөх ач холбогдолтой.
- Эдгээр төслүүд нь орон нутгийн дэд бүтцийн суурь мэдээлэл, төлөвлөлтийн үндэслэл болох бөгөөд ирээдүйн хөрөнгө оруулалтын төслүүдийн чанар, хэрэгжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

# Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Тайлбар | Хариуцагч |
|---|---|---|---|
| 13 | Шинжлэх ухааны парк байгуулах | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | ЭЗХЯ |
| 14 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн лагийг хатаах, шатаах байгууламж /БОУАӨЯ/ | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | НЗДТГ |
| 15 | "Шинэ Хархорум" хотын инженер хайгуулын судалгаа хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах | Судалгаа, ерөнхий төлөвлөгөө | ХББОСЯ |
| 16 | Монгол Улсын гамшгаас хамгаалах нэгдсэн шуурхай удирдлагын штабын байр | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | ШС |
| 17 | Уул уурхайн ордыг түшиглэсэн химийн бордооны үйлдвэр | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | ХХААХҮЯ |
| 18 | Булган аймагт Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц | ТЭЗҮ, БОННҮ боловсруулах | ЭХЯ |
| 19 | Хос тэжээлт автомашины зай хураагуурыг дахин боловсруулах, сэргээх, устгах үйлдвэр /БОУАӨЯ/ | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | БОУАӨЯ |
| 20 | Автомашинаас үүссэн аюултай хог хаягдлыг (шингэн болон хатуу) дахин боловсруулах үйлдвэр /БОУАӨЯ/ | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | БОУАӨЯ |
| 21 | Улаанбаатар – Шинэ ХарХорум чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл | ТЭЗҮ, БОННҮ, зураг төсөл боловсруулах | ЭХЯ |
| 22 | Аймгийн төвүүдийн дулаан хангамжид сэргээгдэх эрчим хүч /Нар, салхи, гүний дулаан/ ашиглах | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | ЭХЯ |
| 23 | Өндөр түрэлтийн ус хуримтлуурт усан цахилгаан станц | ТЭЗҮ боловсруулах | ЭХЯ |
| 24 | "Туул усан цогцолбор төсөл" | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | НЗДТГ |
| 25 | Шинэ тойрог зам төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто зам | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | НЗДТГ |
| 26 | Морингийн давааны цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | НЗДТГ |
| 27 | Сумдын ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | ХББОСЯ |
| 28 | Сумын төвийн ногоон хөгжлийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах төсөл | ТЭЗҮ боловсруулах | ХББОСЯ |
| 29 | Ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөө | Мастер төлөвлөгөө | ХББОСЯ |

